



**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ  
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ  
ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН  
ТАЙЛАН**

**2022 ОН**

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2022 оны 07 дугаар сарын 05

Улаанбаатар хот

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”**

Монгол Улсын Их хурлын 2016 оны 19 дүгээр тогтоол “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Хууль зүйн сайдын 2014 оны А/125 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2019 оны 36 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086, 2014 оны А/279, А/1146, 2017 оны А/252, 2019 оны А/01, 2022 оны А/01 оны дүгээр захирамжийн хэрэгжилт, дүүргийн Засаг даргын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-үүдийг хангах ажлын хүрээнд үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаж байна.

Дэвшүүлсэн зорилтуудын хүрээнд нутгийн захиргааны байгууллагаас нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, хувь хүний хөгжлийг эрхэмлэж, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн ажилтай, орлоготой, эрүүл чийрэг, эрдэм боловсролтой иргэнийг төлөвшүүлэн, эрүүл, аюулгүй амьдралын баталгааг ханган амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тогтвортой хөгжлийн үзэл, баримтлалд суурилсан дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг 6 бүлэг, 16 зорилт, 179 арга хэмжээтэйгээр дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор баталсан. Үүнд:

- “Ковид-19” Цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого
- Хүний хөгжлийн бодлого
- Эдийн засгийн бодлого
- Засаглалын бодлого
- Ногоон хөгжлийн бодлого
- Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого...

үндсэн 6 бүлэгт хамруулсан хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Бодлогын баримт бичиг, хөтөлбөр, тогтоол, захирамж, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн албыг чадавхжуулан, төрийн үйлчилгээг, иргэдэд чирэгдэлгүй, чанартай шуурхай, ил тод, нээлттэй хүргэн, нийгмийн салбаруудыг дэмжиж, иргэдийнхээ амьдрах нөхцөлийг сайжруулан ажиллалаа.

Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийн 2022 онд хэрэгжүүлэх 176 арга хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу үнэлсэн бөгөөд 2022 оны 1 дүгээр улирлын биелэлт 42,8%, хагас жилийн биелэлтийг 60,78% -иар хэрэгжүүлэн ажилласан байна.

Чингэлтэй дүүрэгт 2022 онд хэрэгжиж буй улс, нийслэлийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл 2022 оны эхний хагас жилийн байдлаар:

**Чингэлтэй дүүрэгт 2022 онд шинээр хэрэгжих 87,035.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 59 төсөл, арга хэмжээ байна.**

- Улсын төсвийн хөрөнгөөр 68,744.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 20 төсөл арга хэмжээ
- Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 8,572.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл арга хэмжээ:
- Нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр 800.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл арга хэмжээ:
- Дүүргийн төсвийн хөрөнгөөр 7,589.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 төсөл арга хэмжээ
- Дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр 1,328.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 19 төсөл арга хэмжээ:

**Чингэлтэй дүүрэгт 2021-2022 он дамжин хэрэгжих 101,273.6 сая төгрөгийн нийт 113 төсөл, арга хэмжээнээс:**

- Улсын төсвийн хөрөнгөөр 66,621.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 29 төсөл арга хэмжээ:
- Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 14,386.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл арга хэмжээ
- Нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр 1,585.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл арга хэмжээ:
- Дүүргийн төсвийн хөрөнгөөр 17,955.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл арга хэмжээ:
- Дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр 724.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 17 төсөл арга хэмжээ:

**Улс, нийслэл, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтын нийт 172 төсөл арга хэмжээнээс:**

- Бэлтгэл ажил хийгдэж буй 40 төсөл арга хэмжээ:
- Тендерийн шатандаа буй 27 төсөл арга хэмжээ:
- Гэрээ байгуулагдан ажил үргэлжилж буй 53 төсөл арга хэмжээ:
- Ажил 100 хувь дууссан 52 төсөл арга хэмжээ тус тус байна.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ : “ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”**

### **Монгол улсын Засгийн газрын тогтоол:**

Монгол Улсын Их хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан “Нийтийн мэдээллийг ил тод байлгах тухай” хууль, тогтоолын биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

### **Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт:**

1. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн “Гамшгаас хамгаалах дадлага, сургууль, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах тухай” А/59 дүгээр захирамжийн биелэлт 100%
2. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/379 дүгээр захирамжийн биелэлт- 90%
3. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн “Нийслэл, дүүргийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай” А/448 дугаар захирамжийн биелэлт - 90%
4. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “Тэмцээн зохион байгуулах тухай” А/474 дүгээр захирамжийн биелэлт -70%
5. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн “Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай” А/212 дугаар захирамжийн биелэлт - 80% -тайгаар тус тус хэрэгжсэн байна.

Нийслэлийн Засаг дарга 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр А/01 дүгээр захирамж гарган “Хотын иргэний жил” болгосон. Захирамжийн биелэлтийг улирал тутам гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажиллаж байна.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ: “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”**

**Хүний нөөцийн чиглэлээр:**

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024” арга хэмжээний хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.

**БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ОНОВЧТОЙ ТОДОРХОЙЛЖ, ТҮҮНД ТУЛГУУРЛАН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ, ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД:**

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Дүүргийн удирдлага, Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/1058 дугаар захирамжид нийцүүлэх зорилгоор дүүргийн Засаг дарга 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Б/02 дугаар захирамжийг гаргаж “Архив, бичиг хэргийн тасаг”-ийг “Архивын тасаг” гэж, “Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтэс”-ийг “Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс” гэж өөрчилж, Тамгын газрын бүтцэд “Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс”-ийг, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн бүтцэд “Аж ахуйн тасаг”-ийг тус тус нэмж, ТҮ-1, ТҮ-2, ТҮ-3 зэрэглэлийн албан хаагчдыг Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-т шилжүүлсэн.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/72 дугаар тушаалыг үндэслэн 2022 оны 04 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан тушаалуудад ажлын байрны шинжилгээ хийж, 13 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, холбогдох баримтуудын хамт Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 3/872 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн захирлын болон цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” А/168 дугаар захирамжаар батлуулсан.

Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн байгуулах Ажлын хэсгийг Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/96 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд хөдөлмөрийн дотоод журмын төслийг шинэчлэн боловсруулж байна.

**ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:**

Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа албан хаагчийн оронд 2022 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийг үндэслэн 23 албан хаагчийг томилж, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийг үндэслэн 14 төрийн захиргааны албан хаагчийг байгууллага дотор сэлгэн болон шилжүүлэн ажиллуулсан. Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1 дэх хэсгийг үндэслэн 12 албан хаагчийн ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг харгалзан хууль тогтоомжийн дагуу чөлөөлж, Төрийн албаны тухай хуулийн 44.1 дүгээр хэсгийг үндэслэн 4 албан хаагчийг төрийн өөр байгууллага руу шилжүүлэн ажиллуулсан. Төрийн албаны тухай хуулийн 46.1.1, 46.1.2 дахь заалтын дагуу 4 албан хаагчийг төрийн албанаас түр чөлөөлсөн.

**ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛАН ХЭРЭГЖҮҮЛЖ, СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГА БОЛОХ ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД:**

Ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын ажилтан, албан хаагчдыг дээд шатны байгууллагуудаас зохион байгуулсан сургалтууд болон бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалтуудад үе шаттайгаар, тогтмол хамруулж, нийт 27 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 513 албан хаагч хамрагдсан.



Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйл, Улсын Их Хурлын 2019 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" 21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Засаг даргын Тамгын газар, хороодод, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад ажиллаж буй төрийн жинхэнэ албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгуулах саналыг 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд ERP дотоод удирдлагын системээр хүргүүлэн Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай" А/641 дүгээр захирамжаар дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын 24 албан хаагчийн, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын 5 даргын албан хаагчийн зэрэг дэвийг шинээр болон ахиулж холбогдох цалинг олгосон. Засаг даргын Тамгын газрын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн Б/163 дугаар тушаалаар Тамгын газрын 23 албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдлийг шинээр тогтоосон.

**АЛБАН ХААГЧДЫГ ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ, АЖИЛЛАХ ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД:**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Б/01 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны "Цалин, нэмэгдэл шинэчлэн батлах тухай" Б/46 дугаар тушаалыг үндэслэн нийт албан хаагчдын цалинг сар бүр бүрэн олгож ажилласан.

Хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн эрх үүргийг тодорхой болгох, эрх тэгш байдлыг хангах зорилгоор Засаг даргын Тамгын газрын төрийн үйлчилгээний албан хаагчидтай "Хөдөлмөрийн гэрээ"-г шинээр байгуулан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж, төрийн үйлчилгээний ажилтан, албан хаагчдад ажлын үр дүнгээр олгох ур чадварын нэмэгдлийг сар бүр ажил дүгнэсэн үнэлгээгээр үндсэн цалингийн 25 хүртэлх хувиар бодож олгосон.

Төрийн албаны тухай хуулийн 51.1.4, 61.1.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг үндэслэн албан хаагчдын гүйцэтгэлийг үнэлж, "маш сайн" үнэлэгдсэн 93 албан хаагчид үндсэн цалингийн 40 хувийн, "сайн" үнэлэгдсэн 15 албан хаагчид үндсэн цалингийн 30 хувийн урамшуулал олгосон.

Албан хаагчдын цагийн бүртгэлийг цаг бүртгэлийн системээс татан авч, удирдлагад танилцуулан ажиллаж байгаа бөгөөд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Дотоод журмын 6.5.3

дахь заалтыг үндэслэн ажлаас хоцорсон 1 минутыг 100 төгрөгөөр тооцон цалингаас суутгах арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн Засаг даргын Тамгын газрын хүндэтгэх шалтгаангүйгээр удаа дараа ажил тасалсан 2 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны "Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024 арга хэмжээ" батлах тухай 32 дугаар тогтоолын хүрээнд гэр бүлийн гишүүний эмчилгээний зардалд 6 албан хаагчид 13,6 сая төгрөг, сургалтын төлбөрт 2 албан хаагчид 4,9 сая төгрөг, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд 1 албан хаагчид 3,5 сая төгрөг зарцуулж, нийт 9 албан хаагчийг "Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024" арга хэмжээнд хамруулж, нийт 22,0 сая төгрөгийг зарцуулсан.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Дотоод журмын хүрээнд эмчилгээний зардалд 1 албан хаагчид 420,0 сая төгрөг, шинээр гэр бүл болж, гэрлэлтээ батлуулсан 2 албан хаагчид 1,2 сая төгрөг, гэр бүл, төрөл садны хүн нас барахад 4 албан хаагчид 4,6 сая төгрөг, амаржсан 1 албан хаагчид 685 мянган төгрөг, урт хугацаагаар гадаадын оронд суралцах болсон 1 албан хаагчид 650 мянган төгрөг буюу нийт 9 албан хаагчид 7,6 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.

"Төрийн албаны тухай хууль"-ийн 61 дүгээр зүйлийн 61.1.6, "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 99 дүгээр зүйлийг үндэслэн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн Б/121 дүгээр тушаалаар ажилтан, албан хаагчдын 2022 оны ээлжийн амралтын хуваарийг батлуулсан.

Нийт 95 захирамж, 166 тушаалын төслийг боловсруулж, батлуулсан.

**Албан бичгийн шийдвэрлэлтийн талаар:**

Чингэлтэй дүүргийн Онцгой комисс, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Харьяа **Нийт 107** байгууллагад Edoc.ulaanbaatar.mn нэгдсэн системээр **нийт 25224** албан бичиг ирснээс Хариутай-**2392**, Хариугүй-**22832**, үүнээс хугацаандаа шийдвэрлэсэн-**23994**, хугацаа хоцроож шийдвэрлэсэн **284**, судлагдаж байгаа-**952**, зөрчил тооцогдсон-**182** албан бичиг, шийдвэрлэлтийн **дундаж хоног 6.4** (хоногоор) байна.

/д	Хэлтсийн нэр	Энэ хугацаанд ирсэн бичгийн тоо	Үүнээс хариутай бичгийн тоо B=B1+B2+B4	Шийдвэрлэлтийн байдал			Үүнээс хариугүй бичгийн тоо C=C1+C2+C4	Хугацаандаа хаасан	Хаалтын байдал			Шийдвэрлэлтийн дундаж хоног	Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь	
				Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрсэн				Судалж байгаа	Хугацаа хэтэрсэн				Судалж байгаа
					Шийдвэрлэсэн	Шийдвэрлээгүй				Шийдвэрлэсэн	Шийдвэрлээгүй			
A	B	B1	2	3	4	C	1	C2	C3	C4	D1	E		
2		3	4	5			9	0	11	12	13	14	15	
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	119	9	18			00	6	0	0	4	4.77	100	

2	Засаг даргын Тамгын газар	2873	241	221			4	2632	436	26	0	70	7.57	98.84
3	Харьяа байгууллаг-ууд	22232	2132	2000	45	0	87	20100	19223	201	6	676	6.2	99.28
	<b>Нийт</b>	<b>25224</b>	<b>2392</b>	<b>2239</b>	<b>51</b>	<b>0</b>	<b>102</b>	<b>22832</b>	<b>21755</b>	<b>227</b>	<b>6</b>	<b>850</b>	<b>6.4</b>	<b>99</b>

Дүүргийн хэмжээнд Нийт 11675 албан бичгийн шийдвэрлэлттэй танилцан 3737 бичгийг батлан хянаж, шийдвэрлэлт хангалтгүй 58 албан бичгийн шийдвэрлэлтийг цуцлан, 34 албан хаагчид зөрчил тооцон ажилласан.

**Тоон гарын гарын үсэг олгох ажлын хүрээнд:**

Засаг даргын Тамгын газар, хороодын тоон гарын үсэг ашиглах шинээр томилогдсон 12 албан хаагчийн холбогдох материалыг бүрдүүлэн Үндэсний дата төвд хүргүүлж, мэдээллийг esign.gov.mn нэгдсэн мэдээллийн санд бүртгэн баталгаажуулж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгч заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Дүүргийн хэмжээнд нэгдсэн систем ашигладаг 107 байгууллагын эрх бүхий 142 албан тушаалтан тоон гарын үсэг авч, Edoc нэгдсэн системд тоон гарын үсгээр баталгаажсан баримт ашиглаж байна.

**Явсан албан бичгийн талаар:**

Байгууллагаас дотооддоо боловсруулсан баримт бичигт стандартын дагуу хяналт тавьж ажиллан баримт бичгийн зөвшөөрөгдсөн төслийг үндэслэн хэвлэмэл хуудсанд стандартын дагуу хэвлэх болон албан хэрэг хөтлөлтийн Edoc.ub.gov.mn программд явуулсан бичгийг бүртгэн тухайн байгууллага руу илгээж, Засаг даргын Тамгын газарт ирсэн албан бичгийн холбогдох дарга, хэлтэс албадад шилжүүлэн тайлан мэдээ гаргах (сканердаж, бүртгэл-хяналтын карт хөтлөн бүртгүүлэх) ажлыг тухай бүр хийж гүйцэтгэсэн.

Дотоодод боловсруулсан-1403 албан бичгээс Хариутай-310, Хариугүй-1401 үүнээс Хугацаа хэтэрч хариу ирүүлсэн-0, Шийдвэрлэх шатандаа-2 албан бичиг байна.

Засаг даргын Тамгын газраас Баримт бичгийн зөвшөөрөгдсөн төслийг үндэслэн хэвлэмэл хуудсанд стандартын дагуу хэвлэсэн Засаг даргын Захирамж А-204, Б-88, Засаг даргын Тамгын газрын даргын Тушаал А-147, Б-166 нийт 605 зөвшөөрөгдсөн төслийг үндэслэн хэвлэмэл хуудсанд буулгасан байна.

**Өргөдөл гомдлын шийдвэрлэлт:**

Нийслэлийн Засаг даргын А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2022 оны 01 дүгээр сарын 01-ээс 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд дүүргийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газар, дүүргийн хэмжээнд нийт 1939 өргөдөл ирснээс 1709-ийг шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа судлагдаж байгаа 213 өргөдөл хүсэлт байна.

Үүнээс:

- Хүсэлт – 1520

- Гомдол -367
- Талархал -38
- Санал -11
- Мэдэгдэл - 3 байна.

Нийслэлийн хэмжээнд өргөдөл, гомдлыг барагдуулах дундаж хугацааг 9 хоногт хүргэх зорилтын хүрээнд **2022** оны өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа **11 хоног 09 цаг 24 минут** байна.

Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс албад болон Тамгын газарт ирсэн өргөдөл гомдлыг хүснэгтээр харуулбал:


№	Хэлтэс албад	Нийт тоо	Шийдвэрлэх шатандаа	Шийдвэр лэсэн	Нийт зөрчил
1	Засаг даргын Тамгын газар	510	76	426	8
2	Мэргэжлийн хяналтын хэлтэс	101	12	89	1
3	Цагдаагийн газар	29	4	24	1
4	Цагдаагийн 1 дүгээр хэлтэс	1	0	1	-
5	Цагдаагийн 2 дугаар хэлтэс	13	1	12	-
6	Улсын бүртгэлийн хэлтэс	23	4	18	1
7	Боловсролын хэлтэс	17	1	16	-
8	Нийгмийн даатгалын хэлтэс	17	1	16	-
9	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс	10	1	9	-
10	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс	36	0	35	1
11	Татварын хэлтэс	841	79	757	4
12	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв	15	0	15	-
13	Газар зохион байгуулалтын алба	263	28	234	1
14	Биеийн тамир спортын хороо	2	-	2	-
15	Худалдан авах ажиллагааны алба	1	-	1	-
16	Хороо	10	5	5	-
17	Дүүргийн өмчит үйлдвэрийн газар	1	-	1	-
18	Эмнэлэг	48	1	47	-
19	Цэцэрлэг	1	-	1	-
	<b>НИЙТ</b>	<b>1939</b>	<b>213</b>	<b>1709</b>	<b>17</b>



Дүүргийн хэмжээнд 01 дүгээр сарын 01-ээс 06 дугаар сарын 06-ны байдлаар нийт 549 зөрчил тооцогдсон. Үүнд:

- Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил – 284
- Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил – 67
- Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил – 162 Хугацаа хэтэрсэн 3 байна.

2021 оны эхний хагас жилийн байдлаар 790 өргөдөл гомдол ирснээс зөрчил нийт 224 буюу 28.35%-ийг эзэлж байсан бол 2022 онд 535 буюу 27.59%-ийг эзэлж байна.




	2022	2021
■ Зөрчилтэй өргөдөл	27.59%	28.35%
■ Нийт Өргөдөл гомдол	100%	100%

■ Зөрчилтэй өргөдөл ■ Нийт Өргөдөл гомдол


2021 оны мөн үед явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил нийт 94 буюу 11.89%-ийг эзэлж байсан бол 2022 онд 162 буюу 8.35%-ийг эзэлж байна.

Өргөдөл, гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 10 хоног тутамд нэгээс доошгүй удаа хийж хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээ, үйл явц, хэрхэн судалж байгааг явцын тэмдэглэл хөтөлнө.




■ Явцын тэмдэглэл хөтлөөгүй ■ Нийт Өргөдөл гомдол

2021 оны мөн өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил нийт 86 буюу 10.88%-ийг эзэлж байсан бол 2022 онд 284 буюу 14.64%-ийг эзэлж байна.



2021 оны мөн өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил нийт 44 буюу 5.56%-ийг эзэлж байсан бол 2022 онд 67 буюу 3.45%-ийг эзэлж байна.



### Архивын талаар:

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.6, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/452 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн архивын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн "Захирамжлалын баримт бичгийн цахим нөхөн бүрдүүлэлт хийх хуваарь"-ийн дагуу <https://arch.ulaanbaatar.mn/> программын Archive eDoc" системд оруулсан дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын 93 байгууллагын 173 хадгаламжийн нэгжийн 8157 баримтын 13664 хуудас баримтад батлан шалгах ажлыг хийж гүйцэтгэсэн Батлан шалгалт хийх явцад гаргасан алдаа дутагдлыг тухай бүрд нь хариуцсан албан хаагчидтай холбогдон зөрчлийг арилгуулж давхардсан тоогоор 455 алба хаагчид заавар, зөвлөгөө өгч хяналт тавин ажилласан. 2019-2021 оны "Archive eDoc" системд хөрвүүлсэн захирамжлалын баримт бичгийн цахим хувийг тусгай тээгч (DVD, CD, Hard диск)-д нийт 49 байгууллагын 16791 хнийн 18075 хуудас захирамжлалын баримтыг тусгай тээгч дээр он тус бүрээр буулгуулан актаар хүлээн авсан.

Архивын лавлагаа авах хүсэлт ирүүлсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан хаагчдаас ирсэн албан бичиг, өргөдлийг үндэслэн 14 хөмрөгийн 145 хадгаламжийн нэгжийн баримтын 756 хуудас, баримтыг шүүж үзэж ХУУЛБАР ҮНЭН тэмдгээр баталгаажуулж олгосон байна.

**НИЙСЛЭЛ ЗАСАГ ДАРГЫН 2015 ОНЫ А/633 ДУГААР ЗАХИРАМЖ "НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ ЖУРАМ"-ЫН ХҮРЭЭНД:**

Нийслэл Засаг даргын 2015 оны А/633 дугаар захирамж "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журам"-ын хэрэгжилтийг ханган цаасан суурьт болон цахим санг "Ажил хүлээлцэх акт"-ын дагуу ажлын хэсэгт архивын ажилтан оролцон зааврын дагуу бүрдүүлэлт хийж "Ажил хүлээлцэх комисс"-ын даргад танилцуулан ажилласан. Нийт 42 удирдах албан тушаалтан болон мэргэжилтний ажил хүлээлцэх комисст оролцсон.

**АРХИВЫН БАРИМТЫН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:**


Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасны дагуу дүүргийн архивд архивын баримтын аюулгүй байдал, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор 40м2 өрөөг хадгаламжийн сангийн зориулалттай болгон засварлаж дүүргийн төсвийн хөрөнгөөр Архивын тоног төхөөрөмж худлан авах ЧД2022/01-48 дугаартай гэрээ байгуулж 19,8 сая төгрөгийн Тоног төхөөрөмжөөр хангаж архивын аюулгүй байдал хадгалалт хамгаалалтыг сайжруулсан.

**Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл:**

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ний "Дүүргийн 2022 оны төсөв батлах тухай" 07 дугаар тогтоол батлагдсантай холбоотойгоор дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 14,698,515,600 /арван дөрвөн тэрбум зургаан зуун ерэн найман сая таван зуун арван таван мянга зургаан зуун/ төгрөгийн төсөвт өртөгтэй 101 төсөл арга хэмжээг батлуулсан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/140 дугаар захирамжаар эрх шилжүүлсэн 3 төсөл арга хэмжээ нийт 104 төсөл арга хэмжээний төлөвлөгөөг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн дагуу боловсруулан батлуулж хуулийн хугацаанд Монгол Улсын Сангийн яам, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар тус тус хүргүүлэн ажиллалаа.

- Мөн Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), [www.report.ub-procurement.mn](http://www.report.ub-procurement.mn), цахим хуудаснууд болон өдөр тутмын "Өнөөдөр" сонинд нийтэлж хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллалаа.
  - Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн 600,000,000 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд 100 хувийн гүйцэтгэлтэйгээр зохион байгуулж байна.
  - Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2,072,175,200 /хоёр тэрбум далан хоёр сая нэг зуун далан таван мянга хоёр зуу/ төгрөгийн төсөвт өртөгтэй 37 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд 97 хувийн гүйцэтгэлтэйгээр зохион байгуулсан.
  - Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 12,626,340,400 /арван хоёр тэрбум зургаан зуун хорин зургаан сая гурван зуун дөчин мянга дөрвөн зуу/ төгрөгийн 64 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг нэр төрлөөр нь:

**Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 64 төсөл арга хэмжээ**



Тоног төхөөрөмж 2,153,050,000 /хоёр тэрбум нэг зуун тавин гурван сая тавин мянга/ төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл арга хэмжээнээс 22 төсөл арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэй зохион байгуулсан.

- Зураг төсөв 931,000,000 /есөн зуун гучин нэгэн сая/ төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл арга хэмжээнээс 9 төсөл арга хэмжээг 82 хувийн гүйцэтгэлтэй зохион байгуулсан. Захиалагчаас ажлын даалгавар ирүүлээгүй нэг төсөл арга хэмжээ, Дүүргийн төр захиргааны байгууллагын барилгын зураг төсөв төсөл арга хэмжээ Барилга хот байгуулалтын яам руу эрх шилжсэн хөрөнгө татагдсан.

- Тохижилт засвар 1,456,897,700 /нэг тэрбум дөрвөн зуун тавин зургаан сая найман зуун ерэн долоон мянга долоон зуу/ төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэй зохион байгуулсан.

- Боловсролын салбарт 957,395,100 /есөн зуун тавин долоон сая гурван зуун ерэн таван мянга нэг зуу/ төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл арга хэмжээг 100 гүйцэтгэлтэй зохион байгуулсан.

- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн үйл ажиллагааны бараа үйлчилгээний бусад зардал 270,000,000 /хоёр зуун далан сая/ төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ Засгийн газрын 388 тогтоолоор цуцлагдсан.

**Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл:**

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөвт өртөг	Хөрөнгө оруулалтын ажил тоо
1	Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө	600 000 000	3
2	<b>Нийт дүн</b>	<b>600 000 000</b>	<b>3</b>

**Нэг цонхны үйл ажиллагааны талаар:**

Дүүргийн "Нэг цэгийн үйлчилгээ"-ний танхимд байрлах "Мэдээллийн самбар" буюу "Төрийн Үйлчилгээний ухаалаг дэлгэц"-ээр Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс албадын 24 төрлийн үйлчилгээний мэдээллийг хүргэж ажиллалаа.

Дүүргийн "Нэг цэгийн үйлчилгээ"-ээр эхний хагас жилийн байдлаар 55119 иргэн үйлчлүүлж 55119 асуудал, хороодын "Нэг цэгийн үйлчилгээ"-ээр 18196 иргэн үйлчлүүлж 18196 асуудлыг тус тус шийдвэрлэсэн байна.

**Улсын бүртгэлийн үйлчилгээгээр нийт 14394 иргэнд үйлчилгээ үзүүлснээс:**

1. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хүлээн авах-9850 , олголт- 9780
2. Гадаад паспортын захиалга хүлээн авах-6822, гадаад паспорт олголт-6785,
3. Шинэ төрөлт-4, гэрлэлт батлуулах-1, гэр бүлийн 18 төрлийн лавлагаа-5994, цахим үнэмлэх дахин олголт-2500,
4. Нас баралт бүртгэл-3, овог нэр өөрчлөлт-68, эцэг тогтоолт-13, гэр бүл цуцлалт-56, төрсний гэрчилгээ дахин олголт-198,
5. Шинээр цахим үнэмлэх авах-1099, цахим үнэмлэх сунгалт-4146 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

Төрийн үйлчилгээг ая тухтай, түргэн шуурхай үзүүлэх зорилгоор Дүүргийн 1 давхрын "Нэг цонхны үйлчилгээ"-ний тахимд 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хүртэл засварын ажил хийгдэж байна.



**Хорооны үйл ажиллагааны талаар:**

Нийслэл, дүүрэг, хорооноос дэвшүүлсэн зорилтуудыг иргэдэд хүргэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, орон нутгийн тулгамдсан асуудлаар шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс болон төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж байгаа аливаа үйл ажиллагаанд байгууллага аж ахуй нэгж, иргэдийг жигд хүртээмжтэй оролцуулах, төр захиргааны байгууллагын ажлыг иргэдэд нээлттэй ил тод, түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэхээр ажиллаж байна.

"Хаягжуулалт өнөөгийн байдал, шуудангийн нэгдсэн кодын хэрэглээ" сэдэвт сургалтыг Харилцаа холбооны зохицуулах хороо, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Нийслэлийн хот байгуулалтын хөгжлийн газруудтай хамтран зохион байгуулсан.

Хороодын 197 хэсгийн ахлагчдын ажлын үр дүнг 10 шалгуур үзүүлэлтийн дагуу үр дүнг тооцон сар бүр урамшуулал олгуулах, хэсгийн ахлагч нартай "Хөлсөөр ажиллах гэрээ"-г шинэчлэн батлуулж

ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу хагас бүтэн жилээр дүгнэх, хэсгийн ахлагч нарын үнэмлэх сунгалт, шинээр томилогдсон хэсгийн ахлагч нарыг үнэмлэх олгох ажлыг тус тус гүйцэтгэсэн.

Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөнийг тандах туршилтын судалгааг зохион байгуулах, удирдлага арга зүйгээр хангаж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжил, боловсрол, эрүүл мэнд хариуцсан орлогч Т.Төмөртөмөө болон Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэх саналыг нэгтгэх. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн хөгжлийн сантай хамтран Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөнийг тандах зорилгоор Нийслэлийн хороодод ДТМ аргачлалаар туршилтын судалгааг зохион байгуулсан. Дүүргийн хэмжээнд хороодын 186 хэсгийн мэдээллийг нэгтгэсэн.

Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хүсэлт хүргүүлэн 19, 24 дүгээр хороодын Засаг дарга нарт 19 дүгээр хорооны зуслангийн бүсийн айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хаягжилт бүхий газрын зургийг авч хүргүүлсэн.

“Шилдэг хороо-шилдэг хэсгийн ахлагч нарын баг” шалгаруулах болзолт уралдааны хүрээнд Сонгинохайрхан, Баянгол, Сүхбаатар, Налайх, Багануур дүүргүүдийн 19 хороогоор зөвлөн туслах, хяналт шалгалт, мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч ажилласан

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газраас хамтран зохион байгуулсан “Эртэч Чингэлтэйчүүд” аяны явган аяллыг хороодын ажилтан, албан хаагч, иргэдийн оролцоог хангаж ажилласан.



#### Гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар:

Тус дүүргийн Ерөнхий боловсролын 17, 72 дугаар сургуулиудад Оросын шинжлэх ухаан, соёлын төв /РЦНК/-тэй хамтран 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр орос хэлний төвүүдийг байгуулж, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Ш.Оюунсүрэн тус байгууллагатай Хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан. Орос хэлний төв байгуулах ёслолын үйл ажиллагааны үеэр Оросын шинжлэх ухаан, соёлын төвийн захирал Амгалан Базархандаев Ринчинович тус дүүргийн 17 дугаар сургуулийг ЗХУ-ын 3 удаагийн баатар, маршал Семён Михайлович Будённыйн, 72 дугаар сургуулийг Оросын сансрын нисгэгч, ЗХУ-ын хошой баатар, БНМАУ-ын баатар, хошууч генерал Владимир Александрович Жанибековын нэрэмжит болгох тухай мэдэгдсэн.



Япон улсын Яйзү хотын Засаг дарга Накано Хиромичигээс Чингэлтэй дүүргийн Засаг дарга Н.Батсүмбэрэлд ирүүлсэн 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн албан захидлыг удирдлагад танилцуулж, Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 1/1330 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.

Япон улсын Эрүүл хотуудыг дэмжих ашгийн бус байгууллагын ерөнхийлөгч, доктор Мицуюки Чиба болон бусад албаны хүмүүстэй 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр цахим уулзалт хийж, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/, Япон улсын Эрүүл хотуудыг дэмжих ашгийн бус байгууллагатай хамтран 2022-2025 онд хэрэгжүүлэх дүүргийн 37, 50 дугаар сургуулийн сурагчдад шүдний үзлэг хийх төслийг хэрэгжүүлж эхэлсэн.



2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр төслийн хэрэгжилтийн талаарх ээлжит цахим уулзалтыг хийж, төслийн туршлага судлах үйл ажиллагааг 2022 оны 06 дугаар сард Япон улсад албан ёсоор эхлүүлэхээр шийдвэрлэсэн.



Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Япон улсын Эрүүл хотуудыг дэмжих ашгийн бус байгууллагатай хамтран дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад шүдний үзлэг хийх төслийн хүрээнд Япон улсын Токио хотод туршлага судлах сургалтад хамрагдах тус дүүргийн 9 албан хаагчийн виз мэдүүлэхэд шаардагдах бичиг баримтуудыг бүрдүүлэн ажиллаж байна.

**Шагналын талаар:**

- I. Төрийн дээд одон, медаль:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хороодоос Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар нэр дэвшүүлж шаардлага хангасан 100 иргэний холбогдох баримтын бүрдлийг хүлээн авч холбогдох дээд шатны байгууллагад уламжлан google drive программд нэр дэвшигчдийн мэдээллийг бүрэн шивж оруулсан. Мөн 306 ажилтан, албан хаагч, иргэний материалыг хүлээн авч журмын хүрээнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барихаар бэлтгэл ажил бүрэн хангагдсан.

Дүүргийн хэмжээнд 2022 онд "Алдарт эх"-ийн I дүгээр зэргийн одонгоор 34, II дугаар зэргийн одонгоор 467 нийт 501 эх болзол хангасан. Үүнээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 69 дүгээр зарлигаар 478 эх 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр төрийн ордноос одонгоо гардан авсан.



## II. МУ-ын Засгийн газар болон яамдын шагнал:

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт"-ын дагуу дүүргийн нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгжээс Засгийн газрын болон яамдын шагналаар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж 5 иргэний шагналын материалыг дүүргийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 1/1199 тоот албан бичгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд, 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 1/1188 тоот албан бичгээр Нийслэлийн Соёл, урлагийн газарт, 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 1/1059 тоот албан бичгээр Нийслэлийн Боловсролын газарт тус тус уламжилсан.

## III. Дүүргийн Засаг даргын шагнал:

Дүүргийн Засаг даргын шагналаар 2022 оны хагас жилийн байдлаар нийт 65 хүнийг шагнаж урамшуулсан. Үүнд:

- Дүүргийн Засаг даргын "Хүндэт тэмдэг"-ээр 25,
- Дүүргийн Засаг даргын "Хөдөлмөрийн алдар медаль"-аар 56 нийт 81 ажилтан, албан хаагч, иргэдийг шагнаж урамшууллаа.





Дүүргийн 30 жилийн ойн медалийн эх бэлтгэлийн загварыг Гоёл трейд ХХК-аар эхний ээлжид удирдлагад танилцуулан ажилласан. Нийт 4 ойн медаль, 1 энгэрийн тэмдгийн загварыг дүүргийн ИТХ-ын даргад танилцуулсан.



**Эрх зүй, хуулийн ажлын талаар:**

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл

ажиллагааны хөтөлбөр, бусад холбогдох хууль, тогтоомж болон энэ онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг мөрдлөг болгон ажиллалаа.

Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт байрлах "Тусгаар тогтнолын талбай", "Барилгачдын талбай", "Хэлмэгдэгсдийн хөшөө", "Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэн" "Аргальтай хөшөө" зэрэг газруудад өдөрлөг, арга хэмжээ, жагсаал, цуглаан гэх мэт арга хэмжээ зохион байгуулах 8 хүсэлт /мэдэгдэл/-ийг судлан үзэж, холбогдох байгууллагуудын саналыг харгалзан хуулийн хүрээнд хариу өгч ажилласан болно.

Хууль, эрх зүйн туслалцаа шаардлагатай иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөн ажилласнаас төрлөөр нь авч үзвэл

- Өв залгамжлал-3
- Худалдан, худалдан авах-1
- Бараа материал худалдах худалдан авах-1
- Хөдөлмөрийн маргаан-1
- Иргэний эрх зүйн маргаан-3
- Зөрчлийн хэрэг маргаан-1
- Эрүүгийн хэргийн маргаан-1 нийт 11 иргэнд хууль, зүйн зөвлөгөө өгөн ажилласан.

Иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний төслийг хянах, дугаарлах, бүртгэх ажлын хүрээнд:

- Хог хаягдлын гэрээ-3
- Газрыг нөхөн олговортойгоор худалдан авах гэрээ-33
- Хөлсөөр ажиллах гэрээ-3
- Ажил гүйцэтгэх гэрээ-15
- Хамтран ажиллах гэрээ-25
- Худалдан, худалдан авах гэрээ-5
- Түрээсийн гэрээ-2
- Үйлчилгээ үзүүлэх гэрээ-1
- Зураг төсөв боловсруулах гэрээ-15 нийт 102 гэрээний холбогдох хуулийн үндэслэл, заалтыг судлах, агуулга, найруулгыг хянах, бүртгэж, дугаар олгох ажлууд хийгдсэн.

Дүүргийн Засаг даргын А захирамж 204, Б захирамж 88, Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал 147, Б тушаал 166 тус тус тушаалын эрх зүйн үндэслэлийг судалж, агуулга, найруулгыг хянасан байна.

**Нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:**Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар болон Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газартай хамтран "Анзаар" аян нь "Нэг удаа гэж үгүй" уриатайгаар 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан дүүргийн Шүүх, Прокурор, Цагдаагийн байгууллага, Нутгийн захиргааны байгууллагууд, Ерөнхий боловсролын болон Их, дээд сургуулиуд, Эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төв зэрэг бүх шатны нийт 4125 албан хаагч нарт "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, дуудлага мэдээлэлд очиход анхаарах асуудал, хууль эрх зүй" сэдвээр сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулан ажиллалаа.



Аяны хүрээнд Иргэн-425, Хууль, хяналтын байгууллага-227, Төрийн албан хаагч-772, ЭМТ, ӨЭМТ-ийн эмч, ажилтнууд-187, СӨХ, ААНБ-ын удирдлага ажилтнууд-292, Нийтийн эргүүл-457, Багш-469, Дунд, ахлах ангийн сурагчдын 1296 эцэг эхчүүдэд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өсвөр үе хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах хорт зуршил, түүний үр дагавар сэдвээр сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулан ажиллалаа.



Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газрын 65 төрийн албан хаагч 1-19 дүгээр хороодын 234 иргэн нийт 299 иргэнд "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, дуудлага мэдээлэлд очиход анхаарах асуудал, хууль эрх зүй" сэдвээр нийт сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулан харилцан ярилцан санал, хүсэлтийг сонсон "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн хүнийг таних, илрүүлэхэд анхаарах асуудал" гарын 297 ширхэг гарын авлага тараав.



Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд туслах чиг үүрэг бүхий 23 иргэнтэй Олон нийтийн байцаагч нарыг ажиллуулах гэрээг сунгаж, сар бүрийн 05-ны өдөр ажлын тайлан мэдээг нэгтгэн урамшуулалыг тогтмол олгосон.

**Цэргийн штабын үйл ажиллагаанаас:**

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб нь Батлан хамгаалахын яамны сайд, Нийслэлийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний дагуу 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил 100 хувийн биелэлттэй байна.

Чингэлтэй дүүргийн эдийн засаг, нийгмийг 2022 онд хөгжүүлэх үндсэн зорилтын хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус мөрдлөг болгон Цэргийн штаб 2022 оны эхний хагас жилд үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 64 арга хэмжээ төлөвлөснөөс 2022 оны хагас жилийн байдлаар 100 хувийн биелэлттэй байна.

Батлан хамгаалахын яамны сайд, Нийслэлийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний хүрээнд дүүргийн хэмжээнд батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчлах, батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хүсэлт гаргасан иргэдийг хяналтын тоонд багтаан элсүүлэх, тушаал шийдвэрийн хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих ажлуудыг төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа.

Цэргийн штабт энэ оны хагас жилийн байдлаар удирдах дээд байгууллагаас ирсэн Батлан хамгаалахын сайдын тушаал-3, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаал 2, нийслэлийн Засаг даргын захирамж-1, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын тушаал-8, дүүргийн Засаг даргын захирамж 1, нийт 15 тушаал, захирамж ирснийг бүртгэн авч холбогдох албан тушаалтнуудад танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

*Тоо бүртгэл, цэрэг халалтын ажлын талаар:*

Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны "Цэргийн бүртгэл явуулах тухай" А/331 дүгээр журмыг удирдлага болгон нийслэлийн Засаг даргын 2021 оны А/980, дүүргийн Засаг даргын А/513 дугаар захирамжаар дүүргийн хэмжээнд 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 01 дүгээр сарын 21-ний өдрүүдэд цэргийн бүртгэлийн ажлыг E-Mongolia цахим портал, Засаг захиргааны анхан шатны нэгж болох хорооны Засаг даргын ажлын байранд зохион байгуулан ажиллалаа. Цэргийн бүртгэл явуулахад шаардагдах төсвийг Засаг даргын Тамгын газрын даргын А/237 дугаар тушаалаар гаргуулан зориулалтын дагуу зарцуулж тайлагнан ажилласан.

Дүүргийн Засаг даргын захирамжаар цэргийн бүртгэлийн ажлын хэсгийг байгуулж, цэргийн бүртгэлийг хангах 16 ажил бүхий төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% биелүүлсэн.

ЧД-н Засаг даргын захирамжаар томилогдсон бүртгэлийн ажилд хяналт тавих үүрэг бүхий Цэргийн штабын офицер, ахлагч нар 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр 1-19, 20, 24 дүгээр хороодын Засаг дарга, зохион байгуулагч нартай цэргийн бүртгэлийг хэрхэн зохион байгуулах, иргэд E-Mongolia цахим нэгдсэн порталаар хэрхэн бүртгүүлэх талаар сургалт, семинарыг зохион байгуулсан.

Дүүргийн Цэргийн штабын мэдээллийн сангийн программ болон хороодын мэдээллийн санд вирусийн эсрэг программыг бүрэн суулган, цэргийн бүртгэл явуулах чиглэл, удирдамжийг хороодын Засаг дарга нарт өгсөн.

Цэргийн бүртгэлийн ажлыг зохион байгуулж, хяналт тавин ажиллах ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, анкет, маягт, сурталчилгааны материал, зурагт хуудас, ариутгал халдваргүйжүүлэлтийн материалуудыг тарааж өгч, цар тахлын үеийн зааварчилгаагаар ханган ажиллаа.

Цэргийн бүртгэлийн үеэр цэргийн штабын офицеруудаас хороодод хийх шалган туслах ажлын хуваарь, удирдамжийг боловсруулан, хороодыг хариуцан ажиллах офицеруудын жижүүрийн хуваарь гарган хариуцуулан ажилласан.

Нийслэлийн Цэргийн штабаас 2021 онд дэвшүүлсэн “Цахим шинэчлэлийн жил” зорилтын хүрээнд 2022 оны цэргийн бүртгэлийг цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia болон хороодын Засаг даргын ажлын албаны байранд зохион байгуулж иргэдэд хүрэх зурагт хуудас, гарын авлага маягтууд, төрийн батлан хамгаалах үйлчилгээний мэдээллийн самбарт байршуулан дүүргийн хэмжээнд цэргийн бүртгэл хийгдэж буй хаяг, мэдээллийг нэг загварт оруулан ажиллаа.

Цэргийн бүртгэлийн 2022 онд мэдээллийн санд шинэчлэн бүртгэгдсэн цэргийн үүрэгтний мэдээллийг үндсэн мэдээллийн сангийн баазад хуулбарласан. Шинээр бичигдсэн маягт анкетуудыг мэдээллийн санд шивж оруулан 2022 оны цэргийн бүртгэлийн ажил 96,2 хувтай явагдсан.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/512, дүүргийн Засаг даргын А/143 дугаар захирамжуудыг үндэслэн 2022 оны 1 дүгээр ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагыг 05 дугаар сарын 06, 07, 08-ны өдрүүдэд зохион байгуулсан.



Цэрэг татлагын бэлтгэлийг хангах ажлын төлөвлөгөө гарган, Цэрэг татлагын товчооны даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд нийт 32 ажил төлөвлөснөөс гүйцэтгэл 100 хувь биелсэн.

Төлөвлөгөөт арга хэмжээний хүрээнд зарлан дуудах мэдэгдэл, маягт, анкет, бусад бичиг баримтуудыг шинээр томилогдсон дарга нарын нэрээр, цэргийн насны иргэдийн нэрсийг мэдээллийн сан, өрхийн бүртгэлийн дагуу хороо, хороогоор тус тус гаргаж зарлан дуудах мэдэгдэл бичиж тараасан.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг оношилгоонд цэргийн жинхэнэ албанд татах зарлан дуудах мэдэгдэл авсан цэргийн насны иргэдийг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж, эрүүл мэндийн даатгал тогтмол төлсөн 718 иргэн биохими, цусны дэлгэрэнгүй шинжилгээ, БЗДХ-ын илрүүлэг зэрэг шинжилгээнүүдэд хамрагдсан.

Цэрэг татлагын товчооны хурлыг 2 удаа хийж, товчооны бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарийг тодотгож, хороодын Засаг дарга, зохион байгуулагч нартай 2 удаа, эмч нарын бүрэлдэхүүнтэй 1 удаа тус тус семинар зохион байгуулж, хороодод хяналтын тоо тогтоож, үүрэг даалгавраар хангаж ажилласан.

Эрүүл мэндийн үзлэгт орсон цэргийн үүрэгтнүүдийг цусны дэлгэрэнгүй шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээ, биохимийн шинжилгээ (элэг, бөөрний үйл ажиллагаа, глюкоз), БЗДХ, элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээ, цээжний рентген шинжилгээ, зүрхний цахилгаан бичлэг, хэвлийн чанд авиан оношилгоо, цэргийн жинхэнэ албанд тэнцсэн иргэдээс ковид-19 түргэвчилсэн шинжилгээ зэргийг хийлгэн хариуг бичиг баримтад нь хавсарган Хилийн цэргийн болон Дотоодын цэргийн дамжин өнгөрүүлэх ангиудад хүргүүлж ажиллаа.

Батлан хамгаалах төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор "Шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам"-ын дагуу аймаг, Нийслэлийн дүүргүүдээс шилжин ирсэн цэргийн бэлтгэл үүрэгтэнг хороодын Засаг даргын ажлын албадтай хамтран хяналт тавин ажиллаж 2022 оны хагас жилийн байдлаар 58 цэргийн үүрэгтэн шилжин явж, 32 цэргийн үүрэгтэн шилжин ирснийг зохих журмын дагуу цэргийн бүртгэлд авч, цэргийн мэдээллийн санд баяжилт хийж ажилласан.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн баталсан "Эрүүл Чингэлтэйчүүд-2024" хөтөлбөрийн хүрээнд Засаг даргын захирамж гаргаж "Цэргийн насны залуучуудад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг сайжруулах болзолт уралдаан"-ыг зохион байгуулах уралдааны хөтөлбөр, захирамж боловсруулан, 4 дүгээр улиралд үр дүнг тооцон ажиллана.

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Сангийн яам, дүүргийн Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын 24 дүгээр сургууль, төрийн бус "Олонлог" сургууль, "Соёмбо" принтинг ХХК гэсэн нийт 6 байгууллага, аж ахуйн нэгжид Батлан хамгаалах хууль тогтоомж, цэргийн үүргийн биелэлтийн хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын баталсан хяналт шалгалтын 2022 оны төлөвлөгөө, дүүргийн Засаг даргын 2022 оны А/35 дугаар захирамж, удирдамжийн дагуу зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Тус шалгалтад төлөвлөгөөний дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын 24 дүгээр сургууль, "Олонлог" сургуулийн ажилтан албан хаагчдыг бүрэн хамруулж батлан хамгаалах хуулийн дагуу цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөр орлуулан хаах болзол шаардлага хангасан 18 иргэнд мөнгөн төлбөр тогтоож, ажлын байранд нь төрийн батлан хамгаалах



үйлчилгээг хүргэлээ. Үлдсэн байгууллагуудад төлөвлөгөөний дагуу III улиралд хяналт шалгалтын ажил хийгдэнэ.

Дүүргийн 1-19, 20, 24 дүгээр хороодод Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярын тэмдэглэх ажлын хүрээнд 2022 оны 03 дугаар сарын 12-19-ны өдрүүдэд "Мөрдөстэй залуу нас" сэдэвт алдаршуулах гурван үеийн уулзалт өдөрлөгийг зохион байгууллаа. Уулзалт өдөрлөгт 420 гаруй иргэн хамрагдаж, 60 ахмад дайчин, бэлтгэл офицер, хурандаа нарыг алдаршуулсан. Дүүргийн 7, 8, 13, 15, 17 дугаар хороодоос хугацаат цэргийн албанд татагдсан 43 алба хаагчийн ар гэрт хүнсний болон эд материалын тусламж үзүүлсэн.



Чөлөөлөх дайнд оролцсон 8 дугаар хорооны ахмад дайчин С.Ванчигдоо, Баруун хилийн тулгаралтад тулалдаж явсан 6 дугаар хорооны ахмад дайчин Б.Логи нарт Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101, Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойн баярын мэндийг хүргэж, Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медаль, Батлан хамгаалах яамны сайдын гарын бэлгийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Баянбаатар, Цэргийн штабын төлөвлөлт сургалтын офицер ахмад Н.Лхамжав нар 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр гардуулан өгсөн.

**Боловсролын чиглэлээр:**

Дүүргийн хэмжээнд шинээр баригдаж байгаа сургууль, цэцэрлэгийн барилгын ажил, урсгал засвар шаардлагатай сургууль, цэцэрлэгийн судалгааг гарган холбогдох байгууллагад өгөн засварын ажилд хяналт тавьж ажиллаж байна. Тухайлбал:

- Дүүргийн 16 дугаар хорооны 150 ортой 293 дугаар цэцэрлэг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс үйл ажиллагаа явуулж эхэлсэн.
- Дүүргийн 12 дугаар хорооны 150 ортой 298 дугаар цэцэрлэг барилгын ажил бүрэн дуусаж, улсын комисс хүлээн авсан. Тоног төхөөрөмжийг татаж авсны дараа үйл ажиллагаа эхэлнэ.



- Дүүргийн 1 дүгээр хорооны 39 дүгээр цэцэрлэгийн барилгын ус, дулаан холбогдсон. Гадна тохижилт явган зам болон зоорины давхрын замаск плита хийгдэж байна. Мөн галын аюулгүйн гарц, орцын асуудал шийдэгдсэн.



- Дүүргийн 12 дугаар хорооны 144 дүгээр бага сургууль, 276 дугаар цэцэрлэгийн цогцолбор барилгын ажлыг "Хан Атрибут" ХХК гүйцэтгэж байна. Барилгын 1, 2, 3 давхрын өрлөг шавардлага, цагаан замаскийн ажил, гадна цэвэр, бохир шугамын ажил, цонх суулгах ажил, дулааны холболт, сантехник, дотор халаалт хийгдсэн. Агааржуулалт 90 хувь, гадна замын талбайн тэгшилгээ 90 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. Мөн гадна хашаа, гадна тохижилт, зам талбайн цутгалт хийгдэж байна.



- Дүүргийн 4 дүгээр хорооны Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн өргөтгөлийн шаврын ажил 90 хувь, урд болон хажуу талуудын гадна фасад 90 хувь хийгдсэн, гадна тохижилт хийж эхэлсэн. Дулааны холболт хийгдсэн ба зураг нь барилгын хөгжлийн төв дээр хянагдаж баталгаажсан.



- Шинээр барих 5 дугаар хорооны цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Хөх хайрхан" трейд компани шалгарсан. Барилгын ажлын гүйцэтгэл 50 хувьтай байна.
- Дүүргийн 8 дугаар хороонд 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга баригдахаар шавыг тавьсан. Одоогоор газар чөлөөлөх ажил хийгдэж байгаа ба барилгын ажлын гүйцэтгэгчээр "Лайки лайф" ХХК шалгарсан.
- Ерөнхий боловсролын 37 дугаар сургууль 3 давхрын засварын ажлыг хийж дуусгасан.
- Ерөнхий боловсролын 50 дугаар сургууль нийтийн эзэмшил хана, тааз будаг хийсэн, 3 давхрын шалаа сольсон. Мөн багш нарын өрөөг тохижуулж, номын санд засвар хийсэн.
- Ерөнхий боловсролын 72 дугаар сургууль 1 дүгээр давхрын шалыг плитадаж, засвар хийж дууссан.
- Ерөнхий боловсролын 24 дүгээр сургууль хичээлийн 2 байрын бүх ангидаа интернэтийн шугам оруулж, ил утас холболтуудыг далдалсан. Мөн хичээлийн 2 дугаар байрандаа нийтийн эзэмшлийн сул талбайд номын сан байгуулсан.
- Ерөнхий боловсролын 117 дугаар сургууль 2, 3 давхрын нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийг шинэчлэн засварласан.
- Дүүргийн 31 дүгээр цэцэрлэгийн засварыг бүрэн хийж дууссан.





- Цэвэр агаар төслийн хүрээнд 83 дугаар цэцэрлэг хэрэглээний халуун устай болсон ба фасад дээврийн засвар бүрэн хийгдсэн.
- Дүүргийн 276 дугаар цэцэрлэгийн цахилгааны улсын комисс ажиллаж дүгнэлт гаргасан.
- Ерөнхий боловсролын 50 дугаар сургууль Монгол дахь Гёте институтийн хөрөнгө оруулалтаар Герман хэлний номын сан, уншлагын булан байгуулж, 3795 еврогийн үнэ бүхий Герман хэлний ном, сурах бичигтэй болсон.



- НХО-ын газраас сургууль цэцэрлэгийн цонхонд агаар шүүгч суулгах ажлын тендерт шалгарсан "Окфил эко" ХХК шалгарсан бөгөөд дүүргийн 35 цэцэрлэг, 18 сургуульд нэг бүр нь 121.000 төгрөгийн үнэтэй, нийт 556.963.000 төгрөгийн үнэ бүхий 4603 ширхэг агаар шүүгч суурилуулах ажлыг эхлүүлсэн.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ЕБС-ийн 19 сургуулийн багшийн хөгжлийн төвийг шинэчлэн тохижуулах төсөл арга хэмжээ эхэлж, тендер зарлагдсан.

**"Багшийн мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүй, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэн, хөдөлмөрийг бодитой үнэлэх тогтолцоог бүрдүүлэх" зорилтын хүрээнд:**

"Багшийн ёс зүйн" жилийн хүрээнд ЕБС, СӨББ-ын дэргэдэх ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг чанаржуулж багш, удирдах ажилтнуудад сургалт, үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд:

ЧД-н ЗДТГ, Ахмадын хороотой хамтран 2022 оны 01 дүгээр сард төрийн өмчийн ерөнхий боловсролын нийт 18 сургуулийн 3000 гаруй багшид "Ёс зүй", "Инновац" сэдвээр ахмадын хорооны дарга П.Төвсанаа сургалт зохион байгуулсан.

-Цэцэрлэгийн багш ажилтан нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих зорилгоор "Тоглонгоо суралцахуй" цахим сургалтад нийт 38 цэцэрлэгийн 450 багш

- "Монгол ёс заншил" танхимын сургалтад 54 цэцэрлэгийн 820 багш ажилтан, албан хаагчид
- "Эко боловсрол" хөтөлбөрийн үр дүн цахим сургалтад 38 цэцэрлэгийн 358 багш ажилтан
- "Төсөлт тоглоом - Амьтан" сэдэвт ажлыг зохион байгуулсан үр дүн тайлан - цахим сургалтад

38 цэцэрлэгийн 360 багш ажилтан

- "Хүүхэд хамгаалалд бидний оролцоо" үзүүлэх ажилд 39 цэцэрлэгийн 45 багш ажилтан
- "Хэл яриа хөгжүүлэх" арга зүйн хэрэглэгдэхүүн сургалтын материал бэлтгэх уралдаанд шалгарсан бүтээлийг сурталчлах үзүүлэх ажилд 18 цэцэрлэгийн 62 багш арга зүйч нар хамрагдсан.

- "Эртэч Монгол аян"-ны хүрээнд Боловсролын хэлтсээс 3, 4 дүгээр сард өглөө бүр 07.00 – 08.00 цагийн хооронд 35 цэцэрлэгийн 2500 гаруй багш, ажилтан, албан хаагчдад "Багшийн ёс зүй, харилцаа хандлага" сэдвээр сургалт зохион байгуулсан.

"Чингэлтэй чадварлаг багш - 2024" арга хэмжээний хүрээнд багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, чанарын үнэлгээнд суурилсан үнэлэмжийг бодитой болгох үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. Үүнд:

- Чингэлтэй дүүргийн Түүх, нийгмийн ухааны судлагдахууны зөвлөлдөх багийн багш нарын уулзалт хэлэлцүүлэг хийж 1 дүгээр улиралд хийж хэрэгжүүлсэн ажлаа нэгтгэн дүгнэж, хичээлийн хоцрогдлыг арилгах, ЭЕШ-ийн бэлтгэл ажлын хүрээнд агуулгын залгамж холбоог сайжруулах,

орхигдсон агуулгыг нөхөх, сурагчдадаа сэтгэлзүйгээр дэмжиж, хамтран ажиллах зэрэг асуудлаар ярилцан цаашид хийх ажлаа төлөвлөн ажиллаж байна.

Эко боловсрол тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд хөтөлбөрт 246, 291, 108 дугаар цэцэрлэгүүд шинээр хамрагдаж байгууллагын түвшинд эцэг, эх, багш ажилчдад сургалт зохион байгуулсан

- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах үүднээс 7 хоног бүр арга зүйч нарт өглөөний сонсголыг 3 сар хийж, нэгж байгууллагаас санаачлан хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Үүнд: 74 дүгээр цэцэрлэгийн багш Т.Янжмаа "Тоглонгоо суралцах арга зүй", 280 дугаар цэцэрлэг Монгол ёс заншлын тухай сургалт зохион байгуулах технологи, 126 дугаар цэцэрлэг - Амьтан сэдвээр "Төсөлт тоглоом" зохион байгуулах технологи сургалтуудыг дүүргийн багш нарт зохион байгуулсан.

-43 дугаар цэцэрлэг "Хүүхэд хамгаалалд бидний оролцоо" сэдэвт үзүүлэх ажлыг танхимаар зохион байгуулав.

- Удирдах ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ЕБС-ийн сургалтын менежерүүдийн дунд "Удирдах ажилтны ёс зүй" сэдэвт "Шилдэг илтгэл" шалгаруулах эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, 24 дүгээр сургууль, 117 дугаар сургууль, 17 дугаар сургуулийн багууд эхний 3 байрыг эзэлсэн.

- Орос хэлний багш нарын дунд туршлага солилцох өдөрлөг зохион байгуулж, 17 сургуулийн 22 багш оролцов.



- Сургалтын менежерүүдийн зөвлөлдөх багаас туршлага судлах зөвлөгөөн зохион байгуулж, төрийн болон төрийн бус өмчийн сургуулиудын ахлах, дунд ангийн 36 сургалтын менежер хамрагдав.

- Цэцэрлэгийн 84 багшид "Я класс" цахим ангиар дамжуулан давхардсан тоогоор 220 удаагийн сургалтын хөтөлбөр, төлөвлөлтөд заавар зөвлөгөө өгч зөвлөн тусалсан. ЕБС-ийн 19 сургуулийн удирдлага, нягтлан бодогч нарт Төсвийн шинэчлэл, өөрчлөлттэй холбоотой сургалтыг НБГ, БЕГ-тай хамтран сургалтыг явуулсан.

- БШУЯ, БҮТ-тэй хамтран багшийн гүйцэтгэл, үр дүнг үнэлэх түүвэр шалгалтыг зохион байгуулж 1122 багш, 19820 сурагч хамрагдсан.

- "TOEFL JUNIOR" Үндэсний сургагч багш-2022 хөтөлбөрт Чингэлтэй дүүргийн 23 дугаар сургуулийн багш Э. Саранзаяа, 37 дугаар сургуулийн багш З.Заяабаяр нар хамрагдан амжилттай төгссөн.

- 23 дугаар сургууль Хятадын "I study" соёлын төвтэй хамтран БНХАУ-ын Цан Жоу мэргэжлийн технологи коллеж, Си Нан газрын тосны их сургууль, Ан хуй багшийн их сургууль, Жиан Сү технологийн коллеж, Нан Жин мэдээлэл технологийн их сургуультай цахим уулзалт хийж ахлах ангийн ангийн сурагчдад мэргэжил сонголт болон элсэн суралцахтай холбоотой ярилцлага уулзалт хийсэн.

- Тогтвортой хөгжлийн бодлого, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийн ногоон хөгжилд суурилсан хэтийн зорилт, дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий ISO14001 стандартад суурилсан "Олон улсын Эко сургууль, цэцэрлэг" хөтөлбөрт тус дүүргийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургууль "НОГООН ТУГ", 4, 174, 102

дугаар цэцэрлэгүүд "МӨНГӨН ГЭРЭГЭ", 9, 247 дугаар цэцэрлэгүүд "ХҮРЭЛ ГЭРЭГЭ"-ийн болзол ханган батламж авсан. Мөн ISO14001 стандартад суурилсан "Олон улсын Эко-сургууль, цэцэрлэг" хөтөлбөрийн анхан шатны 1 дэх сургалтад 246, 291, 108, 74 дүгээр цэцэрлэгүүдийн "Эко боловсролын зөвлөл"-ийн гишүүд хамрагдаж, анхан шатны сургалтыг багш, ажилчдадаа зохион байгуулсан. 174 дүгээр цэцэрлэгийн "Эко боловсрол" сэдэвт сургалтын хөтөлбөрийн үр дүнг танилцуулсан цахим, "Эко цэцэрлэг" төсөл хэрэгжүүлэн амжилт гаргасан туршлагаа хуваалцах уулзалт тус тус зохион байгуулж, 35 цэцэрлэгийн 480 багш, арга зүйчид 400 туслах багш хамрагдсан.



Боловсролын байгууллагын удирдлага, багш ажилтан туслах багш нарыг төлөвлөгөөт болон захиалгат сургалтууд зохион байгуулж ажиллав. Эрхлэгч арга зүйч нарын НБГ-аас зохион байгуулдаг графикт сургалтад 39 эрхлэгч, 42 арга зүйчид хамрагдав. НТБ-ын төвөөс зохион байгуулсан "Багшийн ёс зүйн" сургалтад нийт 6 цэцэрлэгийн 84 багш ажилтан хамрагдаад байна. Судлагдахуун бүрийн төлөвлөгөөт сургалт сар бүрийн хуваарьт өдөр болж, мэргэжлийн багш нар хамрагдаж хэвшсэн. Ирцийн болон үр дүнгийн мэдээллийг НБГ-аас авч ажилладаг.

Сургалтын менежерүүдийн зөвлөлдөх багаас туршлага судлах зөвлөгөөн 3 сарын 25-нд зохион байгуулж, төрийн болон төрийн бус өмчийн сургуулиудын ахлах, дунд ангийн сургалтын менежерүүд хамрагдав.



- Цэцэрлэгүүдэд Амьдрах ухааны хөтөлбөрөөр сургалт үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор STEAM сургалтын технологи 291 дүгээр цэцэрлэгт, 4 дүгээр цэцэрлэгт Хэл яриа хөгжүүлэх сургалтын хэрэглэгдэхүүний технологи, 126 дугаар цэцэрлэгт Төсөлд суурилсан сургалтын технологи, 74 дүгээр цэцэрлэгт "Тоглонгоо суралцахуй" сургалтын технологи, 280 дугаар цэцэрлэгт Ардын уламжлалт орчин сургалтын технологи тус тус хэрэгжин дүүргийн хэмжээнд үзүүлэх ажил зохион байгууллаа.

- "ШИМТ" сургалтын хөтөлбөрийн сургалтад нийт 54 цэцэрлэгийн багш удирдах ажилтныг хамруулж 11 цэцэрлэг төсөл бичин ШИМТ+ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллан 291 дугаар цэцэрлэг хэрэглэгдэхүүнээ авсан. Мөн 33, 292 дугаар цэцэрлэгүүд Олон улсын Монтесори хөтөлбөрт, 280 дугаар цэцэрлэгүүд "I'm brick" хөтөлбөрт хамрагдан ЧД-ийн засаг даргын дэмжлэгээр сургалтын хэрэглэгдэхүүнээ хүлээн авч сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Эрдэнэс таван толгойн хөрөнгө оруулалтаар 15 цэцэрлэгт Монтесори хөтөлбөрт хамрагдан, танхим байгуулахаар ажиллаж байна.



- Дүүргийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургууль "Sols" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

- Улсын хэмжээнд 40 гаруй сургууль туршилтаар "Sols" хөтөлбөрийг ашиглаж, нийт 100,000 гаруй хэрэглэгчтэй болсон. Тус хөтөлбөрийг Дүүргийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургууль хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр багш нарын шалгалтын материал засах, үнэлэх ажлын ачаалал буурч, багш сурагчид хаана байгаагаас үл хамааран сургалт, шалгалт, гэрийн даалгавар хийх, дүн үнэлгээтэй танилцах, хурал зөвлөгөө зохион байгуулах боломжтой болсон.

- Дүүргийн 25 цэцэрлэгийн 250 багш Google classroom онлайн анги нээн ашигласнаар эцэг, эхчүүд болон бусад багш нартай уулзалт хийж зөвлөн туслах, туршлага солилцох үйл ажиллагааг байгаа орчноосоо зохион байгуулах боломжтой болсон. Тодруулбал Google classroom- аар дамжуулан давхардсан тоогоор 220 удаа сургалт уулзалт зохион байгуулсан.

- Цахим сургуулиудын тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын 24 дүгээр сургуулийн А байрны бүх ангид интернетийн оролтыг оруулж, сургуулийн дотоод сүлжээг сайжруулсан, сургуулийн А байрны нийтийн эзэмшил болон анги танхимд сонсох төхөөрөмж байршуулж, мэдээллийг шууд дамжуулах боломжийг бүрдүүлсэн. Номын сан болон 2 ангид шинээр камер нэмж суурилуулсан. Мэдээлэл зүйн танхимын ширээ сандлыг шинэчлэн тохижуулсан. Багш хөгжлийн төвд Ухаалаг дэлгэцийг шинээр авч байршуулан цахим хичээл бэлтгэх, сургалт зохион байгуулахад ашиглаж байна. Подкаст хийх тоног төхөөрөмжийг Шударга ёсны клубт байршуулж багш сурагчид Подкаст хийж ажиллаж байна.

- Цахим сүлжээнд ашиглах Оффис-365 программыг бүх сургуулиудад хүргэж хандах эрхийг нь өгч сургуулиуд дотооддоо ашиглаж байгаа бөгөөд ЕБС-дын оффис-365 программын админ эрхтэй төлөөллүүд 2 дугаар шатны мэдээллийг сургууль тус бүр дээрээ зохион байгуулсан.

- Цахим дүүрэг болох зорилтын хүрээнд 25 цэцэрлэгийн 250 багш Google classroom онлайн анги нээн эцэг эхчүүдийг урин цахим сургалтын сан бүрдүүлсэн Сар бүр цахим сангийн мэдээллийг авч нийт 60 цахим хичээл, 80 даалгаврын сан, 120 зөвлөгөө зөвлөмжтэй болсон.

- "Гурван тамир" сургуулийн захирал Бат-Эрдэнэ 108 дугаар цэцэрлэгтэй хамтран "Зарраг аппликейшн ашиглаж цахим хичээл бэлтгэх арга зүй" сургалт зохион байгуулж төрийн болон төрийн бус өмчийн 40 цэцэрлэгийн 80 багш хамрагдсан.


- 108 дугаар цэцэрлэг Зарраг аппликейшн ашиглаж цахим хичээл бэлтгэх арга зүйн сургалтад нийт төрийн болон төрийн бус өмчийн 40 цэцэрлэгийн 80 багш хамрагдсан. Сургууль цэцэрлэгийг цахимжуулах ажлын хүрээнд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар ирсэн 5 нөүтбүүк, 29 суурин компьютер, 13 принтерийг нэн шаардлагатай 291, 292, 293, 298, 277, 276,280 дугаар цэцэрлэгүүд, 17 дугаар сургуульд хуваарилав.

### **Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:**

Нийслэлийн засаг даргын нийгмийн хөгжил, боловсрол, эрүүл мэндийн асуудал хариуцсан орлогч даргын 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр баталсан "Онцлох гэр бүл" шалгаруулах удирдамжийн дагуу нийт 8 номинацид 8 материалыг дүүрэгтээ шалгаруулан Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлсэн.

Тэнсэн харгалзах ял, хүмүүжлийн чанартай албадан сургалтад хамрагдах арга хэмжээ авсан 18 хүртэлх насны 4 хүүхдэд нийгмийн ажлын үйлчилгээг хүргэж төлөвлөлтийн дагуу 19 сургалт, нөлөөллийн ажилд хамруулж, ганцаарчилсан уулзалт 15 удаа, ярилцлага болон бүлгийн уулзалтыг 9 удаа хийж шаардлагатай зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.

Өсвөр үеийн хүүхэд, багачуудыг өөрсдийнх нь сонирхлын дагуу хөгжмийн болон мэргэжлийн сургалтын төвд холбон зуучилсан. "Урлагаар төлөвшүүлэхүй" ТББ-тай хамтран Н.Сүхбатыг Солонгос хэлний сургалт, А.Тэлмүүнбаярыг "гитар хөгжмийн ангид, үсчний мэргэжлийн сургалтад Э.Амарсайхан, боксын секцэд Г.Мөнхгэрэл нарыг тус тус холбон зуучилж хамруулсан.



Гэр бүлийн харилцаан дахь жөндөрийн тухай ойлголт, өрхийн гишүүдийн эрх тэгш байдлыг бий болгох, хувь хүнд харилцаа, хандлага, үйлдлээ хянан удирдах чадварыг эзэмшүүлэх, гэр бүл дэх хүүхэд хамгаалалд эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Гэр бүлийн боловсрол олгох сургалт"-ыг Чингэлтэй дүүргийн 1-19, 20, 24 дүгээр хорооны гэр бүлийн хүчирхийллийн давтан дуудлагатай 43 иргэнд 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан.



Сургалтыг "Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалт"-ын сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Мөн "Зөв дадал ТББ"-ын тэргүүн архины хамаарал болон архины хор уршиг, архинаас гарах, татгалзах арга барилд суралцах талаар ойлголт, мэдээлэл өгсөн.

**Үр дүн:** Архинаас татгалзах арга барил, түүний хор уршиг, гэр бүлийн харилцаанд нөлөөлөх сөрөг хандлага, эрсдэлүүдийн талаар мэдлэгтэй болсон.

1.1.1. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд, бага ангийн сурагчид, сургуулийн өмнөх боловсролд суралцагч хүүхдүүдийн эцэг эхчүүдийн дунд хөгжлийн үйлчилгээний хэрэгцээг тодорхойлон, хүртээмжийг нэмэгдүүлэх ажил үйлчилгээ, арга хэмжээний суурь түвшин тодорхойлох зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын 5, 57, 61 дүгээр сургуулийн дунд болон ахлах ангийн тус бүр 15 сурагч, бага ангийн хүүхэдтэй эцэг эх тус бүр 15, сургуулийн өмнөх боловсролын 4, 9, 18 дугаар цэцэрлэгт суралцагч хүүхдүүдийн эцэг эхчүүдтэй фокус бүлгийн ярилцлага хийх ажлыг 2022 дугаар сарын 02 сарын 28-ны өдрөөс эхлэн 03 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл зохион байгуулсан.

**Үр дүн:** ЕБС-ийн ахлах, дунд, бага ангийн сурагчид, Сургуулийн өмнөх боловсролын суралцагч хүүхдүүдийн эцэг эхчүүдийн дунд хөгжлийн үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж хүртээмжийг нэмэгдүүлж, ажил үйлчилгээ, арга хэмжээний суурь түвшин тодорхойлсон.



1.2.3. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, "Дэлхийн Зөн Монгол" Олон улсын байгууллага хоорондын хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд "Дэлхийн Зөн Монгол" Олон Улсын байгууллагаас хэрэгжүүлж буй "Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төсөл"-ийн "Гэрээр айлчлагч" аргачлалыг дүүргийн 7, 12, 16, 17, 19 дүгээр хороодод хэрэгжүүлэх Ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2022 оны А/106 дугаар захирамжаар байгуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Онцгой байдлын хэлтэстэй хамтран өсвөр насны хүүхдүүдийг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлж, эргэн хяналт тавьж, ар гэрт нь зөвлөгөө өгөх, хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл олгож хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлийн хүрээнд: Өсвөр насны хүүхдүүд хууль эрх зүйн мэдээлэл дутмагаас болж сэтгэцэд нөлөөлөх бодис болох шингэрүүлсэн хий, будаг шингэлэгч хэрэглэж мансуурч эрүүл мэндээрээ хохирч, гэмт хэрэгт өртөж хохирох шалтгаан нөхцөл болж байгаатай холбогдуулан сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн хүүхдүүдэд хяналт тавих, эргэн шалгах, урьдчилсан сэргийлэх хэсэгчилсэн арга хэмжээг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон зах, худалдааны төвүүд, хүнсний дэлгүүрүүдээр зохион байгуулан ажилласан.



### 2.1.2. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо

Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч даргаар ахлуулсан Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүнийг 2022 оны 01 сарын 20-ны өдрийн А/31 тоот захирамжаар шинэчлэн байгуулж Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдэд хууль зүйн хорооны журам, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний санал авах албан тоотыг хүргүүлэн төлөвлөгөөг боловсруулан, анхны хурлыг 2022 оны 05 сарын 4-ний өдөр зохион байгуулан ажилласан. Хуралдаанаар 2021 онд хийсэн ажлын тайлан, 2022 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэж, цагдаагийн газраас тус дүүргийн харьяатай удаа дараа гэмт хэрэг зөрчилд холбогдон цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа 11 хүүхдийн материалыг танилцуулан, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэж ажилласан.



Дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Цагдаагийн газар, дүүргийн Онцгой байдлын хэлтэс, дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтран нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй 5 багаар, хяналт шалгалт хийх ажлын удирдамж, төлөвлөгөө, хуваарийн дагуу хяналт, шалгалтын ажлыг 2022 оны 03 сарын 3,4-ний өдрүүдэд дүүргийн хороодын нийт 43 нийтийн эзэмшлийн тоглоомын талбай, 27 сургууль, 57 цэцэрлэг, нийт 127 байршилд хяналт, үнэлгээ, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллаа.



Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж ажиллах, зөрчил дутагдлыг арилгаж ажилласан талаарх тайлан мэдээг 3 дугаар сарын 17-ны өдрийн дотор Ажлын хэсэгт танилцуулан

ажиллах чиглэлийг холбогдох байгууллагууд (Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс)-д албан бичгээр хүргүүлсэн болно.

2.2.2 Засаг даргын 2022 оны 01 сарын 20-ны өдрийн А/31 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийдийн Хүүхэд хамгааллын бодлого, орчны эрсдэлийг үнэлгээ хийх хяналт шалгалтын ажлыг 2022 оны 05 сарын 10-ны өдөр зохион байгуулсан.



2.2.3. НГБХЗХГ-аас ирүүлсэн албан тоотын дагуу дүүргийн нутаг дэвсгэр үйл ажиллагаа явуулж байгаа СӨББ-ын хүүхэд хамгааллын бодлого, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг 2022 оны 05 дугаар сард зохион байгуулж ажилласан.



### Спорт, соёл үрлагийн чиглэлээр:

**Спортын үйл ажиллагааны чиглэлээр:** Чингэлтэй дүүргийн биеийн тамир, спортын хороо 2022 оны хагас жилийн байдлаар Монгол улсын Биеийн тамир, спортын тухай хууль, Ерөнхийлөгчийн "Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай" 2010 оны 53 дугаар зарлиг, Улсын Их Хурлын "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай" 2009 оны 95, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр "Нийтийн биеийн тамир, спортын талаар авах зарим арга хэмжээний тухай" 2009 оны 05, "Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр батлах тухай" 2014 оны 34 дүгээр тогтоол, Засгийн газар болон Нийслэл, дүүргийн нийгэм, эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

✓ Нийтийн Биеийн тамирыг хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор дүүргийн хэмжээнд нийт 47 тэмцээн уралдаан болон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 423 байгууллагын 47,247 тамирчид хамрагдлаа. Үүнд:

✓ Дүүргийн иргэдийг биеийн тамир, спортоор хичээллүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит "Улаанбаатар марафонд нэгдэцгээе" олон улсын гүйлтийн тэмцээн 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр амжилттай зохион



байгуулагдсан ба дүүргийн төрийн болон төрийн бус аж ахуй нэгж байгууллагуудын ажилтан, албан хаагчид, иргэд, сурагчдаас бүрдсэн нийт 2200 гаруй иргэд хамрагдлаа.



Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2022 оны А/39 дүгээр захирамжаар "Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөл" байгуулсан ба 1 дүгээр улиралд Өсвөрийн шигшээ багийн төрлийг сонгох, багш дасгалжуулагч нарын сонгон шалгаруулалтыг явуулах асуудлаар 2 удаа хуралдсан. Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийг спортын 15 төрлөөр хичээллүүлэх шийдвэр гарч, багш дасгалжуулагчдыг сонгон шалгаруулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга болон Биеийн тамир, спортын хорооны даргатай "Хамтран ажиллах гэрээ" байгуулсан. Дүүргийн Засаг даргын зүгээс багш дасгалжуулагч нарт үнэмлэх олгох ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажил бүрэн хангагдсан. Өсвөрийн шигшээ багуудын бэлтгэл сургуулилтыг хуваарийн дагуу тогтмол зохион байгуулж, давхардсан 960 цагийн тоогоор, 800 тамирчин хамрагдсан. Тивийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль 1, ОУ-ын тэмцээнээс алтан медаль 6, мөнгөн медаль 2, хүрэл медаль 1, УАШ тэмцээнээс алтан медаль 32, мөнгөн медаль 25, хүрэл медаль 26, УБХАШ тэмцээнээс алтан медаль 1, мөнгөн медаль 1, хүрэл медаль 2, Нэрэмжит тэмцээнээс алтан медаль 14, мөнгөн медаль 12, хүрэл медаль 5 тус тус хүртэж, нийт 21 удаагийн уралдаан тэмцээнд оролцож нийт 143 багц медаль хүртсэн амжилт үзүүлсэн.

Чингэлтэй дүүргийн өсвөр үеийн таеквондогийн аварга шалгаруулах тэмцээн 3 дугаар сарын 27-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж 14 байгууллагын 90 гаруй тамирчид хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж 1-р байранд 23-р ЕБС, 2-р байранд 24-р ЕБС, 3-р байранд 49-р ЕБС-ийн баг, тамирчид шалгарлаа.



Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар лиг" сагсан бөмбөгийн тэмцээнд Чингэлтэй дүүргийн 117 дугаар сургуулийн С.Үнэнбат дасгалжуулагчтай ахлах насны охид хүрэл медалийн эзэд боллоо.



Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ЕБС-ийн сурагчдын 2022 оны "УЛААНБААТАР ЛИГ" волейболын шигшээ тэмцээнд 9 дүүргийн 38 сургуулийн шилдэг 64 багийн 832 сурагчид оролцлоо. Тус тэмцээнд Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн Г. Жаргалсайхан дасгалжуулагчтай баг тамирчид тэргүүн байр эзэлж аваргын алтан медаль хүртэж өндөр амжилт үзүүллээ. Мөн багш Г. Жаргалсайхан "ШИЛДЭГ ДАСГАЛЖУУЛАГЧ"-аар, тамирчин сурагч Э. Гансүх "ШИЛДЭГ ДОВТЛОГЧ"-оор шалгарлаа.



"Үндэсний спорт"-ын VII их наадмын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг "Мөсний шагайн харваа", "Мөсөн сурын харваа"-ны төрлөөр зохион байгуулж, давхардсан тоогоор 11 багийн 72 тамирчин хамрагдлаа.



Монголын Бүх Ард Түмний спортын их наадмын Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 8 төрлөөр зохион байгуулж 95 байгууллагын 294 тамирчин хамрагдлаа.

Биеийн тамир спортын улсын хороо болон Нийслэл, дүүргээс зохион байгуулсан 4 сургалтад 28 албан хаагчдыг хамрууллаа.



### Соёл урлагийн чиглэлээр:

Соёлын төв нь тайлант улиралд дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Соёлтой иргэн-2024" арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг ханган ажиллаж байна.

Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын 2018 оны "Дүрэм, бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" А/13 тоот тушаалын дагуу Соёлын төв нь 10 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Үндэсний бахархал өв соёлыг иргэдэд түгээн дэлгэрүүлж, соёл урлагийн үйлчилгээгээр дамжуулан сурталчлан таниулах, иргэд олон нийтэд хүргэх, тэдэнд үйлчлэх Соёлын ордон барих ажлыг Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.

"Соёлтой иргэн-2024" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Амар оюуны хөрөнгө оруулалт" ХХК-тай хамтран "Харилцааны соёл, ур чадварыг хөгжүүлэх сургалт"-ыг дүүргийн 7 хороонд зохион байгуулж 86 албан хаагчийг хамруулсан.

"Угийн бичиг хөтлөх арга зүйн сургалт"-ыг зохион байгуулж нийт 103 албан хаагч, иргэдийг хамруулан угийн бичгийн хөтлөх цаашид дэлгэрүүлэн, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгууллаа.

Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны түүхт 30 жилийн ойг угтан "Монгол бүжгийн чуулбар" бүжгийг ЕБС-ын 39 дүгээр сургуулийн 20 хүүхдэд зааж сургав.



### НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР-ТЭТГЭМЖ

"Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын дагуу шаардлага хангасан шинээр зэрэг дэвийн нэмэгдэл авах эрх үүссэн 6 албан хаагчийн судалгааг хүргүүлж, 3 албан хаагч төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ажилдаа идэвх санаачилгатай ажилласан 15 албан хаагчдын цалингийн шатлалыг нэмж ажилласан.

2022 оны эхний хагас жилд [www.ehalamj.mn](http://www.ehalamj.mn) цахим системээр нийт 32490 иргэнд 32,478,627,597.0 төгрөгний тэтгэвэр, тэтгэмжийг дараах байдлаар олгон ажиллалаа.

Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр- 2359 иргэнд 11,562,368,016.0 төгрөг,
- Жирэмсэн эхийн тэтгэмж- 980 иргэнд 564,116,291.0 төгрөг,
- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж- 6592 иргэнд 5,291,579,384.0 төгрөг,
- Ихэр хүүхдийн тэтгэмж- 39 иргэнд 89,000,000.0 төгрөг,
- Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж- 288 иргэнд 464,939,874.0 төгрөг,
- Асаргааны тэтгэмж -2926 иргэнд 4,333,158,410.0 төгрөг,
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж- 2501 иргэнд 2,883,945,622.0 төгрөг,
- Эхийн алдар 1, 2-р зэргийн одон- 8978 иргэнд 6,657,720,000.0 төгрөг,
- Насны хишиг тэтгэмж- 7827 иргэнд 631,800,000.0 төгрөгийн файлыг тус тус үүсгэн, баталгаажуулж, төрийн сан амжилттай илгээн ажиллалаа.

Нийгмийн даатгалын сангийн ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох журмын дагуу шилжилт хөдөлгөөнд хяналт тавин, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст 54 иргэний материалыг шилжүүлэн тооцоо хийж тухай бүрд нь шийдвэрлэн түргэн шуурхай үйлчиллээ. Үүнд:

- Өндөр насны тэтгэвэр-6 иргэн
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр-2 иргэн
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр-46 иргэн

2022 оны хагас жилийн байдлаар олголтоос буцаагдсан нэр данс зөрүүтэй, камын шалгуур хангаагүйгээс болоод олголт хийгдээгүй:

- 2219 үйлчилгээ - 4 иргэний данс хаагдсан
- 1101 үйлчилгээ - 1 иргэний нэр данс зөрсөн
- 1225 үйлчилгээ - 1 иргэний нэр данс зөрсөн
- 2111 үйлчилгээ - 2 иргэн нэр данс зөрсөн, хаагдсан данстай
- 2113 үйлчилгээ - 2 иргэн хаагдсан данстай
- 2218 үйлчилгээ - 2 иргэн хаагдсан данстай
- 2501 үйлчилгээ - 75 хүүхдийн нэрсийн жагсаалтыг хороодын мэргэжилтнүүддээ өгч дансны асуудлыг шийдвэрлүүлэн мөнгийг бүрэн олгуулан ажилласан.

"E-MONGOLIA" нээлттэй хаалганы өдөрлөгийг Төв шуудангийн 1 давхрын танхимд 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдаж, өдөрлөгт ирсэн иргэдэд халамжийн үйлчилгээг үзүүлэн ажиллалаа.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасны дагуу "Хүнсний эрхийн бичиг олгох журам" шинэчлэн батлагдсан. Уг журамд Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд хүнсний эрхийн бичиг олгох босго оноог орон нутагт 310.0, нийслэлд 292.5 ба түүнээс доош байгаа өрхийн гишүүн-иргэнд сард олгох хүнсний эрхийн бичгийн үнийн дүнг нэг хүүхдэд 8000 /найман мянган/ төгрөгөөр, насанд хүрсэн нэг гишүүнд 16000 /арван зургаан мянган/ төгрөгөөр тус тус тогтоосны дагуу олгож байна.

Нийгмийн халамжийн багц хууль, дүрэм, журмын дагуу шинэ хууль журмын өөрчлөлтийн талаар тогтмол мэдээлэл авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, хороо хариуцсан мэргэжилтнүүдэд холбогдох журмын хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч ажилласан. 2022 оны эхний хагас жилийн байдлаар хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан тус дүүргийн зорилтот бүлгийн нийт өрх-иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг түргэн шуурхай, эрүүл ахуй, аюулгүй байдлыг ханган зохион байгуулсан.

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, иргэнийг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн хугацаанд төлүүлэх, өр авлага барагдуулах ажлуудыг зохион байгуулан ажилласны үр дүнд эхний хагас жилийн байдлаар нийгмийн даатгалын санд **167 721,9** сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэхээс **195 208,9** сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг **116.7** хувиар давуулан биелүүлсэн.

№	Сар	Төлөвлөгөө/мян.төг/	Биелэлт/мян.төг/	Хувь
1	1 сар	21 095 454,90	26 103 700,63	124%
2	2 сар	22 455 246,90	28 553 577,64	127%
3	3 сар	32 231 827,60	38 755 447,65	120%
4	4 сар	29 251 877,20	32 521 950,11	111%
5	5 сар	29 853 260,60	36 440 007,03	122%
6	6 сар	32 834 293,60	32 834 293,60	100%
	<b>Д Ү Н</b>	<b>167 721 960,80</b>	<b>195 208 976,66</b>	<b>116%</b>

2022 оны 2 дүгээр улирлын байдлаар нийгмийн даатгалын санд **195 208,9** сая төгрөгийн орлого төвлөрүүлж, **27 100,0** сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагатай гарсан бөгөөд орлогод эзлэх авлагын хэмжээ **13.8** хувь байна.

**Хамралт:**

2022 оны 2 дугаар улирлын байдлаар нийгмийн даатгалд хамрагдаагүй **3 904,3** сая төгрөгийн цалингийн сан бүхий **318** аж ахуйн нэгж байгууллагын албан хүсэлтийг хүлээн авч, нийгмийн даатгалын программд шинээр бүртгэж, мэдээллийг бүрэн оруулж, орлогын байцаагчид хуваарилан ажиллалаа. Албан журмын даатгалд **1570** даатгуулагчийг шинээр хамруулсан.

**Тайлан авах ажлын хүрээнд:**

2022 оны 2 дугаар улиралд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан тооцоо хийсэн **4498** ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тоон гарын үсгээр болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн өдрийн А/182 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтын дагуу хүлээн авч, хянан баталгаажуулан, байгууллага тус бүрээр хавтас нээж зохих журмын дагуу ажиллаж байна.

Вэб программаар илгээсэн зөв тайлан хүлээн авах, даатгуулагчийн мэдээлэл болон регистрийн дугаарыг үнэн зөв оруулах, даатгуулагчийн кодыг зөв сонгож тайлагнахад анхаарч аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчдыг тайлан шалгах цонхыг ашиглан алдаа зөрчилгүй тайлан баталгаажуулах болон холбогдох мэдээ мэдээлэл мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаж байна.

2022 оны 2 дугаар улиралд ажил олгогчоос цалин залруулга, нөхөн тайлан, ажил олгогчийн үйл ажиллагаатай холбоотойгоор нийт **292** албан хүсэлт, даатгуулагч иргэдээс регистр нэгтгэх, даатгуулагчийн үндсэн мэдээлэл засуулахаар нийт **135** хүлээн авч, холбогдох анхан шатны баримтыг үндэслэн хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.

2022 оны 2 улирлын байдлаар нийт **13105** сайн дурын даатгуулагч хамрагдсан байна. Үүнээс шинээр **1182** даатгуулагч, **1401** эхчүүдтэй гэрээ байгуулан ажилласнаар нийгмийн даатгалын санд **1906,6** сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс **1795,6** сая төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг **94** хувиар биелүүлсэн байна.

2022 оны 2 дугаар улиралд "Сайн дураар даатгуулах тухай гэрээ" байгуулсан боловч хуулийн хугацаанд шимтгэлээ төлөөгүй хугацаа хожимдуулан төлсөн **605** даатгуулагчид нийт **68,5** сая төгрөгийн алданги ногдуулж, алдангийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн.

НДЕГ-ын даргын 2020 оны 01 дүгээр сарын 27 өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/11 тоот тушаал, 2020.01.28-ны өдрийн "Шийдвэр хүргүүлэх тухай" 3/175 дугаар тоот албан бичгийн дагуу 0-3 нас хүртэлх хүүхэдтэй эхчүүдийн шимтгэлийн 50 хувийг улсаас төлүүлж, 50 хувийг өөрөө төлөх заалтын дагуу нийт **150** эхчүүдийг шинээр сайн дурын даатгалд хамруулах гэрээ байгуулж ажилласан.

Тус хэлтэс нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан өндөр насны-547, тахир дутуугийн-165, тэжээгчээ алдсаны-47, цэргийн тэтгэвэр авагч 29, нийт 788 даатгуулагчийн баримт материалыг хүлээн авч шинээр тэтгэвэр тогтоон, бүртгэл хөтлөн ажилласан.

2022 оны 2 дугаар улирлын байдлаар тус хэлтэст хөнгөлөлттэй нөхцөлөөр 23, малчнаар 6 иргэн нийт 29 иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байна.

Нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тэтгэвэр тогтоолгож байгаа иргэдэд хүүхэд бүрийн тоогоор 1 жил 6 сарыг нэмэгдүүлэн тэтгэвэр авагч **нийт 336** иргэнд ажилласан жил нэмж тооцон тэтгэвэр тогтоосон.

Тэтгэвэр авагчдын тэтгэвэр олголтын файлыг сар, 7 хоног бүрээр хянаж бэлтгэн харилцагч Төрийн, Хаан, Худалдаа хөгжил, Голомт банкны салбаруудад файлыг дамжуулж тайланг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Иргэд даатгуулагчдад тэтгэвэр олгох нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх талаар арилжааны Төрийн банк, ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банкуудтай хамтран ажиллаж байна.

Сар бүрийн сүүлчийн өдөр Буян компаниас нас барсан тэтгэвэр авагчийн бүртгэлийг авч мэдээллийн санд хөдөлгөөний тэмдэглэл хийн тэтгэврийг зогсоож байна.

Нийгмийн даатгалын тэтгэмжийн сангаас 2022 оны 2 улирлын байдлаар хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 8413 даатгуулагчдад 1 123,1 сая төгрөг олгосон.

Жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 1859 даатгуулагчдад 4 142,3 сая төгрөг олгосон.

Ажилгүйдлийн тэтгэмжийн даатгалын сангаас 617 даатгуулагчдад 1 357,6 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Оршуулгын тэтгэмжид 28 иргэний 28.0 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус хуулийн хугацаанд олгож ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын санд 2022 оны 2 улирлын байдлаар **9812** иргэд даатгуулагчдыг хамруулж **650,0** сая төгрөг төвлөрүүлэхээс **593,9** сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэн **91,3** хувийн биелэлттэй байна.

Шинээр их дээд сургуулийн окутан суралцагч 374 гадаадын иргэн харьяалалгүй 17, ажил хөдөлмөр эрхлээгүй 9483 нийт **9812** даатгуулагч иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, сунгалтыг хийн баталгаажуулав.

Өндөр насны тэтгэвэр авагч 17497, тахир дутуугийн тэтгэвэр авагч 2684, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 903, цэргийн тэтгэвэр авагч 1235, **нийт 22479** иргэний тэтгэврийг цаг хугацаанд нь чирэгдэлгүй түргэн шуурхай олгон ажиллаж байна.

МУ-ын Засгийн газрын 2019 оны 483-р тогтоолоор "Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж, иргэд даатгуулагч нарт тухай бүр зөвлөгөө мэдээлэл өгч, мэдээллийг программд оруулан татвар төлсөн эсэхийг нягтлан шалгаж, нийт 7 иргэнийг нөхөн даатгалд хамруулж, 9,156,000 мянган төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж ажилласан.

Нийгмийн даатгалын тэтгэмжийн сангаас 2022 оны эхний хагас жилийн байдлаар хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 2257 даатгуулагчдад 511,239.51 мянган төгрөг олгосон.

Жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 2183 даатгуулагчдад 4,696,512.55 мянган төгрөг олгосон.

Ажилгүйдлийн тэтгэмжийн даатгалын сангаас 599 даатгуулагчдад 1,292,265.12 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Оршуулгын тэтгэмжид 21 иргэний 21,000,000 төгрөгийн тэтгэмжийг тус тус хуулийн хугацаанд олгож ажилласан байна.

Тайланг хугацаанд нийт 69 ажил олгогчийг шалган 32749,3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж акт тогтоон, 8472,9 мянган төгрөгийн алданги тооцож, нийт 41222,2 мянган төгрөгийн, ажилгүйдлийн даатгалын сангаас илүү тэтгэмж олгогдсон 9 даатгуулагчийн 5784,9 мянган төгрөг, мөн тэтгэврийн даатгалын сангаас илүү тэтгэвэр олгосон 11

тэтгэвэр авагчийн 89979,5 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлэн нийт 95,764,4 мянган төгрөгийн төлбөрийг улсын байцаагчийн акт тавьж 57,458,6 мянган төгрөгийг барагдуулан ажиллаж байна.

### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР:**

Чингэлтэй дүүргийн Эрүүл Мэндийн Төв нь дүүргийн 19 хорооны 156417 хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан, хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг Нарийн мэргэжлийн Төв салбар, Хүүхдийн салбар нийт 2 амбулатори, Гэмтэл, мэс заслын 1 тасаг, Хэвтэн эмчлүүлэх 252 ортой Нэгдсэн эмнэлэг, дүүргийн 24 хорооны 16 Өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан хүргэж байна.

Эмнэлгийн дээд мэргэжилтэн их эмч 106, эмнэлгийн дунд мэргэжилтэн 146, бусад туслах болон үйлчилгээний ажилтан 116, зөвлөх 7, нийт 375 ажиллагсадтайгаар ажиллаж байна.

ЭМТ-ийн Төв, Хайлааст, Бага тойруу, Хайлааст хүүхдийн салбар болон нэгдсэн эмнэлэгт, мөн 16-н ӨЭМТ-үүдэд цахим бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.

### **Төв салбарын үйл ажиллагаа**

Төв салбар нь нарийн мэргэжлийн чиглэлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг Нарийн мэргэжлийн кабинет-20, Их эмч-50, Сувилагч-30 Үйлчилгээний ажилтан-7 гэсэн бүрэлдэхүүнтэйгээр дүүргийн иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, шуурхай, чирэгдэлгүй үзүүлж байна.

Эрүүл мэндийн төвийн ажилтнуудад ажлын үр дүн гүйцэтгэлийг нь харгалзан улирал тутам олгох мөнгөн урамшууллыг тооцон олгох журмыг Эрүүл мэндийн төвийн даргын А/62 дугаар тушаалаар батлуулж, нийт ажилтнуудад танилцуулан үр дүнгийн урамшууллыг тооцон олгож байна.

Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн зэрэг хамгаалах нөхцөлийг бүрдүүлж Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу мэргэжлийн зэрэг хамгаалах ажилтнуудад шалгалтын үеэр цалинтай 7 хоногийн чөлөөг олгодог. Байгууллагын мэргэжлийн зэрэгтэй ажилтнууд жилээс жилд нэмэгдэж байна. Үүнд:

2022 оны хагас жилийн байдлаар:

- Тэргүүлэх зэрэгтэй их эмч -10
- Ахлах зэрэг хамгаалсан эмч-29
- Зөвлөх зэрэгтэй сувилагч -2
- Тэргүүлэх зэрэгтэй сувилагч, тусгай мэргэжилтэн - 13
- Ахлах зэрэгтэй сувилагч, тусгай мэргэжилтэн - 28

Тэргүүлэх зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 23, зөвлөх зэрэгтэй сувилагч 2, ахлах зэрэгтэй 57 эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 82 ажилтан мэргэжлийн зэргийн нэмэгдлээ авч ажиллаж байна. Зөвлөх зэрэг 20%, тэргүүлэх зэрэг 15%, ахлах зэрэг 10%-ийн үндсэн цалингийн нэмэгдэл олгодог.

### **ЦАХИМ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ**

- 1.1. ЧД-н ЭМТ-ийн даргын 2014 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр "Цахим бүртгэлийн ажиллах журам" батлуулж, цахим бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.
- 1.2. НЭМГ-ын даргын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн "Үзлэгийн цаг захиалгын үйлчилгээ нэвтрүүлэх бэлэн байдлыг хангуулах тухай" 02 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор эмчийн үзлэгийн цаг захиалгын дуудлагын нэгдсэн төвд ЧД-н ЭМТ-өөс 1 ажилтныг томилон ажиллаж байна.
- 1.3. Эрүүл мэндийн төвийн амбулаторийн тусламж үйлчилгээний хүлээгдлийг бууруулах, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж буй иргэдэд цаг захиалгын 6 сувгаар дамжуулан эмчийн үзлэгийн цаг захиалах болон эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаж байна. Үүнд:

✓ Дуудлагын нэгдсэн төв-18000119

- ✓ ЭМТ-ийн салбар амбулаториудын цахим бүртгэл
- ✓ ЭМТ-ийн амбулаторийн үзлэгийн цаг захиалгын утас- 70116761
- ✓ Эрт элрүүлгийн цаг захиалгын утас- 77227766
- ✓ Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн Chemn.moh.gov.mn веб сайт
- ✓ Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв фейсбүүк хуудас

1.4. ЭМТ-ийн цахим бүртгэлийн үйлчилгээнд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 06 сарын 07-ны байдлаар:

- ✓ Амбулаторийн үзлэг– 106,943
- ✓ Хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгч- 4950
- ✓ Дүрс оношилгоо – 30,705
- ✓ Яаралтай тусламж /Том хүн/- 4,089
- ✓ Яаралтай тусламж /Хүүхэд/- 9,166
- ✓ Лабораторийн – 54,648 хүн хамрагдсан байна.

1.5. Иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, үйлчлүүлэгчдийн гомдол мэдээллийг хүлээн авах зорилгоор дараах нээлттэй утсыг ажиллуулж хэвшсэн. Үүнд:

- ✓ Хүүхдийн эмчийн зөвлөгөө өгөх утас: 70110715 (ажлын өдөрт 08.30-22.00 цаг)
- ✓ Төв салбарын Чанарын лавлагаа үйлчилгээний ажилтан 11-314587 утсаар ажлын 8 цагаар санал хүсэлт хүлээн авах
- ✓ Цахим бүртгэл ажилтан 70117162 утсаар үйлчилгээний цаг захиалах, лавлагаа, мэдээлэл өгөх
- ✓ Насанд хүрэгчдийн яаралтай тусламжийн үйлчилгээ авах талаар 70110279 утсаар 24 цагийн турш лавлагаа, мэдээлэл өгөх
- ✓ Хүүхдийн яаралтай тусламжийн үйлчилгээ авах талаар 70110278 утсаар 24 цагийн турш лавлагаа, мэдээлэл өгөх
- ✓ Гэрийн сувилахуйн тусламжийг өрхийн эмнэлгээр дамжуулан үзүүлж байгаа бөгөөд эрүүл мэндийн 4,5 дугаар бүлгийн ахмад настнуудад сар графикайн дагуу утсаар зөвлөгөө өгч шаардлагатай тохиолдолд гэрийн сувилахуйн тусламжийг үзүүлэн ажиллаж байна.
- ✓ Үүнд 4,5 бүлгийн нийт 1865 ахмадыг утсаар ярьж хяналтыг хийж гэрээр 198 ахмадад өдрийн эмчилгээ болон сувилахуйн тусламжийг үзүүлсэн.
- ✓ Хөнгөвчлөх эмчилгээг нэгдсэн эмнэлгийн хөнгөвчлөх эмчилгээний тасгаар дамжуулан нийт 24 хүнд сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлсэн.
- ✓ Хавдар, хими эмчилгээний эмч жирэмсний амралт авсантай холбоотойгоор 2022 онд хими эмчилгээ хийгдээгүй.
- ✓ Гэрээр дараах сувилахуйн тусламжийг үзүүлсэн.

**Үүнд:**

✓ Шээлгүүр тавих, цэвэрлэх, авах	4
✓ Хэсэгчилсэн угаалга	85
✓ Бариа бумба	75
✓ Эмчилгээ	35
✓ Байрлал солих	98
✓ Амин үзүүлэлт үзэх	296
✓ Зөвлөгөө	358



✓ Цэвэрлэх бургуй

25

Гэрээр сувилахуйн тусламжийг үзүүлэн тушаал зааврын дагуу анхан шатны маягтыг хөтөлж хэвшсэн бөгөөд сувилгааны түүхийг хөтлөн сувилгааны онош төлөвлөлтийг хийн үр дүнг тооцон ажиллаж байна.

**Хүүхдийн кабинет**

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 43 дугаар тушаалын дагуу Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын А/33 тоот тушаалыг батлуулан Эрүүл мэндийн төвд хүүхдийн кабинетыг уртасгасан цагаар ажлын өдрүүдэд 22:00 цаг хүртэл, ням гарагт 10:00-17:00, өрхийн эрүүл мэндийн төвүүд бямба гарагт 10:00-17:00 цагийн хооронд хуваарийн дагуу ажиллахаар төлөвлөж, Эрүүл мэндийн төвийн 2 эмч, 2 сувиллагч, Өрхийн эрүүл мэндийн төвийн 16 эмчийг үүрэгжүүлэн томилон ажилласан.

**Нөхөн үржихүйн кабинет**

ЭМТ-өөс 1-19, 20, 24 дүгээр хороодын 38191-н нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл судалгааг хамтран шинэчлэн хянан ажиллаж байна. ЧД-ийн эмэгтэйчүүдийн эмч нар сард 1 удаа өрхийн эмнэлэг дээр очиж урьдчилан сэргийлэх үзлэгийн зохион байгуулсан. Нэг цэгийн цогцолборт нийт 2022 онд 2098-2250 жирэмсэн хяналтад авсан, Түр оршин суугч 88 жирэмсэн харьяа нутаг дэвсгэрийн өрхийн эмчийн хяналтад авсан. Үүнээс:

- Нийт үзлэг-14010
- Өвчний учир-2984
- Төрсөн эх-1340
- Нийт жирэмсэн эх-2039
- Эрүүл жирэмсэн эх-420
- Өртөмхий бүлгийн жирэмсэн эх-1678
- Онцгой жирэмсэн эх-148
- Цусны шинжилгээ хамрагдсан-1621
- Хяналтгүй төрөлт 12%-0.24%
- Гэрийн төрөлт-0.49%-0.17%
- Амьгүй төрөлт-4.88%-4.8%
- Жирэмсний эрт хяналт-90.2%-н үзүүлэлттэй байна.

**Сүрьеэгийн кабинет**

Нийт сүрьеэгийн тохиолдол 107 илэрсэн ба эмчилгээний амжилт 88%-тай байна. Шинээр илэрсэн сүрьеэгийн тохиолдол 79 бүртгэгдсэнийг онлайн эмчилгээнд бүрэн хамруулсан. Олон эмд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөн 2, цөөн эмд тэсвэртэй 3 илэрснийг 100% эмчилгээнд хамруулж, эмчийн идэвхтэй хяналтад хянаж байна.

Цэрний түрхцийн шинжилгээгээр 577 шинжилгээ хийгдэж 37 тохиолдол илэрч, эмчилгээнд бүрэн хамруулсан. Gxpert шинжилгээнд 412 хийгдэж 48 МТВ-илрүүлсэн.

Шууд хяналттай харж уулгах эмчилгээнд хамрагдаж буй сүрьеэтэй өвчтөний тоо- 142

- Уушгины -98
- Уушгины бус -44
- Диспансерт -76
- Өдрийн эмчилгээний цэгт-21
- Өрхийн эмнэлэгт-11
- Сайн дурын ажилтнаар-55
- Цахимаар 18 өвчтөн эмчилгээг зөвлөмжийн дагуу авч эмээ дамжуулан ууж байна.

Эмд тэсвэртэй сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлыг 100% эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээнд хамруулж үүнээс олон эмд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөн 2, цөөн эмд тэсвэртэй 3

тохиолдол илэрснийг 100% эмчилгээнд хамруулж, эмчийн идэвхтэй хяналтад хянаж байна. Дэмжлэгт хяналт ХӨСҮТ-ээс 2 удаа дэмжлэгт хяналт хийгдсэн.

Чингэлтэй дүүргийн Сүрьеэгийн диспансерт эмд тэсвэртэй сүрьеэтэй 5 өвчтөнийг эмч нарын зөвлөгөөнд оруулж эмчилгээний асуудлыг шийдвэрлэсэн. Шинээр эмчилгээнд 3 өвчтөнийг, 2 өвчтөнийг үр дүн тооцуулж шийдвэрлүүлсэн. ХӨСҮТ-ийн эмч нарын зөвлөгөөнд нийт 7 өвчтөнийг эмчилгээний асуудал шийдвэрлүүлсэн.

#### 📌 ДОХ/БЗХӨ-ны кабинет

БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинет нь 2022 оны хагас жилийн байдлаар нийт 6279 үзлэг хийсэн. Үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 5366 (85,4-%) диспансерын хяналтын үзлэг 188, амбулаторийн үзлэг 448, шинээр хяналтад авсан өвчлөл 188, үүнээс эрүүлжилт 148 (78,8%) байна.

#### Халдвартын кабинет

##### 📌 Халдвартын кабинет

Нийт үзлэг-2571 иргэн хамрагдсан. Хурц халдварт өвчний үзлэгээр 67 хүн ирснээс халдварт шар өвчнөөр 1 хүн, гар хөл амны өвчнөөр 14 хүн, салхин цэцэг өвчнөөр 26 хүн, гахайн хавдар 1 хүн, улаан эсэргэнэ 1 хүн, бруцеллэз 1 хүн, хачигт халдвараар 2 хүн, ёлом өвчний шинжтэй 1 хүн тус тус оношлогдсон байна. Шинээр 12 хүнд хөдөлмөр зохицуулалт хийсэн. 2022 оны эхний хагас жилийн байдлаар В вирусийн эмчилгээнд 76 хүн, С вирусийн эмчилгээнд 3 хүн хамрагдаж байна.

##### Өсвөр үеийн кабинет

Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн байдал. Үүнд:

- Нийт үзлэг – 2194.
- Урьдчилан сэргийлэх үзлэг – 27
- Өвчний учир амбулатори – 2165
- Эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай 31 хүүхэд, өсвөр үеийнхэнд зөвлөгөө өгөх үйлчилгээг тус тус үзүүлсэн байна.

№	Үзүүлэлт	2021 оны эхний хагас		2022 оны эхний хагас		
		Тоо	Хувь	тоо	хувь	
1	Нийт үзлэг	876	-	2194	-	
2	Үүнээс:	Амбулатори	89,9		2165	98,6
		Урьдчилан сэргийлэх-27	10,0		27	1,4
		Сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн	12		31	-
3	Халдварт бус өвчлөл шинээр	281	37,6	512	23,3	
4	Эмчлэн эрүүлжсэн хүүхэд өсвөр үе	823	93,9	2118	96,5	
5	Дараагийн шатны тусламж үйлчилгээнд хамрагдсан	63	-	76		
6	Охидын жирэмслэлт: (15-19 насны 1000 охидод)	8	-	3		

6	сургалт, сурталчилгаа бусад үйл ажиллагаанд хамрагдсан өсвөр үеийнхэн	118	-	2101	
7	Өсвөр үеийнхний дунд зохион байгуулсан үйл ажиллагаа, арга хэмжээний тоо	2	-	3	

### ХҮНС, ХУДАЛДААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

1.1.Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/699, А/496, А/295, А/555 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны 01/40, 05/82, 01/106, 01/292, 01/447, 01/452, 01/685, 05/151, 01/470 дугаартай албан бичиг, А/18 А/34, А/218, А/79, А/106 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2022 оны А/67, А/199, А/197, А/102, А/176, А/205 дүгээр захирамжийн хэрэгжилтийг ханган ажилласан.

1.2. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний дүүргийн Засаг даргын Тамгын газрын (цаашид "ЗДТГ" гэх) Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст (цаашид "ХХҮХ" гэх) хамаарах 3 зорилтын 19 заалтын хэрэгжилт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 90%-ийн биелэлттэй дүгнэгдлээ.

1.3.Тайлант хугацаанд Нийслэлийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн 14, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн шуурхай зөвлөгөөнөөс өгсөн 35 нийт 32 үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж, 90%-тай дүгнүүлээ.

1.4.Дүүргийн Засаг даргын Тамгын газрын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хэлтэст хамаарах 6 зорилтын 11 заалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2022 оны хагас жилийн байдлаар 90%-ийн гүйцэтгэлтэй байна.

2022 оны "Нийслэлийн хүн амын махны тогтвортой хангамжийг бүрдүүлэх талаар авах арга хэмжээний тухай", А/218 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилгын хүрээнд нөөцийн мах худалдан борлуулах бэлтгэл хангасан 51 аж ахуйн нэгж "АГРО НЭГТГЭЛ ТРЕЙД ХХК", "ХКҮ ХХК", "НАТУРАЛ ГРАСС ЛАНД ХХК", МОН МИЙТ РЕЙД ХХК зэрэг дөрвөн компанитай "Бэлтгэн нийлүүлэгч, агентын гэрээ"-г 2022 оны 03 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд дүүргийн Засаг даргын тамгын газрын хурлын зааланд зохион байгуулав.

Нөөцийн мах худалдан борлуулах бэлтгэл ажлыг хангуулахаар хүнсний дэлгүүрүүдэд мэдээлэл өгөн нийлүүлэгч компанитай хамтран гэрээ хийлээ. Хүн амын хаврын улирлын хэрэгцээнд нийлүүлэгдэх махны хэмжээг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Татварын газартай хамтран И баримт олгох, пос терминал буюу кассын машины системийн хөгжүүлэлт, цахим төлбөрийн системд мэдээллийг цаг хугацаанд нь илгээх талаар нөөцийн мах худалдан борлуулах хүнсний дэлгүүрүүдэд мэдээллийг хүргүүлэн ажилласан. Дүүргийн 1-19, 20,24 дүгээр хорооны 51 хүнсний дэлгүүрүүдэд нөөцийн мах нийлүүлэх гэрээ бүхий 4 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах бэлтгэлийг хангуулан, борлуулалтыг гүйцэтгүүлэн ажиллалаа.

Мөн Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны Хүнс худалдаа үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсээс нөөцийн махны худалдан борлуулах хүсэлтэй аж ахуйн нэгжийн судалгааг ирүүл гэсний дагуу нөөцийн махны худалдаа эрхлэх хүсэлтэй 14 аж ахуйн жагсаалтыг батлуулж нийт 65 аж ахуйн нэгж байгууллага нөөцийн мах худалдан борлуулалт хийж байна. Нөөцийн махны худалдааны мэдээг 7 хоног бүрийн пүрэв гаригт нийслэлийн хүнс худалдаа үйлдвэр үйлчилгээний хэлтэст 8 удаагийн татан авалтаар нийт 93,8 тн махыг худалдан борлуулсан мэдээг хүргүүлэн ажиллаж байна.

Нийт байшин хорооллын нийт 417 аж ахуй нэгж, үйлчилгээний байгууллагаас судалгаа авч саналын хуудсыг нэгтгэн дүгнэхэд хүнс болон барааны дэлгүүр 08:00-22:00 цагийн хооронд, ажиллах саналыг ирүүлсэн байсан бөгөөд бусад үйлчилгээний газрууд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас ирүүлсэн саналыг дэмжсэн байна.

#### **Хөдөө аж ахуйн чиглэлээр:**

2022 оны "Нийслэлийн хүн амын махны хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах талаар авах зарим арга хэмжээний тогтвортой байлгах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/18 дугаар тушаалын хэрэгжилт, нөөцийн мах худалдан борлуулах бэлтгэл ажиллагааг хангах, тавигдах шаардлагын хэрэгжилт, хөргөгч хөлдөөгчийн багтаамж, нөөцлөх боломжтой махны хэмжээ, эрүүл ахуй аюулгүй байдал стандартын шаардлага хангасан эсэхэд хяналт тавьж ажиллалаа. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан удирдамжийн дагуу чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт нөөцийн мах худалдан борлуулах хүнсний дэлгүүрүүдийн 20 хувийг шалгалтад түүвэрлэн хамруулж 4, 6, 9, 10, 12, 15, 17 дугаар хорооны нийт 9 дэлгүүрт Нийслэлийн

Хүнс, хөдөө аж ахуйн газар, Чингэлтэй дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Чингэлтэй дүүргийн татварын хэлтэстэй хамтран 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа. Мөн Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны Хүнс хөдөө аж ахуй, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хэлтэстэй хамтран 2 удаагийн зөвлөн туслах шалгалтыг хийж ажилласан.

Шалгалтаар жин хэмжүүр нь баталгаажилтгүй, баталгааны хугацаа дууссан, худалдаа эрхлэгч нь эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдаагүй зориулалтын дүрэмт хувцас өмсөж хэвшээгүй зэрэг нийтлэг зөрчил илэрснийг арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар өгч мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн



#### ***Дүүргийн 7-19 дүгээр хороо буюу /Гэр хороолол/***

Цагийн хязгаарыг тогтоох тухай 368 аж ахуйн нэгж байгууллага 512 иргэнээс цаасаар болон цахимаар саналыг авч ажиллалаа.



Гэр хорооллын иргэн, аж ахуйн нэгж байгууллын цагийн хязгаарыг тогтоох саналыг нэгтгэн дүгнэхэд:

- Баар 15:00-24:00
- Ресторан 08:00-24:00
- Кафе 08:00-24:00
- Хүнсний зах худалдааны төв 07:00-22:00
- Хүнсний бус барааны худалдааны төв 08:00-22:00
- Хүнсний мухлаг, ТҮЦ 08:00-24:00
- Нийтийн ахуй үйлчилгээ 07:24:00
- Саун 24 цагаар
- Авто засварын үйлчилгээ 08:24:00
- Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ 06:00-24:00
- Хүнс, барааны дэлгүүрийг 08:00-22:00 цагийн хооронд ажиллуулах саналыг ирүүлсэн байна.

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлчилгээний газруудын үйлчилгээ эрхлэх цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ, ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 31 иргэн, аж ахуй нэгж, байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 14:00 цагт зохион байгуулан нийт газруудын цагийн хязгаарын төсөлд саналыг авч ажиллалаа. Хэлэлцүүлгийн явцад нийт 3 санал гарсан.

**Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр:**

"Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль", "Төрийн албаны тухай хууль", "Хөдөлмөрийн тухай хууль", "Төсвийн тухай хууль", Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан "Чингэлтэй дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв"-ийн дүрэм, "Хөдөлмөрийн дотоод журам"-ын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан.

Нутгийн Захиргааны байгууллагаас иргэдэд үзүүлж буй төрийн ажил үйлчилгээний бодлого зорилтын хүрээнд "Чингэлтэй дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв"-өөс 2022 онд зохион байгуулах үйл ажиллагааны 3 бүлэг 31 заалт бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг Дүүргийн Засаг даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Дүүргийн бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүний сурталчлан, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор "Чингэлтэйд үйлдвэрлэв" байнгын худалдааны цэгийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг ханган, эхний хагас жилийн байдлаар үндэсний болон европ хувцас, бэлэг дурсгал, сүлжмэл, модон эдлэл, арьсан эдлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 60 үйлдвэрлэгчийн 15 нэр төрлийн нийт 2144

ширхэг бараа бүтээгдэхүүн борлуулагдаж, **113,329,700** төгрөгийн борлуулалтын орлого орсон үр дүнтэй байна.



Үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх, түншлэл хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор "Сар шинэ-2022", "Их Хотын Хавар-2022, Нээлттэй хаалганы өдөрлөгийн арга хэмжээний хүрээнд "Чингэлтэйд үйлдвэрлэв", "Амралтын өдрийн худалдаа", "Эх үрсийн баяр", "Жаргалтай инээмсэглэл" нийт 6 удаагийн үзэсгэлэн худалдаанд **110** үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулж **41,322,000** төгрөгийн бараа бүтээгдэхүүн борлуулсан үзүүлэлттэй байна.



Дүүргийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг үйлдвэрлэлээ явуулах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, тогтвортой ажиллах нөхцөл боломжийг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх хүрээнд 123 зөөврийн ажлын байрыг үйлдвэрлэгчдэд үнэ төлбөргүй 2016 оноос эхлэн ашиглуулж байгаа бөгөөд тус төвийн "Зөөврийн ажлын байранд үйлдвэрлэгч сонгон шалгаруулах, хамтран ажиллах журам" болон Зөөврийн ажлын байр үнэ төлбөргүй ашиглах үйлдвэрлэгчтэй хамтран ажиллах гэрээний дагуу

хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг төвийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар байгуулж, хэрэгжилтийг хангаж, ажлын хэсгийн шалгалтаар үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа 110, зориулалтын дагуу ашиглаагүй, үйл ажиллагаа явуулахгүй байгаа 8 зөөврийн ажлын байрны зөрчлийг илрүүлэн ашиглалтыг зориулалтын дагуу болгох мэдэгдэл хүргүүлж, зөөврийн ажлын байрыг сонгон шалгаруулах журмын дагуу шалгуур үзүүлэлтийг хангасан 5 үйлдвэрлэгчид шилжүүлж, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллаж байна.

Зөөврийн ажлын байрны сонгон шалгаруулалтад тэнцсэн үйлдвэр эрхлэгчдэд ажлын байрыг шилжүүлэн тээврийн зардлыг иргэнээс гаргуулан хашаанд нь байршуулсан.

- 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр 10 дугаар хорооны үйлдвэрлэгч Д.Бат-Очирт,
- 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр 19 дүгээр хорооны үйлдвэрлэл эрхлэгч Б.Энхзаяад,
- 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр 16 дугаар хорооны үйлдвэр эрхлэгч Д.Сүх-Очирт,
- 2022 оны 04 сарын 28-ний өдөр 19 дүгээр хорооны үйлдвэрлэл эрхлэгч П.Нансалмаад,
- 2022 оны 05 сарын 11-ний өдөр 16 дугаар хорооны үйлдвэрлэл эрхлэгч Алтанхуяг



"Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв" НӨҮГ, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр "Шинэ дэд төв"-тэй хамтран "Зээлийн материал бүрдүүлэлт, анхаарах зүйлс" сэдэвт сургалтыг Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийн хөгжлийн төвд зохион байгууллаа. Тус сургалтад 26 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хамрагдаж хөдөлмөрийн зах зээлийн 70 хувийг бүрдүүлдэг ЖДҮ эрхлэгчид "Хүсэл үү, хэрэгцээ юу, хувь хүний санхүүгээ хэрхэн зөв удирдах вэ" сэдвээр олон талын мэдлэг, мэдээллийг олж авсан үр дүнтэй сургалт боллоо.

#### **Тохижилт, нийтийн аж ахуйн чиглэлээр:**

Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр Агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилго бүхий "Ногоон дүүрэг 2024" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус хэлтэс нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас хэлтсийн эрхлэх асуудал, үйл ажиллагаатай холбоотой ирсэн санал хүсэлт, гомдлыг судалж, холбогдох байгууллагуудтай хамтран шуурхай шийдвэрлэж, Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Нийслэл, дүүргийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, шийдвэрийг нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд сурталчлах, хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 12 дугаар хорооны Өрхийн эмнэлгийн үүдний тохижилтын ажлыг "Би Жи Роял" ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд 45м<sup>2</sup> явган зам, 50м<sup>2</sup> зүлэг, 15 улиас, 35у/м хайлаас, 2 сүүдрэвч, 2 хогийн сав, 2 нарны зайн гэрэлтүүлэг тус тус хийж гүйцэтгэсэн.

Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр Чингэлтэй дүүргийн Тохижилт Үйлчилгээ ХХК-тай хамтран 1 дүгээр хороо 35 дугаар байрны дундах 345м<sup>2</sup> явган зам, 24м<sup>2</sup> бетоны ажил тус тус хийж гүйцэтгээд байна.

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын гадна хашааг "Би Жи Роял" ХХК зураг төсвийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны А/79 дүгээр тушаалын дагуу Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дэх согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, хоолй үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад хболбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, стандартын шаардлагыг хангуулах орчны 50 метрийн тохижилт, гадна фасад, гэрэлтүүлийг, хаягжилтыг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр аттестатчилах удирдамжийн дагуу 77 аж ахуй нэгжүүдээр үзлэг шалгалтыг Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэстэй хамтран зохион байгуулан ажиллаж байна.



Тус дүүргийн хэмжээнд 168 гараж буулгахаар төлөвлөснөөс одоогоор Дүүргийн Газар зохион байгуулалтын албанаас 143 гараж буулгаад байгаа бөгөөд 11 байршилд Хот байгуулалт хөгжлийн газраас ажлын даалгавар гаргуулан тохижилтын ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.





Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.1.113 "Ногоон байгууламж, тоглоомын талбай" /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, XII.1.141 Хороо, дүүргийн орчныг тохижуулах "Жишиг гудамж" тохижилтын төсөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, төсөл арга хэмжээ тус бүрийн байршил, ажлын тоо хэмжээг Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлэн тендер зарлахад бэлтгэл ажил хангагдсан.

XII.1.113 "Ногоон байгууламж, тоглоомын талбай"

- 1 дүгээр хороо, Мэргэжлийн 100 дугаар байрны урд хоосон талбай
- 3 дугаар хороо, 15, 16 дугаар байрны дундах байрны тохижилт
- 4 дүгээр хороо, 41, 46 дугаар байрны дундах хоосон талбайг тохижуулах
- 12 дугаар хороо Булгийн 11 дүгээр гудамжны гадна талбайн тохижилт
- 16 дугаар хороо Хоймор хайрхны амралтын газрын гадна тохижилт
- 16 дугаар хороо Жижиг дунд үйлдвэрлэлийн гадна талбайн тохижилт
- 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт Авто баазын гадна тохижилт
- 19 дүгээр хороо Зуун модны зуслангийн тохижилт

XII.1.141 Хороо, дүүргийн орчныг тохижуулах "Жишиг гудамж" тохижилтын төсөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/

- 7 дугаар хороо Хувьсгалчдын Г-10, 14, 15 дугаар гудамж
- 10 дугаар хороо Дэнжийн 33, 42 дугаар гудамж
- 10 дугаар хороо Чингэлтэй 6 хэсэгт 15 гудамж

**Авто замын чиглэлээр хийгдсэн ажлын хүрээнд:**

Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн "Сурагчийн 24 дүгээр гудамжны авто зам" төсөл, арга хэмжээний хүрээнд 150 у/м авто замын ажлыг "Хайрхан уулын зам" ХХК хийж гүйцэтгэсэн.



Дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн "Гудамж сайжруулах-11 дүгээр хороо" төсөл, арга хэмжээний хүрээнд Нуурын 15 дугаар гудамжинд нийт 123 у/м авто замын ажлыг "Баянцогт зам" ХХК хийж гүйцэтгэсэн.



Дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн "Гудамж сайжруулах-14 дүгээр хороо" төсөл, арга хэмжээний хүрээнд Хайлааст 24 дүгээр гудамжинд нийт 130 у/м авто замын ажлыг "Баянцогт зам" ХХК хийж гүйцэтгэсэн.



Дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн "Гудамж сайжруулах-15 дугаар хороо" төсөл, арга хэмжээний хүрээнд Жаргалантын 62 дугаар гудамжинд нийт 90 у/м авто замын ажлыг "Нано экологи" ХХК хийж гүйцэтгэсэн.

Дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө



орруулалтаар хэрэгжүүлсэн "Гудамж сайжруулах-16 дугаар хороо" төсөл, арга хэмжээний хүрээнд Согоот 49 дүгээр гудамжинд нийт 265 у/м авто замын ажлыг "Норовтүн" ХХК хийж гүйцэтгэсэн.

Дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн "Гудамж сайжруулах-19 дүгээр хороо" төсөл, арга хэмжээний хүрээнд

Зээлийн 1, Тахилт 4 дүгээр гудамжинд нийт 160 у/м авто замын ажлыг "Нано экологи" ХХК хийж гүйцэтгэсэн.

Дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрийн Сургуулийн 9 дүгээр гудамжинд 12 дугаар хороо, 13 дугаар хорооны авто замтай холбогдсон 50 у/м авто замын ажлыг "Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ" ХХК дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн.



Дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрийн Спорт хороо, хорооны цогцолбор байр хүртэлх 138 у/м авто замын ажлыг "Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ" ХХК дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн.



Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан болон Дүүргийн төсвийн хөрөнгө, дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр нийт 1106 у/м авто замын ажил хийгдэж дуусгасан.

Дүүргийн нутаг дэвсгэр дэх Баруун Сэлбийн гудамж, Их дэлгүүрийн зүүн урд талын



уулзвараас "Тэди" төвийн зүүн хойд уулзвар хүртэлх 610 у/м авто замын засвар шинэчлэлтийн ажлыг Нийслэлийн Замын хөгжлийн газраас хийж гүйцэтгүүлсэн. Дүүргийн нутаг дэвсгэр дэх С.Чоймболын



гудамж, Энхтайваны өргөн чөлөөнөөс хойш Их тойруу хүртэлх 320 у/м авто замын засвар шинэчлэлтийн ажлыг Нийслэлийн Замын хөгжлийн газраас хийж гүйцэтгүүлсэн.

Дүүргийн нутаг дэвсгэр дэх Лааганы гудамжны уулзвараас "Хүрд" компанийн 4 замын уулзвар хүртэлх авто замд 300 у/м авто замын засвар шинэчлэлтийн ажлыг Нийслэлийн Замын хөгжлийн газраас хийж гүйцэтгүүлсэн.



Дүүргийн нутаг дэвсгэрт нийт 1230 у/м авто замын засвар шинэчлэлтийн ажлыг Нийслэлийн Замын хөгжлийн газраас хийж гүйцэтгүүлсэн байна.

Дүүргийн нутаг дэвсгэр дэх Гүнтийн даваа хүртэлх 2800 у/м авто замын засвар шинэчлэлтийн ажлыг Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ хийж гүйцэтгэсэн байна



Мөн дүүргийн 1-6 дугаар хорооны гол болон туслах авто замуудад 1038,9м<sup>2</sup> нүхэн эвдрэлийг засварлах ажил хийгдсэн. Дүүргийн 24 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Жигжид зуслангийн замд 3000м<sup>2</sup> асфальтан хучилт хийгдсэн. Тус ажлыг "Квадровэй" ХХК хийж гүйцэтгэсэн.

*/Урт цагааны гудамжны авто зам дагуух 40x80 шүүрт худгийн засвар/*



*/Тасганы овооны авто зам дагуух 40x80 шүүрт худгийн засвар/*

**Нийтийн тээврээр зорчигчдын ая тухтай байдлыг хангах чиглэлээр:** Нийтийн тээврээр зорчигчдын ая тухтай байдлыг хангах үүднээс дүүргийн 16 дугаар хорооны Хайлаастын эцсийн автобусны буудлыг "Баян их наяд констракшн" ХХК нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэн хүлээлгэж өгсөн.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 19 байршилд автобусны буудлын сүүдрэвч бүхий тохижилтын ажлыг "Цагаантолгойн нуур" ХХК хийж гүйцэтгэхээс 6 байршлын гүйцэтгэл 100 хувьтай, 1 байршлын гүйцэтгэл 60 хувьтай, 8 байршлын ажлын гүйцэтгэл 20 хувьтай, 4 байршлын зураг төсөл зөвшилцөх шатандаа буюу 10 хувийн гүйцэтгэлтэй явж байна.



**Иргэдийн амьдрах орчинг сайжруулах чиглэлээр:** Дүүргийн 7-20, 24 дүгээр хороодын иргэдийн амьдрах орчинг сайжруулж бороо, үерийн усанд эвдэрсэн гудамж, зам талбайг түрж тэгшлэх,

шаварлаг хөрстэй гудамж талбайд дайрга асгах, түрж тэгшлэх, нягтруулах /индүүдэх/ ажлыг хийж гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд 12, 16, 17 дугаар хороонд нийт 209770 м<sup>2</sup> шороон зам, талбайг дайрга асгах, авто грейдрээр түрж тэгшлэх, нягтруулах /индүүдэх/ ажлыг дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр Чингэлтэй дүүргийн "Тохижилт үйлчилгээ" компаниар хийж гүйцэтгүүлээд байна

#### **Бичил цэцэрлэгүүдийн үзлэг шалгалт:**

Чингэлтэй дүүргийн Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэнгийн арчлалт хамгаалалттай Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн Х.Энхбат, Чингэлтэй дүүргийн Тохижилт Үйлчилгээ ХХК-ний гүйцэтгэх захирал Э.Ганчимэг, ерөнхий инженер Н.Ариунболд нар хамтран 02 сарын 18-ны өдөр үзлэг шалгалт зохион байгууллаа. Тус шалгалтаар нийт 63 бичил цэцэрлэг, тоглоомын талбайгаар явсан:

- 1 дүгээр хороо, 22, 23, 39,40 дүгээр байрны дундах "Жүр үр" ХХК-ий хажуу талын бичил цэцэрлэг
- 3 дугаар хороо 19, 29 дүгээр байрны дундах бичил цэцэрлэгийн усан толиог дүүргэлт хийж засварлах
- 4 дүгээр хороо 14 дүгээр байрны баруун талын бичил цэцэрлэг шинээр цамхаг тоглоом нэмэгдсэн.
- 5 дугаар хороо Ахмадын цэцэрлэгт хүрээлэнгийн "өвөө эмээ"-тэй хөшөөний арчилгаа цэвэрлэгээг сайжруулах.
- 12 дугаар хороо Булгийн 131 дүгээр худгийн бичил цэцэрлэгийн сагсны шитийг засварлах
- 12 дугаар хороо Булгийн 19 дугаар гудамжны тоглоомын талбайн цэвэрлэгээ тааруу
- 12 дугаар хороо, Булгийн 19 дүгээр гудамжны бичил цэцэрлэгийн цэвэрлэгээ сайн байсан.

Тус үзлэг шалгалтаар нийт 63 бичил цэцэрлэг, тоглоомын талбайгаар явсан бөгөөд 5, 12 дугаар хороодын бичил цэцэрлэгийн цас цэвэрлэгээний ажил тааруу байсан. Энэ сарын арчилгаа, цэвэрлэгээний ажил өмнөх сард гарсан зөрчлийг бүрэн гүйцэт арилгасан байсан.



*/5 дугаар хороо бичил цэцэрлэг/*

*/5 дугаар хороо 2А, 16, 17 дугаар байрны бичил цэцэрлэг/*



*/6 дугаар хороо, 24 дүгээр байрны бичил цэцэрлэг/*



*4 дүгээр хороо 14 дүгээр байрны баруун талын бичил цэцэрлэг/*



*12 дугаар хороо Булгийн 131 дүгээр/  
худгийн бичил цэцэрлэг/*

*12 дугаар хороо Булгийн 10  
дугаар байрны бичил цэцэрлэг/*



**/3 дугаар хороо 19, 29 дүгээр байрны дундах бичил цэцэрлэг/**

Чингэлтэй дүүргийн Тохижилт, нийтийн аж хуйн хэлтэс, Чингэлтэй Тохижилт үйлчилгээ ХХК-иас урин дулаан цаг ирж байгаатай холбогдуулан дүүргийн төвийн 1-6 дугаар хороодын нийтийн эзэмшлийн зам талбай дахь хүүхдийн тоглоомын талбай, хайс хашлага, хогийн савуудыг угааж цэвэрлэн ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэн ажиллаж байна.



**Улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтын ажлын талаар:**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: БХБЯамнаас Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр тендер зарлагдаж 7 байрны дээврийн засвар, 9 байрны фасад засвар ажлын үнэлгээ хийгдэж байна.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар: 2 дугаар хороо 28-р байрны дээвэр засвар 2 удаа тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй тул тоо хэмжээг өөрчлөн дахин тендер зарласан.



Дүүргийн төсвийн хөрөнгөөр оруулалтаар: 2021-2022 онд он дамжин хийгдсэн 3 дугаар хороо 8/9 дүгээр байрны цахилгаан шатыг "Гидродизайн" ХХК хийж гүйцэтгэж 2022 оны 01 дүгээр сарын 19 нд комисс ажиллаж ашиглалтад оруулсан.

**Сууц өмчлөгчдийн холбоодын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлууд:**

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/51 дүгээр захирамжаар Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм болон холбогдох хууль, стандартын хэрэгжилт болон лифтний аюулгүй ажиллагааг хангуулах, гарч болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, орон сууцны цахилгаан шат /лифт/-нд үзлэг шалгалт хийх зорилготой ажлын хэсэг байгуулагдсан.

Ажлын хэсэг нь 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр **Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо** 6 СӨХ-ны 11 байр, СӨХ-гүй 2 орон сууц нийт 13 орон сууцны хүн тээврийн 23 цахилгаан шат, 2022 оны 02 дугаар сарын 21, 22-ны өдөр **3 дугаар хорооны** 10 СӨХ-ны 15 байрны 18 хүн тээврийн цахилгаан шат, 1 ачаа тээврийн цахилгаан шат, 2022 оны 02 дугаар сарын 23, 24-ний **өдөр 6 дугаар хорооны** 15 СӨХ-ны 17 байрны 39 хүн тээврийн цахилгаан шат, 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр **4 дүгээр хорооны** 5 СӨХ-ны 5 орон сууцны 7 хүн тээврийн цахилгаан шат, 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр **дүүргийн 1 дүгээр хороо** СӨХ-гүй 2 орон сууцны 2 хүн тээврийн цахилгаан шат, 2 дугаар хороо 2 СӨХ-ны 2 орон сууцны хүн тээврийн 4 цахилгаан шат, **9 дүгээр хороо** 2 СӨХ-ны 2 орон сууцны хүн тээврийн 4 цахилгаан шат, 10 дугаар хорооны 1 СӨХ-ны 1 орон сууцны 6 цахилгаан шат, 15 дугаар хороо СӨХ-гүй 1 орон сууцны 1 цахилгаан шат нийт 1, 2, 3, 4, 5, 6, 9, 10, **15 дугаар хорооны** 69 байрны 101 орцод ашиглаж буй 127 цахилгаан шатыг хамруулан үзлэг шалгалт хийн цахилгаан шатны кабин дотор Мэргэжлийн хяналтын газрын аюулгүйн санамж, гадна талын дуудлагын товчны дээд тал болон хажуу талд Чингэлтэй дүүрэг, мэргэжлийн хяналтын газрын аюулгүйн санамж, зөвлөмжийг нааж, зөвлөгөө өгч ажилласан байна.



2022 оны 01 дугаар сарын 08-ны өдрийн 11 цагт 4 дүгээр хорооны иргэний танхимд "Шарга" СӨХ-ны хурал хуралдаж Дүүргийн Засаг даргын А/470 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн илтгэх хуудсыг танилцуулсан.

2022 оны 02 дугаар сарын 14 нд дүүргийн уулзалтын танхимд "Эв нэгдэл биднийх" СӨХ нд харьяалагдах 2 дугаар хороо 56, 3 дугаар хороо 51, 4 дүгээр хороо 10 дугаар байрны БЗД, СХД-ийн байрнаас салгах эсэх асуудлаар ТНААХ-ийн дарга Б.Саруул-Од, 2 дугаар хорооны хэсгийн ахлагч н.Отгонгэрэл, 3 дугаар хорооны Засаг дарга Б.Солонго, 4 дүгээр хорооны зохион байгуулагч Б.Уранчимэг, "Эв нэгдэл биднийх" СӨХ-ны гүйцэтгэх захирал Ундрах, нягтлан бодогч нарын хамт уулзалт хийж байр тус бүрээс авахаар шийдвэрлэсэн.

2022 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 12.00 цаг, 2022 оны 06 дугаар сарын 04-ны 12.00 цагт хуралдсан "Галт 5" СӨХ-ны хуралд хяналт тавьж оролцсон.

2022 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 15.00 цаг 1 дүгээр хорооны Иргэний танхимд "Бат Эвсэг" СӨХ-ны бүх гишүүдийн хурал хуралдаж гүйцэтгэх захирал Н.Наранжаргал тайлангаа

танилцуулж, ирц хүрээгүй тул удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийг нөхөж сонгоогүй хойшилсон байна.

Мөн тайлант хугацаанд Сууц өмчлөгчдийн холбооны

- Шинээр СӨХ байгуулагдсан 1 ("Дэлгэрэх-49" СӨХ)
- Гэрчилгээ шинэчилсэн 1 ("Есөн орд" СӨХ)

Гүйцэтгэх захирлын өөрчлөлт 4 ("Шарга" СӨХ, "Солонго 45" СӨХ, "Эрчим 98", "Ялалт цогцолбор 4" СӨХ), нийт 6 гэрчилгээнд тодотгол хийж ажилласан байна.

#### **Гэрэлтүүлгийн чиглэлээр:**

Чингэлтэй дүүргийн гэрэлтүүлгийн ашиглагч "Соёндрийм" ХХК-нд 2021 оны 01 дүгээр сард 22 гомдол, 2 дугаар сард 13 гомдол, 3 дугаар сард 19 гомдол, 4 дүгээр сард 18 гомдол, 5 дугаар сард 12 гомдол нийт 84 гомдол ирүүлснийг тухай бүр засварлаж ажилласан. Мөн 2021 онд 1200 гаруй гэрэлтүүлэгт засвар үйлчилгээ хийж 135 гэрэлтүүлгийн шугамын гэмтлийг засварласан. 50 гэрэлтүүлгийг шинээр суурилуулсан байна.

2021 оны 05 дугаар сарын 21-ний өдөр "Соёндрийм" ХХК-ны цахилгааны инженер Ц.Цолмонбаатартай хамтран гэрэлтүүлгийн үзлэг шалгалтын ажлыг зохион байгуулж дүүргийн 1-19 хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд 12 хорооны 34 байршилд 61 ширхэг гэрэлтүүлэг асахгүй, 1 ширхэг гэрэлтүүлэг анивчсан байдалтай байсан бөгөөд 1 /0705/ -ын дээрх фазын уналтаас үүдэлтэй тэжээлгүй болсон 15 гэрэлтүүлгийг газар дээр нь асаасан.

Тус үзлэг шалгалтыг сар бүр зохион байгуулж ажиллаж байна.

Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ-ын Шуурхай ажиллагааны хэсгээс ирүүлсэн дүүргийн 19 дүгээр хороо Гүнтийн даваа өгсөх зам дагуу, 18-р хороо Ногоон булаг 43-р гудамжны гэрэлтүүлгийн шонгоос унжсан хариуцагч эзэмшигч нь тодорхойгүй кабелийг "Соёндрийм" ХХК засварласан.

Ардын их хувьсгалын 100 жилийн ойн хүрээнд 1-р хороо 40 шон, 2-р хороо 40 шон, 3-р хороо 40 шон, 4-р хороо 40 шон, 5-р хороо 40 шон, 6 дугаар хороо 40 шон нийт 240 ш гэрэлтүүлгийн шонг будаж, өнгө үзэмжийг сайжруулах судалгааг ХИБХ-д хүргүүлсэн.

Гэрэлтүүлгийн ашиглагч Соёндрийм ХХК 2, 3, 6, 7, 10, 11, 17 дугаар хорооны гэрэлтүүлгийг хийж дуусгасан.

#### **Ногоон байгууламжийн ажлын хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 350 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу жил бүр зохион байгуулдаг "Бүх нийтээр мод тарих өдөр"-ийг Чингэлтэй дүүргийн хэмжээнд зохион байгуулах ажлыг Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн А/147 дугаар захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдаж, мод тарих ажилд хяналт тавьж ажилласан.

Хаврын мод аяныг зохион байгуулах ажлын хүрээнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр ханган Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын харьяа газар, хэлтэс албадын дарга нарт Засаг даргын 2/1127 тоот албан бичгийг хүргүүлж, эрэгтэй албан хаагчдаар 8000 ширхэг мод тарих нүхийг бэлдүүлсэн.

Дүүргийн хэмжээнд мод тарих боломжит газрын хээрийн судалгааг Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи Газарзүй, Геоэкологийн Хүрээлэн, дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран хийж, тарих модны төрлийг гаргасан. Үүнд:

- Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, "Хайрхан хөгжлийн төв" УТҮГ,
- 16 дугаар хороо, "Хоймор хайрхан амралт" ОНӨТҮГ

Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "Хайрхан хөгжлийн төв" УТҮГ-ийн 50 га газрын геодезийн зургийг "Грандмэп инженеринг" ХХК-аар гүйцэтгүүлсэн.

Хаврын мод тарих аяны хүрээнд Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо, "Хоймор хайрхан амралт" ОНӨТҮГ, 19 дүгээр хороо, "Хайрхан хөгжлийн төв" УТҮГ, 293 дугаар цэцэрлэгийн хашаа, Ж.Самбуугийн гудамж, Жуулчны гудамжинд мод тарьсан. Уг газруудад Нийслэлийн Засаг даргын

хэрэгжүүлэгч 6 агентлаг, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх харьяа, хэлтэс албад, Цагдаагийн Ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба хаагчид, Нийслэлийн 7 эмнэлгийн байгууллага, Чингэлтэй дүүргийн "Тохижилт үйлчилгээ" ХХК, "Соён Дрийм" ХХК, "Найши трейд" ХХК Монгол Улсын Их Сургууль, "Эрдэнэс таван толгой" ХК, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд, Приус центр, Ленд.мн "Монголын гар утас бизнес эрхлэгчдийн үндэстэн холбоо" ТББ-ууд нийгмийн хариуцлагын хүрээнд мод тарьсан.

Дүүргийн хэмжээнд нийт 14 төрлийн (хайлаас, бургас, нарс, гацуур, улиас, агч, шар хуайс, монос, голт бор, балгана, гүйлс, буйлс, чацаргана) 34,219 модыг 4,000 гаруй албан хаагч, ажилчид 5 байршилд тарьсан.

Дүүргийн хэмжээнд 2022 оны хаврын мод тарих аяны хүрээнд 5 байршилд мод тарьсан модны тоо хэмжээ



**"ХАЙРХАН ХӨГЖЛИЙН ТӨВ" УТУГ-ын эргэн тойронд** Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 6 агентлаг, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн 7 эмнэлгийн байгууллага, "Эрдэнэс таван толгой" ХК, Ленд.мн, "Соён Дрийм" ХХК, Найша трейд ХХК-ий албан хаагчид болон ажилчид мод тарив.



**"ХОЙМОРЬ ХАЙРХАН АМРАЛТ" ОНӨТҮГ-т** Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс албадын албан хаагч, Ерөнхий боловсролын 39 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 18 байгууллага, "Монголын гар утас бизнес эрхлэгчдийн үндэстэн холбоо" ТББ-ийн албан хаагч, ажилчид мод тарив.

2022 оны хаврын мод тарих аяны хүрээнд дүүргийн "Тохижилт үйлчилгээ" ХХК дүүргийн гол гудамж болох **Ж.САМБУУГИЙН ГУДАМЖ, ЖУУЛЧНЫ ГУДАМЖИНД** нөхөн сэргээлт хийн, шинэ суулгац тарьсан.



**Чингэлтэй дүүргийн "Тохижилт үйлчилгээ" ХХК дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Тусгаар тогтнолын талбайд 4000 ширхэг нэг наст цэцгийг 44 м<sup>2</sup> талбайд тарьсан.**



#### Хог хаягдлын чиглэлээр:

Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК, Найши трейд ХХК байгууллагууд нь байрших гэр хороолол, зуслангийн бүсийн айл өрх аж ахуй нэгж байгууллагуудын хог хаягдал, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ арчилгаа, бичил цэцэрлэгүүдийн цэвэрлэгээ, үйлчилгээ, гудамж талбайд байршуулсан хөшөө, хогийн сав, хайс, сандал, саравчийн тоос шороо арчиж цэвэрлэх мөн гэр хороолол айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын орчны цэвэрлэгээ, далан суваг, гуу жалганы түүвэр цэвэрлэгээ хийх, цэвэрлэгээнээс гарсан хог хаягдал болон ахуйн хог хаягдлыг ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэн ажилладаг.

Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК, Найши трейд ХХК-иуд хагас жилийн байдлаар нийт **17,056** рейсээр **112,381** тонн хог хаягдлыг тээвэрлэн ажиллалаа.



### "ЭЭРЭГ ДАВАЛГАА" ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Швейцарын хөгжлийн агентлаг болон Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран ахуйн хог хаягдлыг цуглуулалт, тээвэрлэлтийн менежмент төслийг 2019 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

Уг төслийн хүрээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, багасгах, бууруулах, дахин ашиглах чиглэлээр иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх хог хаягдлын тухай хууль тогтоомж холбогдох дүрэм, журам, хог хаягдлаас байгаль, орчин хүний эрүүл мэндэд үзүүлдэг сөрөг нөлөөллийг таниулах зорилгоор "Эерэг давалгаа" өдөрлөгийг 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Тусгаар тогтнолын талбайд зохион байгууллаа.

Мөн "Өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгцгөөе" уриатай хуучин эд зүйлсээ солилцох, үнэгүй өгөх чиглэлээр тус арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.



Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2022 оны А/08тушаал, 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх урин дулаан цаг ирж байгаатай холбогдуулан иргэдийн цэвэр аюулгүй, цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ"-ний ажлыг дүүргийн нутаг дэвсгэрт 2022 оны 04 дүгээр сарын 22-23 ны өдрүүдэд зохион байгуулж байна.

Цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг "Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ" ХХК, "Найши трейд" ХХК хог тээвэрлэгч 2 байгууллага 46 машинаар хог тээвэрлэлт хийж нийт **350** гаруй тн хог хаягдал болон **65** гаруй рейсээр ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргүүлэн ажилласан.



### Иргэдийн бүлгийн цэвэрлэгээ үйлчилгээ:

Чингэлтэй дүүргийн "Тохижилт үйлчилгээ" ХХК, "Найши трейд" ХХК-ууд иргэдийн бүлгийг өөрсдийн хөрөнгөөр тогтмол ажиллуулж байна. Чингэлтэй дүүргийн "Тохижилт үйлчилгээ" ХХК 7-16 дугаар хороо буюу 2 дугаар бүсэд 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 2 бүлэг, "Найши трейд" ХХК 3 дугаар бүс болох 17-19 дүгээр хороонд 13 хүний бүрэлдэхүүнтэй 2 бүлгийг тогтмол ажиллуулан хэвшээд байна. Чингэлтэй дүүргийн гэр хорооллын 7-19 хороонд хоёр компанийн нийт иргэдийн бүлгийн 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэй иргэдийн бүлэг 7 хоногт 2-3 удаагийн давтамжтайгаар түүвэр цэвэрлэгээг хийж гүйцэтгээд байна. Цэвэрлэгээний явцад гэр хорооллын гуу жалга, далан сувгийн үүсмэл хог хаягдал, шарилж болон лаг цэвэрлэгээг цэвэрлэн ажиллаж байна. Цэвэрлэгээний явцад жилийн эцсийн байдлаар нийт **45232 м2** талбайн **109,2** тонн үүсмэл хог хаягдлыг цуглуулан цэвэрлэж ачилт хийн ажиллаж байна.



**Хэрэгжиж буй төсөл хөтөлбөр:**

Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт Улсын төсвийн хөрөнгөөр Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас хэрэгжиж байгаа түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй "Гэр хорооллын ариун цэврийн байгууламж, цэвэрлэх байгууламжийн лаг хаягдлыг байгальд халгүй аргаар шатааж устгах туршилтын төсөл"-ийн гүйцэтгэгчээр "Мөнгөн болдог" ХХК шалгаран зураг төслийн дагуу хийж гүйцэтгэж байгаа бөгөөд захиалагчийн хяналтыг Барилгын хөгжлийн төвөөр хянуулан ажиллаж байна. 2022 оны хагас жилийн байдлаар ажлын явц 50 хувьтай хэрэгжиж байгаа ба суурь бетон цутгалтын ажил бүрэн хийгдэж, лаг хаягдлын бассейны нүхийг ухаж дуусган сэндвичийн барилгыг босгохоор ажиллаж байна.



Барилга хот байгуулалтын яамнаас хэрэгжүүлж буй Ногоон хороо Эко жорлон БХБЯ (202212029) дугаартай тендерийн ажил зарлагдан дүүргийн 7, 10, 12, 13, 14, 15, 16, 17, 19 дүгээр хороодын нийт 2000 гаруй айл өрхөд стандартад нийцсэн ариун цэврийн байгууламж барих ажлыг эхлүүлээд байна.

**Нохой устгалын чиглэлээр:**

Иргэдийн эрүүл аюулгүй байдалд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, халдварт өвчөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 7-19 дүгээр хороод болон зуслангийн бүсэд золбин нохой, муур устгалыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны гэрээт "Их булаг А ТҮК" ХХК 2022 оны 01, 02 дугаар улиралд нийт 458 золбин нохойг устгалд оруулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

**Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний ажлын хүрээнд**

Тус байгууллага нь дүүргийн нийтийн эзэмшлийн 1,057,379м<sup>2</sup> талбайн арчилгаа, цэвэрлэгээний ажилд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан 2, зам талбайн мастер 2, байцаагч 2, зам талбайн үйлчлэгч 120 хүний бүрэлдэхүүнтэй хариуцан гүйцэтгэж байна. Хариуцан ажиллаж буй зам талбайн өдөр тутмын явган болон авто зам, нуух, автобусны болон автомашины зогсоол, ногоон байгууламжит талбайн цэвэрлэгээ, хогийн сав, сандал, хайс хашлаганы тоос шороо арчих, угаах, гэрлийн шон, хашаа, ханан дээр наасан сурталчилгааны хуудсыг цэвэрлэх, цэвэрлэгээ үйлчилгээнээс гарсан хог хаягдлыг ачиж тээвэрлэн ажиллаж байна. Зам талбайн шүүрдэх ажил өдөр тутам /Даваа-Баасан, ням гаригт 02:00-06:00 / тогтмол, зам талбайн гар цэвэрлэгээний ажлыг өдөр тутам /Даваа-Баасан гаригт 05:00-16:00, бямба, ням гаригт 09:00-16:00/ тасралтгүй, хэвийн, хөдөлмөрийн аюулгүй байдлыг чанд сахин зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ хариуцсан мастер, ногоон байгууламжийн цэвэрлэгээ, арчилгаа хариуцсан мастер, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан нар хариуцан зохион байгуулан ажиллаж байна. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнууд өдөр бүр ажилтнуудад хөдөлмөрийн аюулгүй байдлын давтан зааварчилгаа өгч хэвшүүлсэн ба хогны түрдэг тэрэгний аваарын ойлгогч, хамгаалалтын тумба, хувцас жигдрэлт, хантааз зэрэгт хяналт тавин ажиллаж байна.

Нийт ажилтнууд нормын хувцас /хавар, намар, зуны хувцас, гутал, бээлий, маск гэх мэт/, багаж хэрэгсэл /түрдэг тэрэг, хүрз, шүүр, савар, цавчуур, хусуур, хамгаалалтын тумба, хувин, резинин бээлий гэх мэт/-ээр бүрэн хангаж ажиллаж байна. Зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээнээс гарсан хог хаягдлыг тээвэрлэх зориулалт бүхий бага оврын, задгай 2 ширхэг самосмол машин нь шуурхай зохион байгуулалттайгаар ачиж тээвэрлэн ажиллаж байна.

**Давс бодис цацаж цас мөсний халтиргаа гулгааг арилгах ажлын хүрээнд**

Тус байгууллага нь хариуцан ажиллаж буй нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай дундах автозамуудад цас орсон даруйд халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлж давс, бодис цацах ажлыг тогтмол зохион байгуулан ажилласан.

Давс, бодис цацах, зам шүүрдэх, цас түрэх ажлыг тусгай зориулалтын камаз 6, цас түрэх зориулалтаар грейдер 2, цас ачих зориулалтаар ковш 2, зам талбайн цэвэрлэгээ, авто замын нуух шүүрдэх шүүрдэгч машин 2 гэсэн техник хэрэгслийн бүрэлдэхүүнтэй цас орсон даруйд шуурхай зохион байгуулан ажиллалаа.



Нийтийн эзэмшлийн бичил цэцэрлэгүүдийн арчилгаа, цэвэрлэгээний арчилгааны ажлын хүрээнд хариуцан ажилладаг бичил цэцэрлэгүүдэд өдөр тутмын цэвэрлэгээний ажлуудаас гадна Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, бичил цэцэрлэгт байрших эд хөрөнгө, хөшөө дурсгал, явган болон





чулуун зам, хайс хашлагыг засварлах, нөхөн сэргээх ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэн ажиллаж байна

Дүүргийн хэмжээнд Самбуугийн гудамж, Анкарагийн гудамж, Б.Явуухулангийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн, Учралын цэцэрлэгт хүрээлэн, Эрдэнэсийн арлын цэцэрлэгт хүрээлэн, Ахмадын цэцэрлэгт хүрээлэн, н. Лааганы гудамж гэх мэт томоохон цэцэрлэгт хүрээлэнгүүд болон орон сууцны дундах болон гэр хорооллын дундах 65 бичил цэцэрлэгийн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байна.

Ногоон байгууламжийн ажилбарууд 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хариуцан ажиллаж буй бичил цэцэрлэгүүд болон нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн ногоон байгууламжит гудамж талбайд эхэлсэн бөгөөд улиас, хайлаас, ургамлын хашлага хэлбэржүүлэлд, улиас, хайлаас модны шохойдолт, хавар намрын цэнэг усалгаа, бордоот усалгаа, зүлэг нөхөн болон шинээр тарилт, зүлэгт тайрч тэгшлэх, цэцэг тарилт, үхсэн болон хатсан модны мөчир цэвэрлэх, цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг ачиж тээвэрлэх ажлыг тогтмол хийж гүйцэтгэн ажиллаж байна.



### Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр:

2022 оны 02 дүгээр сарын 11-ны өдрөөс 02 дугаар сарын 28-ны өдрийн хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 тушаалаар батлагдсан журмын дагуу “Агаарын бохирдлын эж үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл”-ийг дүүргийн 7-19 дүгээр хороонд зохион байгуулан ажилласан.

“Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан” буюу <https://www.envpol.mne.gov.mn/> цахим системд нийт ердийн галлагаатай 3-15 кВт хүртэл хүчин чадлын зуух 21095, усан халаалтын 15-100 кВт хүртэл хүчин чадлын зуухтай 307, 100-4200квт хүртэл хүчин чадлын зуух 40 зуухнуудыг шивэн оруулсан.

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уурын зуух, 100 кВт-аас дээш нэгж хүчин чадалтай халаалтын зуух ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, магадлан итгэмжлэх ажлыг Чингэлтэй дүүрэгт 2022 оны 02 дугаар сарын 11-нээс 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Тус магадлан итгэмжлэх ажилд: НМХГ-ын агаарын чанарын хяналтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч Б.Түшигбат, Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын хог, орчны бохирдол зохицуулалтын хэлтсийн агаар орчны бохирдлын мэргэжилтэн Б.Эрдэнэбаяр Хэсэгчилсэн Инженер хангамжийн удирдах газрын ХАБ-ын инженер Ц.Цогзолмаа, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын мэргэжилтэн Г.Бат-Оюун нар оролцлоо. Халдвар хамгааллын дэглэмийн чанд сахин бээлий 35 ш, амны хаалт 100ш, нүүрний хаалт 25ш, гар ариутгагч 10ш-ийг тарааж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэрэглэсэн.

## **ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Тайлангийн хугацаанд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд нийт 17896 иргэнд үйлчилсэн. Үүнээс:

- Нийслэлийн улсын бүртгэлийн дансанд хураамжид 82.205.000, татварт 22.296.900
- Гэрлэсний бүртгэл – 1167
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл – 23
- Үрчилсний бүртгэл – 0
- Эцэг, /эх/ тогтоосны бүртгэл – 11
- Овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл – 18
- Нас барсны бүртгэл – 17
- Засвар өөрчлөлтийн бүртгэл – 0
- Гэрчилгээний дахин олголт – 64
- Иргэний үнэмлэх шинээр олгосон болон дахин олгосон – 2246
- Иргэний үнэмлэхийн хугацааны сунгалт – 453
- Гадаад паспорт, түүнийг олгох бүртгэл – 5295
- Шилжилт хөдөлгөөний бүртгэл /хот доторх/ - 1246
- Шилжилт хөдөлгөөний бүртгэл /орон нутаг/ - 145
- Лавлагаа – 7211

### **Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр**

1. Тайлангийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн дараах үйлчилгээг иргэн хуулийн этгээдэд үзүүлсэн байна. Үүнд:

- Хүлээн авсан нийт мэдүүлгийн тоо-3887
- Анхны бүртгэл -535
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаа-3
- Хуулбар-52
- Буцсан мэдүүлэг -545
- Түрээсийн гэрээ -1
- Үрэгдүүлсэн гэрчилгээ дахин авах -45
- Гэмтээсэн гэрчилгээ дахин авах -1
- Урьдчилсан тэмдэглэл хийх-3
- Хувийн хэрэг хаах-128

Анхны бүртгэлийг үйлчилгээний төрлөөр ангилж үзвэл:

- Өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салгах-71
- Өмчлөгчийн хүсэлтээр гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсэх-71
- Төрөөс үнэгүй өмчлүүлсэн газар-148
- Газраас бусад үл хөдлөх эд өмчлөх эрх бүртгүүлэх -254
- Шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэл-55

Гэрээний эрхийн бүртгэлийг үйлчилгээний төрлөөр ангилж үзвэл:

- Өмчлөх эрх шилжих гэрээ-1136
- Барьцааны гэрээ-659
- Барьцааны гэрээ дуусгавар болсон тухай бүртгэл-758
- Бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах-76

2. Нийт 552 албан бичиг хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд нийт 190 үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн тухай бүртгэл хийж, холбогдох байгууллагуудад энэ тухай хариу албан бичиг хүргүүлсэн. Мөн эрх бүхий байгууллагын ирүүлсэн албан бичиг шийдвэрийн дагуу нийт 40 үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн захиран зарцуулах эрхийг сэргээсэн тухай бүртгэл хийсэн.

4. Тайлангийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжийн орлого нийт 130.914.323 төгрөгийг НУБГ-ын дансанд, тэмдэгтийн хураамжид 3.048.444 төгрөг, үл

хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 2%-ийн татвар болох 1.760.809.261 мянган төгрөгийг Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн дансанд тус тус төвлөрүүлэн ажиллаа.

### **ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР :**

2022 онд Татварын ерөнхий газраас "Татвар төлөгчийн боловсролын жил", Чингэлтэй дүүрэг "Нийгмийн хөгжлийг дэмжих жил" зорилтын хүрээнд Монгол улсын татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, Хэлтсийн 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ханган биелүүлэх, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ, сургалт, сурталчилгааны чанар үр нөлөөг дээшлүүлэх, татварын албаны мэдээллийн урсгал, мэдээлэл солилцох тогтолцоог сайжруулах, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Татварын албаны хэмжээнд 2022 онд бүртгэлтэй байгаа татвар төлөгчийг сегментийн ангиллаараа болон нийт оны эхэнд 124,844 татвар төлөгч бүртгэлтэй байснаас 571 татвар төлөгчөөр шинээр нэмэгдэн бүртгүүлж, нийт 125,461 татвар төлөгчийн буюу 102%-ийн өсөлттэй байна.

#### **1. Бүртгэлтэй татвар төлөгчийн сегментийн мэдээ:**

Үзүүлэлт	Сегмент	Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан	Оны эцэст	Өссөн хувь
Татварын албанд бүртгэлтэй татвар төлөгчийн мэдээ	Жижиг	3,035	15		3,050	100%
	Бичил	17,273	441	14	17,700	102%
	Иргэн	104,596	115		104,711	102%
	<b>НИЙТ</b>	<b>124,844</b>	<b>571</b>	<b>14</b>	<b>125,461</b>	<b>102%</b>

Нийт 125,461 татвар төлөгч бүртгэлтэйгээс 3050 нь буюу 2.4% нь жижиг сегментийн, 17700 нь буюу 14.1% нь бичил сегментийн, 104,711 нь буюу 83.5% нь иргэний татвар төлөгчид байна.

#### **2. Нэмэгдсэн өртгийн албан татварын төрлийн бүртгэл:**

##### **НӨАТ**

Сегмент	БО НӨАТ ногдох хэмжээнд хүрсэн	Чөлөөлөгдөх	Өөр татварын албанд бүртгэгдэх	Бүртгэгдвэл зохих	Бүртгэсэн	Хувь
Бичил	227	19		208	115	55.0%
Жижиг	209	137		72	41	57.0%
Иргэн	87	4	45	29	10	67.8%
<b>НИЙТ</b>	<b>523</b>	<b>160</b>	<b>45</b>	<b>309</b>	<b>166</b>	<b>59.9%</b>

Борлуулалтын орлогын дүн НӨАТ ногдох хэмжээнд хүрсэн 523 татвар төлөгчөөс 160 нь чөлөөлөгдөх, 166 нь бүртгэх материалаа өгч, Иргэний харьяаллаар өөр татварын албанд бүртгэгдэх 45 иргэнээс 59.9% -ийг бүртгэн ажиллаж байна.

#### **3. Нийслэл хотын албан татварын төрлийн бүртгэл:**

Тухайн төрлөөр бүртгүүлэх болон бүртгэлээс хасагдах татвар төлөгчдийн нэрсийн дагуу сегментийн хариуцсан байцаагч нар бүртгэл хариуцсан байцаагчтай хамтран ажиллаж байна.

Сегмент	Оны эхний ТТТоо	Нэмэгдсэн ТТТоо	Хасагдсан ТТТоо	Эцсийн ТТТоо /2022.06.09/
<b>Бичил</b>	335	5	2	338
<b>Жижиг</b>	332	8	2	348
<b>Иргэн</b>	150	5	3	150
<b>НИЙТ</b>	<b>817</b>	<b>18</b>	<b>7</b>	<b>836</b>

Нийслэл хотын албан татварын төрлөөр 138 татвар төлөгчийг шинээр бүртгэж, 7 татвар төлөгчийг хасаж 836 татвар төлөгч идэвхтэй бүртгэлтэй байна

**4. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын төрлийн бүртгэл:**

Үл хөдлөх эд хөрөнгө /шинэ бүртгэл/

Сегмент	Бүртгүүлсэн ТТ-ийн тоо	Үл хөдлөх хөрөнгийн тоо	Үнэлгээний дүн /мян.төг/	Ногдлын дүн /мян.төг/
<b>Бичил</b>	3	3	429,400.0	4,505.6
<b>Жижиг</b>	14	18	4,862,366.3	47,177.1
<b>Иргэн</b>	45	47	3,818,356.1	105,267.1
<b>Нийт</b>	<b>62</b>	<b>68</b>	<b>9,110,122.4</b>	<b>156,949.8</b>

Ногдол оруулсан

<b>Бичил</b>				
<b>Жижиг</b>	76	108	727,740.6	
<b>Иргэн</b>	811	985	307,245.3	
<b>Нийт</b>	<b>887</b>	<b>1093</b>	<b>1,034,985.9</b>	

Үнэлгээ өөрчилсөн

<b>Бичил</b>	5	5		
<b>Жижиг</b>	13	26		
<b>Иргэн</b>	842	1016		
<b>Нийт</b>	<b>860</b>	<b>1027</b>		

Хасагдсан

<b>Бичил</b>	4	4		
<b>Жижиг</b>	19	39		

Иргэн	1	1
Нийт	24	44

Иргэн, Хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгчөөр 2022 онд 62 татвар төлөгчийн 68 үл хөдлөх эд хөрөнгийг шинээр бүртгэж 156,949.8 мянган төгрөгийн ногдол үүссэн байна.

Бүртгэлтэй 887 татвар төлөгчийн 1093 үл хөдлөх эд хөрөнгийн 1,037,985.9 мянган төгрөгийн ноогдлыг ТУНС-д бүртгэн ногдлыг үүсгэсэн. Учир нь ТУНС хөрөнгийн ноогдлыг оруулахдаа бүсчлэлийг буруу тогтоосноос шалтгаалан хөрөнгийн ногдол дээр зөрүү үүссэн.

Бүртгэлтэй 860 татвар төлөгчийн 1027 үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг өөрчилж, 24 татвар төлөгчийн 44 үл хөдлөх эд хөрөнгийг тус тус холбогдох материал, хүсэлтийн дагуу өөрчлөх болох төрлийн бүртгэлээс хасалт хийж бүртгэсэн.

**5. Татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлсэн байдал:**

Сегмент	Хүсэлт	Хүлээн авсан тайлан	Утсаар зөвлөгөө өгсөн /11-312728/	Биечлэн зөвлөгөө өгөх	1800-1288 утас
Бичил	10,692	17,970	3,549	5,153	4,506
Жижиг	9,423	13,595	4,263	6,043	-
Иргэн	12,624	9,456	4,624	7,627	-
НИЙТ	32,739	41,021	1,2436	18,823	4,506

Татварын албаны хэмжээнд 2021 онд бүртгэлтэй байгаа татвар төлөгчийг сегментийн ангиллаараа болон нийт оны эхэнд 19949 татвар төлөгч бүртгэлтэй байснаас 945 татвар төлөгчөөр шинээр нэмэгдэн бүртгүүлж, нийт 20550 татвар төлөгчийн буюу 103%-ийн өсөлттэй байна.

**Татварт хамруулалт Бичил, Жижиг сегмент /нийт/:**

Татварын төрөл	Ногдолтой Бүртгэлтэй ТТТоо	Ногдол төлсөн ТТТоо	Хувь
НӨАТ төлөгчийг татварт хамруулалт	1858	1107	59.6%
Цалин хөлс болон тэдгээртэй адилтгах орлогын албан татварыг татварт хамруулалт	3144	1480	47.1%
Хуулийн этгээдийн ҮХЭХАТ-т хамруулалт	605	363	60.0%
АТБӨЯХАТ-т хамруулалт	73465	33077	45.0%
Галт зэвсгийн албан татварт хамруулалт	40	17	42.5%

Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварт хамруулалт	101	62	61.4%
Нийслэл хотын албан татварт хамруулалт	320	153	47.8%
<b>НИЙТ</b>	<b>79533</b>	<b>36259</b>	<b>46.0%</b>

Нийт 7 татварын төрлийн тайлант оны ногдлыг татварт хамруулалт татварын төрөл тус бүрийн нийт 79533 татвар төлөгчөөс 36259 татвар төлөгч буюу 46.0% нь татварт хамрагдсан байна.

**Татварын орлогын гүйцэтгэлийн мэдээ /нийт/: /мян.төг/**

	Төсөв	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Жигд ажиллагаа		Хувь
					Биелүүлэх сар	Биелүүлсэн сар	
Улсын төсөв	21,486,712.8	25,323,762.4	117.8%	5	3	60.0%	
Нийслэлийн төсөв	6,868,111.0	10,217,028.9	148.7%	5	5	100.0%	
Орон нутгийн төсөв	58,205,534.7	48,243,835.8	82.9%	5	2	40.0%	
<b>НИЙТ ДҮН</b>	<b>86,560,358.5</b>	<b>83,784,627.1</b>	<b>96.8%</b>	<b>5</b>	<b>4</b>	<b>80.0%</b>	

2022 оны 06 дугаар сарын 09-ны байдлаар өссөн дүнгээр Улсын төсөвт 25,323,761.4 мянган төгрөгийн төвлөрүүлж 117.8%, Нийслэлийн төсөв 10,217,028.9 мянган төгрөг төвлөрүүлж 148.7%, Дүүргийн төсөв 48,243,835.8 мянган төгрөг төвлөрүүлж 82.9% нийт дүнгээрээ 86,560,358.5 мянган төгрөгийн төлөвлөгөөний 82,129,116.9 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж 96.8%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:**

Чингэлтэй дүүргийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан. Дүүргийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь 4 бүлгийн 15 дэд бүлэгт хамаарах 101 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Газрын менежментийг хэрэгжүүлэх талаар 27 ажил
- Газар зохион байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ 40 ажил
- Хот байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ 6 ажил
- Нөхөх олговор олгох, газрын байршил, хэмжээ 28 ажил тус тус тусгагдсан.

Чингэлтэй дүүргийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт 80,6%-тай хэрэгжээд байна.

Газрын кадастрын системд иргэдээс газар эзэмших эрхээ баталгаажуулах, нэр шилжүүлэх, талбайн хэмжээ өөрчлөх, хугацаа сунгах асуудлаар нийт 2300 хүсэлтийг бүртгэснээс дүүргийн Засаг даргын 7 удаагийн захирамжаар 1011 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж 1289 иргэдийн хүсэлт дүүргийн Засаг даргын захирамжийн төсөлд хянагдаж байна.

## Дүүргийн Засаг даргын 7 удаагийн захирамжаар 1011 иргэний хүсэлтийг шийдвэрлэв.



- Газар эзэмших эрх баталгаажих
- Газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх 3 удаагийн захирамж
- Газар эзэмших эрхийн хугацаа сунгах 2 удаагийн захирамж
- Газар эзэмших эрхийн талбай хэмжээ өөрчлөх 2 удаагийн захирамж
- Газар эзэмших эрх сэргээсэн

### Газрын зөрчил арилгах арга хэмжээний тухай

Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/388 дугаар захирамжаар Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 12 байршлын 168 гараашны газрыг албадан чөлөөлөхөөр төлөвлөгдсөний дагуу 12 байршлын 168 объект чөлөөлөлдөхөөс 10 байршлын 134ш объектыг чөлөөлж, 87,100,000 төгрөгийн төсөвтэй газар чөлөөлөх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

- 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 39 дүгээр цэцэрлэгийн урд, хойно 34 гарааш
- 6 хорооны нутаг дэвсгэрт 62 дугаар байрны 21 гарааш
- 24 дүгээр байрны зүүн талд 12 гарааш
- 24 байрны баруун талд 24 гарааш
- 6 хорооны нутаг дэвсгэрт 23 дугаар байрны 5 гарааш
- 41 дүгээр байрны урд талын 11 гарааш
- 6 хороо 49 дүгээр байрны хойд талын 24 гарааш нийт 10 байршлын 134ш объектыг чөлөөлсөн.



2022 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын талаар гарсан Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 121 дүгээр тогтоол, Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны 11/33 дугаар тогтоолоор 232 иргэнд газар өмчлүүлэхээр баталсан.

Эзэмшиж буй газраа өмчилж авах хүсэлт ирүүлсэн 79 иргэний хүсэлтийг 2023 оны ГЗБТөлөвлөгөөнд тусгуулахаар хүлээн авсан.

**Газрын маргааныг шүүх, хууль хяналтын байгууллагаар хянан шийдвэрлүүлсэн байдал:**

2022 онд газар эзэмших, ашиглах болон бусад байдлаар газартай холбоотой эрх ашгаа хамгаалуулахаар гаргасан:

- 1.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд -4,
- 2.Иргэний хэргийн анхан шатны шүүхэд-2,
- 3.Нийт 6 хэрэг маргаанаас 4 хэргийг эцэслэн шийдвэрлүүлсэн байна. 2 хэрэг маргаан дээр хэрэг хянан хэлэлцэгдэх ажиллагаа явагдаж байна. 8 удаагийн нотлох баримт, тайлбар гаргаж хүргүүлсэн.

**ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Дотоод аудит, хяналт шалгалтын удирдамжийг дүүргийн Засаг дарга болон албаны даргаар батлуулан Ерөнхий боловсролын 139 дүгээр дунд сургууль, сургуулийн өмнөх боловсрол олгох 56, 74, 155, 258, 280, 292, 245 дугаар цэцэрлэгийн төсвийн төлөвлөлт, төсвийн санхүүжилт, төсвийн зарцуулалт, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, түүний ашиглалт, үр ашигтай байдал, бүтэц, орон тоо цалин хөлсний тогтоолт, олголт, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэлийн байдалд, холбогдох хууль тогтоомж, заавар журам, стандартын хэрэгжилтийн дагуу аудит, хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгөн, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж, албан шаардлагыг хүргүүлэн ажилласан.

Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтийн хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний төсөвт байгууллагуудаас тусгай шилжүүлгийн 22 байгууллага, орон нутгийн 6 байгууллага, төрийн ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэгч хувийн хэвшлийн 46, нийт 74 байгууллагын Шилэн дансны хуулийн хэрэгжилт, цахим хуудсанд тавигдсан мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байдалд хяналт шалгалт, аудит хийж нийтлэг гарч буй зөрчлийг арилгуулах, мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд оруулж хэвшүүлэх талаар зөвлөмж хүргүүлэн ажилласан.

Тус аудитаар шилэн дансны тухай хуулийн зарим зүйл, заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй "Мэнд цолмон", "Таны итгэл", "Чин хүслэн", "Цэнгэл жаргал хайрхан", "Ижил санаа" ӨЭМТөвүүд, Ерөнхий боловсролын 17, 117-р сургууль, 70, 292-р цэцэрлэгт албан шаардлага хүргүүлсэн. Мөн хяналт шалгалтын ажлаар хангалтгүй ажилласан 224, 245, 258, 275, 280-р цэцэрлэг, 24, 37, 50, 112, 140-р сургуулийн захирал эрхлэгч нарт шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргүүлсэн.





Дүүргийн Засаг даргын 2022 оны 22/08 дугаартай удирдамжаар үйл ажиллагаагаа эхэлж байгаа ОНӨТҮГГазрууд болох Нийтлэг үйлчилгээний газар, Хайрхан хөгжлийн төв, Чингэлтэй Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв, Хоймор хайрхан амралтын газарт зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж цаашид анхаарч ажиллах болон заавал хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийг хүргүүлсэн. Нийслэл дэх Төрийн аудитын газраас тус албаны 2021 оны санхүүгийн тайланд хийсэн хяналт шалгалтаар "ЗӨРЧИЛГҮЙ" санал дүгнэлттэй ажилласан.

### **МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТЭС:**

Нийслэлийн Засаг даргын Захирамжаар 2022 оныг "Хотын иргэний жил" болгон зарласантай холбоотойгоор эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх замаар хүнсний аюулгүй байдлыг хангуулан, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэн, шалгалтын нэгдсэн удирдамжийн дагуу 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангах зорилгоор мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, ард иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, иргэд, бизнес эрхлэгчдийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээг илүү оновчтой хийх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, төрийн албаны стандартыг мөрдөж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөн туслах үйлчилгээ, сургалт, тандалт судалгаа, хяналт шинжилгээ хийж ажиллалаа.

2022 оны эхний хагас жилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт 1987, тандалт судалгаа 95, хяналт шинжилгээ 20, төлөвлөгөөт бус шалгалт 89, төлөвлөгөөт бус зөвлөн туслах үйлчилгээ 190, агаарын чанарын бүсэд мөрдөх хяналт шалгалтыг 9811 айл өрх, 323 аж ахуйн нэгж нийт 10134 объектод хийсэн.

Хяналт шалгалтын явцад зөрчилтэй байсан 36 аж ахуйн нэгж, иргэнд 25100,0 мянган төгрөгийн шийтгэвэр ногдуулж, 2700,0 мянган төгрөгийг барагдуулан ажилласан.

Монгол улсын шадар сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 142 дугаар тушаал, МХЕГ-ын даргын 2022.01.06-ний өдрийн 01/04 дугаар "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд зөвшөөрөлгүй түүхий нүүрс түлж байгаа эсэхэд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд тус Чингэлтэй дүүргийн 7-19 дүгээр хороодын аж ахуйн нэгж, айл өрхийн түүхий нүүрс хог хаягдал, дугуй шатааж байгаа эсэх, эрчим хүчний тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн түүхий нүүрсний татан авалтын байдалд хяналт шалгалт хийлээ. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг дүүргийн 7-19 дүгээр хороодын 9811 айл өрх, 323 аж ахуйн нэгж нийт 10134 объектыг хамруулан зохион байгуулсан. Шалгалтаар түүхий нүүрсийг зөвшөөрөлгүй түлсэн зөрчил илрээгүй.

Ой, ан, байгалийн ургамал, ойн дагалт баялгийг түүж бэлтгэх, агнах, барих, худалдаалах, тээвэрлэлтийн байдалд урьдчилан сэргийлэх шалгалтаар Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо Чингэлтэй, Салхит, Шадивлан, Яргайт, Зуун мод, Жигжид, Гүнт, Майхан толгой зэрэг газруудаар урьдчилан сэргийлэх шалгалтыг гүйцэтгэж, 22 тээврийн хэрэгслийг уулнаас буулгаж, 200 орчим иргэнд 2 төрлийн сэрэмжлүүлэг плакат тарааж зөвлөгөө өгч ажилласан. Он гарсаар ногоон бүсэд шар өвсний түймэр 1 удаа гарсан. Зөрчил гаргасан иргэнд зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ ногдуулсан.

Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг нийт 1687 объектод хийж гүйцэтгэсэн байна.

МХЕГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн "Коронавируст халдварын дэгдэлтийн үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд шалгалт хийх тухай" 01/95 тоот дугаар удирдамжийн дагуу Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй ЧДЭМТөв Хайлааст салбар болон Сүндэра мед эмнэлгүүдэд коронавируст халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хэрхэн хангасан байдалд хяналт шалгалт хийгдсэн. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, эмнэлгүүд тандалтын багийн ажлыг сайжруулах, хүнээ зөв, эрт эрэмбэлэх, эмнэлэгт камер суурилуулах талаар эмнэлгийн удирдлагуудад мэдээлж, коронавируст халдварын

үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан "Урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай" 01/51 тоот удирдамжийн дагуу ЧД-ийн 1-19 дүгээр хороонд 26 аж ахуйн нэгж байгууллага урьдчилсан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Шалгагдсан нийт 26 аж ахуйн нэгж байгууллагын 2 буюу 7.7% нь бага, 21 буюу 80.8% нь дунд, 3 буюу 11.5% нь их эрсдэлтэй гэсэн үнэлгээтэй тус тус дүгнэгдсэн байна. Шалгалтаар "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хууль, барилга угсралтын аюулгүй ажиллагааны норм, дүрэм журмыг хэрэгжүүлээгүй нийт 132 зөрчил илрүүлсний 64 зөрчлийг шалгалтын хугацаанд бүрэн арилгуулсан.

2022 оны 05 дугаар сарын 16-ний өдрөөс эхлэн МХЕГ-ын даргын баталсан 2022 оны 05 дугаар сарын 11-ний 01/66 тоот "Тэтгэврийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад урьдчилан сэргийлэх шалгалт хийх" удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын хэлтсийн Тэтгэврийн даатгалын сангийн 2020, 2021 оны төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалтыг анхан шатны болон санхүүгийн баримттай тулган хяналт шалгалтыг хийж байна.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн А/51 дүгээр захирамжийн хүрээнд "Чингэлтэй дүүргийн орон сууцны цахилгаан шат /лифт/-нд үзлэг, шалгалт хийх ажлын хэсгийн удирдамж"-ийн дагуу Чингэлтэй дүүргийн 1,2,3,4,5,6,9,10,15 дугаар хорооны нийт 69 байрны 101-н орцонд ашиглаж буй нийт 127 лифтийг хамруулан хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар "Хөдөлмөрлөх эрх, аюулгүй ажиллагааг хангуулан ажиллах тухай" улсын /ахлах/ байцаагчийн хугацаатай зөвлөмжүүд 41-г үйлдэж, НМХГ-ын "Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай" албан тоот мэдэгдэл 114-г хүргүүлсэн байна.

Чингэлтэй дүүргийн 12, 13, 15, 16, 19 дүгээр хороонд баригдаж буй ЧД, 19-р хороо, 240 хүүхдийн цэцэрлэг, 150 хүүхдийн бага сургуулийн цогцолбор барилга Саран Инж ХХК, ЧД, 13-р хороо, Өрхийн эмнэлгийн барилга Мандал голомт ХХК, ЧД, 12-р хороо, 120 хүүхдийн цэцэрлэг, 180 хүүхдийн бага сургуулийн цогцолбор барилга Хан атрибут ХХК нийт 11 барилгад Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2022 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн 10 дугаар захирамжаар байгуулагдсан дүүргийн нутаг дэвсгэрт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын гүйцэтгэл удаашралтай, ашиглалтад өгөх хугацаа хэтэрсэн, барилгын норм, чанар стандарт зөрчсөн, зураг төсөв холбогдох тооцоо судалгаа хангалтгүй байгаа барилга байгууламжид хяналт хийлээ. Тус ажлын хэсгийн хяналт шалгалтын дүгнэлтийг үндэслэн хангалтгүй ажлын явцтай байгаа гүйцэтгэгч компаниудын ажлын гүйцэтгэл, явцад үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөгөө өгч, зөрчилтэй байгууллагуудад 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02-02/192 дугаартай мэдэгдэл өгч ажилласан байна.

Чингэлтэй дүүргийн 14 сургууль, цэцэрлэгийг хамруулан хяналт шинжилгээ хийж ундны усны 10 дээж авч шинжлүүлэхэд 2 (20%) нь нянгийн тоо зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр, үзүүлэлттэй гарсан. Шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагчийн дүгнэлт 8-ийг үйлдэж, 2 сургуулийн ус нөөцлөх савыг дахин мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлж, давтан шинжилгээ хийлгүүлэн, стандартыг хангуулж ажилласан.

Хэсгийн болон зөөврийн усан хангамжтай нийт 15 хүүхдийн байгууллагад ус нөөцлөх савыг угааж халдваргүйжүүлэх гарын авлага зөвлөмжийг хүргүүлсэн.

МХЕГ-ын дэд даргын баталсан 2022 оны 01/29 тоот "Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн үдийн хоолны илчлэг, шимт бодисыг тодорхойлох хяналт шинжилгээ хийх" удирдамжийн хүрээнд 23 ЕБС-ийн үдийн хоолны хоол хүнстэй холбоотой бүртгэл хөтлөлт, хүнсний бүтээгдэхүүний зарцуулалтын мэдээлэлд үндэслэн сургуулийн үдийн хоолны илчлэг, шимт бодисын хэмжээг хүснэгтийн аргаар тооцож, 10 сургуулийн үдийн хоолноос дээж авч, лабораторийн шинжилгээгээр илчлэгийг тооцуулан, үнэлэлт дүгнэлт өгсөн. Хяналт шинжилгээний дүнгээр Үдийн хоолны дундаж илчлэг 178.75-690 ккал, уураг 8.38-28.9 гр, өөх тос 4.18-31.76 гр, нүүрс ус 23.92-144.69 гр байна.

МХЕГ-ын Тэргүүн дэд даргын баталсан 01/15 дугаартай "Хот суурин газрын хөрсний бохирдлын байдалд хяналт шинжилгээ хийх" удирдамжийн дагуу Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрийн тогтоосон 10 цэгээс хөрсний шинжилгээний дээж авч НМХГ-ийн төв лабораторийн нян судлалын лабораторид 10 хөрс, химийн шинжилгээнд 5 хөрсний дээж, Ханлаб ХХК-ийн лабораторид

хими хүнд металлын үзүүлэлт тодорхойлуулахаар 5 хөрсний дээжийг шинжилгээнд хамруулан хөрсний бохирдол болон хог хаягдалтай холбоотой 16 зөвлөмж, гарын авлага боловсруулан ажилласан.

МХЕГ-ын Тэргүүн дэд даргын баталсан 01/01 дугаартай "Ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир усанд хяналт шинжилгээ хийх" тухай удирдамжийн хүрээнд УСУГ-ын Төв цэвэрлэх байгууламжийн харьяа Чингэлтэй цэвэрлэх байгууламжийн технологийн горим, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, нийт 4 дээж авч, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын ХАБҮЛЛ-ийн хими, нян судлалын лабораторид шинжилгээнд хамруулахад итгэмжлэгдсэн лабораторийн 22-2734 дугаартай сорилын дүнгээр биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 2.8 дахин их, химийн хэрэгцээт хүчилтөрөгч зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 2.1 дахин их, умбуур бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1.3 дахин их байгаа нь Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус, Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартын 5.3 дахь заалтыг хангахгүй байсан тулд 02-03-242/44 дугаартай улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Хяналт шинжилгээ үргэлжилж байна.

### **ГАМШИГ, ОСОЛ, ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

"Гамшгаас хамгаалах тухай" хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын тушаал шийдвэр, албан даалгавар, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын 2022 онд дэвшүүлсэн зорилт, Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамж, бусад эрх зүйн баримт бичгүүдийг удирдлага болгон үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан.

Гал түймэр унтраах, аврах 10 дугаар анги 2022 оны эхний хагас жилд 156 удаагийн томилгоот харуул ээлжийн үүрэг гүйцэтгэх явцад гал түймрийн дуудлага нийт 180 удаа хүлээн авснаас, худал дуудлага 1, өөрөө унтарсан 2, иргэд унтраасан 7, зөрчил 26, анги тархалт хийж унтраасан 151 гал түймэр дээр нийт 55 цаг 05 минут ажиллаж 296,2 тонн гал унтраах бодис, 3217,49 литр шатахуун зарцуулан, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд учирч болох 2 Тэрбум 320 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалж, утаажилтын бүсээс 255 иргэнийг гаргаж, угаартсан 2, түлэгдсэн иргэн 2, амьсгалын бие даасан төхөөрөмж 186 ширхгийг хэрэглэж техникийн сааталгүй тактикийн алдаа гаргалгүй ажиллаж гал түймэр унтраасан нотломжийг тухай бүрд бүртгэж нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймрийн жижүүрийн байцаагч нарт хүргүүлж бүртгүүлэн ажилласан.

Дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/134 тоот захирамж дагуу "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах "сарын аяны хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 28-ний өдрийн хооронд дүүргийн 4-19 дүгээр хорооны Засаг дарга түүний ажлын албатай хамтран хороодын нутаг дэвсгэрт "Нэгдсэн өдөрлөг"-ийг 3 удаа зохион байгуулж ажилласан. Өдөрлөгт мэргэжлийн ангийн нийт 260 алба хаагч, тус хэлтсийн нийт 50 алба хаагч 2 техник хэрэгсэлтэйгээр ажиллаж хороод тус бүрийн жагсаалын бэлтгэл, техник хэрэгсэл багаж зэвсгэлэмжийн бүрэн байдал, анхны тусламж хэрхэн үзүүлэх, гамшиг ослын үед болон газар хөдөлсөн тохиолдолд хэрхэн арга хэмжээ авч ажиллах талаар цагийн байдлыг өгч богино хугацаанд хурдан шуурхай, оновчтой шийдвэр гаргах арга барилыг олгосон дадлагыг зохион байгуулж зөвлөмж сэрэмжлүүлэх материал нийт 416 ширхгийг тараан ажиллалаа.

"Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" албан даалгавар, Чингэлтэй дүүргийн онцгой комиссын даргын 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 02 албан даалгаврын хэрэгжүүлэх ажлын хүрээнд Гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх нийт 12 нэгдсэн арга хэмжээний хүрээнд ухуулга, сурталчилгааны ажлыг орон нутгийн телевизээр явуулсан сэрэмжлүүлэх шторк 77 удаа, байгууллагын цахим сайтад болон албаны сонинд мэдээлэл 288 удаа, цахим хаягт 321 удаа, сонин хэвлэлд 68 удаа, сонин хэвлэлд ярилцлага-9 удаа, орон нутгийн телевизэд ярилцлага-6 удаа, санамж тараах материал-23.728 ширхэг тараан 20,117 хүн, 16.220 айл өрхөд сургалт сурталчилгааг хүргэн ажиллалаа.

Дүүргийн Онцгой комиссын даргын 01, 02 дугаар албан даалгавруудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд үерийн аюултай бүсэд оршин суух айл өрхүүдэд албан шаардлага, мэдэгдэл өгч,

үерийн эрсдэлтэй хороодоор автомашины чанга яригчаар, шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх талаар заавар зөвлөмж, видео шторкийг нэг удаа бэлтгэн хоолойн бичлэг хийлгэж иргэд олон нийтэд түргэн шуурхай хөдөлгөөнт 2 автомашины чанга яригчаар 3-6 удаагийн давталттайгаар нийт 243 удаа хүргэж MN 25 дугаар суваг телевизэд сэрэмжлүүлэг видео шторк болон сэрэмжлүүлэх анхааруулах мэдээг 3-4 удаагийн давтамжтай нийт 66 удаа сэрэмжлүүлэг хүргэж, өрөг.mn zagig.mn мэдээллийн сайтад Гал түймэр унтраах аврах 10 дугаар ангийн салааны захирагч, ахмад Г.Мөнхбат 2 удаа, Гал түймэр унтраах аврах 10 дугаар ангийн гал сөнөөгч С.Алтансүх 1 цагийн ярилцлага мэдээллийг өнөөдөр сонинд тус тус өгч ажиллалаа.

Өнжмөл шар авсны гал түймэр болон ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг иргэдэд, сурталчлан хүн ам олноор цуглардаг Алтжин бөмбөгөр, Содон бөмбөгөр, Юмт бөмбөгөр, Тэди гар утас худалдааны төвүүдийн танхимын чанга яригчаар 2 удаагийн давтамжтайгаар нийт 88 удаа зөвлөмжийг хүргэж, Чингэлтэй дүүргийн Нийслэлийн засаг захиргааны III байрны лед дэлгэц, MN Tower төвийн гадна талбайн лед дэлгэц, дүүргийн 1-19 дүгээр хорооны цахим дэлгэцээр 3-4 удаагийн давтамжтайгаар иргэдэд сэрэмжлүүлгийг нийт 381 удаа явуулж ажиллалаа.

### **ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ГЭМТЭЛ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:**

Эхний хагас жилийн байдлаар зөрчлийн шинжтэй 3260 гомдол мэдээлэл хүлээн авснаас Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1 дахь заалтаар 1982, 14.7 дугаар зүйлийн 5 дах хэсгийн заалтаар 126, мөн хуулийн хуулийн 14.7 зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчилтэй 333, хурд хэтрүүлсэн 78 иргэнд зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулсаар шийдвэрлэлтээр нь ангилбал 206 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээн хуулийн хугацаанд шийдвэрлэж, хялбаршуулсан журмаар 2710, татгалзаж шийдвэрлэсэн 21, шийдвэрлэгдээгүй хуулийн хугацаанд шалгагдаж байгаа 315 байна.

Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг ослоос урьдчилан сэргийлэх, гудамж замын хөдөлгөөнд тавих хяналт зохицуулалтыг эрчимжүүлэх, хөдөлгөөнд оролцогчдын сахилга соёлыг дээшлүүлэх чиглэлээр гудамж замд хийсэн хяналт шалгалтаар нийт 38344 зөрчил илрүүлснээс, улсын дугаарын хязгаарлалт 11710, бүрэн бус 2239, хамгаалах бүс хэрэглээгүй 850, хориглосон нөхцөлөөр зогссон 5291, хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн 15, эгнээ байр буруу эзэлсэн 904 нийт 38344 иргэнийг 1.576.400.000 төгрөгөөр торгосон. Тээврийн цагдаагийн албанаас зарлагдсан 13 тээврийн хэрэгсэл, бусад албадаас зарлагдсан Цагдаагийн нийтлэг үүргийн дагуу 14, АСАП санд эрэн сурвалжлагдаж байсан 82 илрүүлж харьяаллын дагуу холбогдох байгууллага албан тушаалтанд шилжүүлэн ажилласан.

Тээврийн цагдаагийн албатай хамтран Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний дүрмийн 14 дүгээр зүйл 14.8 дахь заалт, Монгол Улсын зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 35, 36 дахь заалтад заасан "жолооч тээврийн хэрэгслийг зорчих хэсэг дээр түр, удаан зогсоох журам зөрчиж бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд явган хүний гарц дээр, замын тэмдгээр зөвшөөрөгдөөгүй явган хүний зам дээр зогсоож явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулсан" жолоочийн тээврийн хэрэгслийг фото зургаар баримтжуулан Замын хөдөлгөөний удирдлагын төвд файлаар хүргүүлэн тухайн тээврийн хэрэгслийн эзэмшигчийн гэрийн хаяг, бүртгэлтэй гар утсанд торгуулийн хуудсыг хүргүүлж нийт 6158 зөрчилд 61.580.000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулан ажиллаж байна. Тус Фото зургийн зөрчил дээр Засаг даргын тамгын газраас 2 урамшуулалт эргүүлийг ажиллуулж, ахлах зохицуулагч нар өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

Зам тээврийн хэрэг ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн алслагдсан гудамж зам болох зуслангийн замд 3-н байршилд тээврийн хэрэгслийн нийт 30,000,000 сая төгрөгийн өртөг бүхий хурд мэдээлэх электрон самбар байрлуулах саналыг Чингэлтэй дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлсэн боловч тендерт оролцох аж ахуй, нэгж байгууллага материалаа ирүүлээгүй тул тус ажлыг зогсоосон.

**ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:**

Цагдаагийн газрын Нэг, Хоёрдугаар хэлтсүүдэд 2022 оны эхний хагас жилд 16171 дуудлага мэдээллийг хүлээн авсан нь өмнөх оны мөн үеэс 19.5 хувиар өссөн. Нийт дуудлагын 11.1 хувийг хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага эзэлж байна.

Хүснэгт 1

Хүлээн авсан дуудлага, 2022.I-V

Өмнөх оны эхний саруудад, хорио цээр, хязгаарлалтын дэглэмээс шалтгаалан, ахуйн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн буюу гэр бүлийн хүчирхийллийн дуудлагын эзлэх хувийн жин их байсан бөгөөд, мөн үетэй харьцуулахад, гэр бүлийн хүчирхийллийн дуудлагын эзлэх хувийн жин 2.8 пунктээр буурч, харин гэмт хэрэг, зөрчлийн дуудлага болон зарлан мэдээллийн тоо, хувийн жин тус тус өсжээ.

"Угаартсан" гэх дуудлага 56 бүртгэгдэж, угаартсаны улмаас 2 хүн нас барж, 139 хүн хордсон. Өмнөх оны мөн үеэс "угаартсан" гэх дуудлагын тоо 7-оор, хордсон хүний тоо 11-ээр тус тус өсч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Дуудлага мэдээлэл /I, II хэлтэс/	2022.I-V		Өсөлт, бууралт	
	Тоо	Эзлэх %	тоо-р	хувиар
Гэмт хэрэг	716	4.4	179 ↑	33.3
Зөрчил	13413	82.9	2469 ↑	22.6
Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн	1790	11.1	-86	-4.6
Зарлан мэдээлэл	252	1.6	76 ↑	43.2
<b>Нийт</b>	<b>16171</b>		<b>2638 ↑</b>	<b>19.5</b>

Зураг 1. Гэмт хэргийн тоо, өсөлт бууралт

Дүүргийн нутагт бүртгэгдсэн зам тээврийн осол, зөрчлийн 4033 дуудлагыг Тээврийн цагдаагийн албанд хүлээн авсан нь өмнөх оны мөн үеэс 1777-оор буюу 78.8 хувиар өссөн. Зам тээврийн осол, зөрчлийн дуудлага хоногт 27, цагт 1 бүртгэгджээ.

Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 10897 гомдол мэдээллийг хүлээн авч, шалгасан нь өмнөх оны мөн үеэс 68.6 хувиар өссөн. Үүнээс: I хэлтэс 3659 (60.6%-иар өссөн), II хэлтэс 4292 (32.0%-иар өссөн), ЗЦХ 2946 (3.2 дахин өссөн). Нийт гомдлын 10397 буюу 95.4 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэжээ.

Шийдвэрлэсэн, гэмт хэргийн шинжтэй (3572) гомдол мэдээллийн 36.4 хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээн, 62.9 хувийг татгалзаж, 0.7 хувийг шилжүүлж,

Шийдвэрлэсэн, зөрчлийн шинжтэй (7325) гомдол мэдээллийн 75.8 хувийг зөрчлийн хэрэг нээж болон хялбаршуулсан журмаар шалгаж, 23.9 хувийг татгалзан, 0.3 хувийг бусад байгууллагад шилжүүлсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээсэн хувь 9.0 пунктээр, зөрчлийн хэрэг нээж болон хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэсэн хувь 4.1 пунктээр тус тус өссөн.

Гурав. Бүртгэгдсэн гэмт хэргийн талаар

Тус дүүргийн нутаг дэвсгэрт 2022 оны эхний 5 сард 1345 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 720-оор буюу 2.1 дахин өссөн.

Хүснэгт 2. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, илрүүлэлт

*Нийслэлийн төвийн 6 дүүргийн үзүүлэлттэй харьцуулбал*

**Гэмт хэргийн илрүүлэлт:** Нийт гэмт хэргийн илрүүлэлтийн хувь 59.4 (үүнээс: хөнгөн 61.1%, хүнд 24.6%) хувьтай байна.

Илрүүлэлт өмнөх оны мөн үеэс 30.4 пунктээр өссөн, Нийслэлийн дунджаас 10.6 пунктээр, улсын дунджаас 11.3 пунктээр тус тус өндөр, зэрэг үзүүлэлттэй байна.


Нутаг дэвсгэр	Бүртгэгдсэн гэмт хэрэг				Хэргийн илрүүлэлт	
	Тоо		Өсөлт, бууралт		Хувь	Өсөлт /пункт/
	2021.I-V	2022.I-V	тоогоор	хувиар		
1-9-р хороо	326	709	↑ 383	2.2 дахин	56.1	35.3
10-19-р хороо	299	636	↑ 337	2.1 дахин	63.7	21.0
Чингэлтэй	625	1345	↑ 720	2.1 дахин	59.4	30.4

Зураг 2. Гэмт хэргийн илрүүлэлт, өсөлт, бууралт

Гэмт хэргийн тоогоор Хан-Уул, Чингэлтэй дүүрэг хамгийн бага, илрүүлэлтийн түвшингээр тус дүүрэг хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Дүүргийн нутагт 2022 оны эхний 5 сард бүртгэгдсэн нийт (1345) гэмт хэргийн 87.1 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг (21.5%), хулгайлах (15.2%), залилах (50.5%) гэмт хэргүүд эзэлж байна.

*Сүүлийн 5 жилийн мөн үеийн үзүүлэлтийг харьцуулахад,*



Хулгайлах гэмт хэрэг 205 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 110-аар буюу 2.2 дахин өссөн үзүүлэлттэй байгаа ч, 2020 оны мөн үеэс 16.7 хувиар, 2019 оны мөн үеэс 2.2 дахин, 2018 оны мөн үеэс 2.5 дахин тус тус буурсан.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 70 хувиар, 2018, 2019, 2020 оны мөн үеэс 9.5-16.5 хувиар тус тус өссөн.

Залилах гэмт хэрэг энэ оны эхний 5 сард хамгийн ихээр бүртгэгдсэн байна.

Нийт гэмт хэргийн 560 буюу 41.6 хувь нь цахим орчинд, 12.6 хувийг согтуугаар, 0.4 хувийг мансуурсан үедээ, 3.7 хувийг бүлэглэн, 3.3 хувийг хүүхэд, 11.8 хувийг эмэгтэй хүн оролцон, 4.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, цахим орчинд 445-аар буюу 4.9 дахин, согтуугаар 85-аар, бүлэглэн 14-өөр, хүүхэд үйлдсэн 33-аар, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 57-оор, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 28-аар тус тус өссөн байна.

Гэмт хэргийн 35.2% нь гэр орон сууцанд, 20.7 хувь нь гудамж талбайд, 12.6 хувь нь олон нийтийн газарт, 8.6 хувь нь аж ахуйн нэгжид, 1.9 хувь нь авто замд, үлдсэн хувь нь төрийн, төрийн бус байгууллага, нийтийн тээвэр болон бусад газарт үйлдэгджээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, олон нийтийн газар, гудамж талбай, авто зам, нийтийн тээвэрт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо болон нийт хэрэгт эзлэх хувийн жин нь тус тус өссөн. Цахим хэлбэрээр үйлдэгдсэн залилах гэмт хэргийн тоо өссөнтэй уялдаатай бусад газарт үйлдэгдсэн үзүүлэлт ч огцом өссөн байна.

Өмнөх оны эхээр хорио цээр, хязгаарлалттай холбоотой гэр, орон сууцанд, ахуйн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэргийн нийт хэрэгт эзлэх хувийн жин их байсан бөгөөд, энэ оны эхний 5 сард 35.2% болж өмнөх оны мөн үеэс 8.0 пунктээр буурсан байна.

Тус дүүргийн нутаг дэвсгэрт бямба гарагт болон 06-19 цагт хамгийн их гэмт хэрэг бүртгэгджээ.

Тус газрын хэлтсүүдэд 2022 оны эхний 5 сард 43907 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27194-өөр буюу 2.6 дахин өссөн.

Зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан байдал:

- 41013 иргэн, 468 хуулийн этгээдийг 1 тэр бум 719 сая 098 мянган төгрөгөөр торгосон
- 1780 иргэнийг торгож-тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан
- 381 иргэнийг шүүхээр баривчлуулсан.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, зөрчил үйлдэж, торгох шийтгэл хүлээсэн хүний тоо 2.6 дахин, хуулийн этгээдийн тоо 6.2 дахин, торгуулийн хэмжээ 2.6 дахин, баривчлуулсан хүний тоо 2.1 дахин өссөн.

Хүснэгт 3. Зөрчлийн тоо, Зөрчлийн тухай хуулийн зүйл хэсгээр, 2022.I-V

Зөрчлийн төрөл (ЗТХ-ийн зүйлээр)	I хэлтэс	II хэлтэс	ЗЦХ	ЧДЦГ нийт	Дунд эзлэх %	Өсөлт, бууралт	
						тоогоор	хувиар
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих /14.7/	472		35458	35930	81.8	25294	3.4.0
Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах /5.1/	1015	3786		4801	10.9	1145	31.3
Хүний биед халдах /5.3/	419	433		852	1.9	193	29.3
Хуурамч дуудлага, мэдээлэл өгөх /15.9/	197	411		608	1.4	-61	-9.1
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих /5.4/	90	222		312	0.7	119	81.7
Хүүхдийн эрхийг зөрчих /6.20/	48	46		94	0.2	35	59.3
Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих /10.4/	8	34		42	0.1	-98	-70.0
Хулгайлах /8.6/	29	11		40	0.1	3	8.1
Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих /5.13/	1			1	0.0	-39	-97.5
Бусад	209	107	911	1227	2.8	603	96.6
<b>Дүн</b>	<b>2488</b>	<b>5050</b>	<b>36369</b>	<b>43907</b>		<b>27194</b>	<b>2.6.0</b>
<i>Дунд эзлэх хувь</i>	<i>6.7</i>	<i>11.5</i>	<i>82.8</i>				

Дүүргийн нутагт 2022 оны эхний 5 сард 1345 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 720-иор буюу 2.1 дахин өссөн, цар тахлын өмнөх үе буюу 2019 оны мөн үетэй харьцуулахад 11-ээр буюу 0.8 хувиар буурсан.

Залилах гэмт хэрэг 679 бүртгэгдсэний 538 буюу 79.2 хувь нь цахим орчинд үйлдэгдсэн, олон үйлдэлтэй байна. Эдгээрийн дийлэнх нь ард койн зарах гээд залилуулсан, "гар утас зарна, авна" "дугаар зарна" "автомашин зарна", "байр түрээсэлнэ", ажил явдалд хандив тусламж хүсэх гэх мэт цахим зар, мэдээллийн дагуу хандаж залилуулсан байна. Хохирогчдын 74.6 хувь нь 18-39 насныхан, 72.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй хүмүүс байгаа бөгөөд эх сурвалжийг нягталж үзэхгүй, амар хялбар аргаар мөнгө олох гэсэн ашиг сонирхол нь залилах гэмт хэргийн хохирогч болох, уг гэмт хэрэг үйлдэгдэх боломж нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 58 гэмт хэрэг, үүнээс 24.3 хувь нь архидалтаас, 63.8 хувь нь хардалт, 8.6 хувь нь таарамжгүй харилцаанаас, 1.7 хувь нь эдийн засгийн хараат байдлаас шалтгаалсан. Үүний дотор бие мах бодийн хүчирхийлэлд 6-9 насны 3 хүүхэд өртөж хөнгөн гэмтсэн бөгөөд 2 нь төрсөн эцэг нь архидан согтуурснаас, 1 нь хойд эцгийн зан төлөвийн таагүй байдлаас үйлдэгджээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн 46.8 хувь, хүүхдийн эрх зөрчих зөрчлийн 51.1 хувь нь тус тус согтуугаар үйлдэгдсэн байна.

### **ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ТАЛААР:**

2022 оны эхний хагас жилийн байдлаар цахим системээр мэдээлэл өгвөл зохих 638 байгууллагаас 285 ААНБ-ыг (44.7%) цахим хэлбэрээр статистик мэдээ илгээх нэвтрэх нэр, нууц үг өгч мэдээг нягтлан шалгаж, Нийслэлийн Статистикийн газарт алдаагүй дамжуулж ажилласан. Дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтээр “Чингэлтэй дүүрэг-2021” эмхэтгэлийг нэгтгэлд орох материалыг хэлтэс албадаас хүлээн авсан ба нэгтгэн боловсруулах ажил хийгдэж байна. Албан ёсны болон захиргааны статистик мэдээлэлд үндэслэн дараах 10 төрлийн танилцуулга судалгааг эмхэтгэн, тархаахад бэлэн болгоод байна.



Статистикийн мэдээг цахим хэлбэрээр мэдээлэх боломжтой 638 ААНБ-ийн мэдээллийг татварын НАӨТ-ын тайлантай тулгалт хийж, мэдээллийн зөрүү гарсан тохиолдолд ААНБ-тай холбогдон тодруулга хийж ажиллав.

Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтын явцын мэдээг 7 хоног бүр гаргаж, Дүүргийн Засаг дарга, хороодын зохион байгуулагч нарт танилцуулан баяжилтыг тогтмол хийх, алдааг засварлах үүрэг өгч ажиллаж байна. Шинэ төрсөн 2238 хүүхэд, нас барсан 252 иргэний мэдээллийг бүртгэж, он гарсаар өрх, хүн амын 5106 алдаа буюу 92.7 хувийг засварласан байна. Хаягт амьдардаггүй иргэдийн боловсрол, гэрлэлт, хөдөлмөр эрхлэлт зэрэг үзүүлэлт тодорхойгүй тул эдгээр иргэдийн мэдээллийн алдаа засварлах боломжгүй байна.

### **НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНААС:**

Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар нь дүүрэг, дүүргийн өмчит болон харьяа байгууллага, хороодын барилга, байгууламжийн ашиглалт, засвар, харуул хамгаалалт, камержуулалт, камер арчлалт, дотоод сүлжээ, интернэтийн засвар, цахилгаан, сантехник, цэвэр, бохир ус, дулаан дамжуулах инженерийн шугам сүлжээний засвар, авто бааз, авто зогсоол, ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр 2021 оны 11 дүгээр сард Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр байгуулагдсан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасны дагуу архивын баримтын аюулгүй байдал, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор Дүүргийн Засаг даргын Тамгын газрын В1 давхарт байрлах агуулахын зориулалтаар ашиглагдаж байсан 40м2 талбай бүхий өрөөг хадгаламжийн сангийн зориулалтаар засварлах ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 18-ны өдрүүдэд өөрсдийн ажилтан, албан хаагчдаар гүйцэтгүүлэн хүлээлгэж өглөө.





Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын гадна мэдээллийн самбар болон хажуугийн шонгийн гэрэлтүүлгийг шинэчлэх, шаардлагатай засварыг хийж сэргээн будах ажлыг 2022 оны 05 дугаар сарын 05-наас 19-ний өдрүүдэд өөрийн ажилчдаар гүйцэтгүүлэн ашиглахад бэлэн болгож хүлээлгэн өглөө.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын гаднах авто зогсоолын үйлчилгээ хангалтгүй, үйлчилгээний талаар санал, гомдол ихээр гарах болсон тул үйлчилгээг сайжруулах зорилгоор тэмдэглэгээг сэргээн будах, автомат хаалт хийх, зогсоолыг камержуулах ажлыг авто зогсоолын үйлчилгээ үзүүлэгч "Дабль Бридж" ХХК-тай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 24-нөөс 05 дугаар сарын 16-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

Чингэлтэй дүүргийн 11-р хорооны барилга нь 2008 онд ашиглалтад орсон, ашиглалтад орсноос хойш засвар хийгдээгүйгээс албан хаагчдын ажиллах болон иргэдийн тав тухтай орчинд үйлчлүүлэх нөхцөл хангагдахгүй болсон тул хорооны байранд 2022 оны 05 дугаар сарын 09-нөөс 31-ний өдрүүдэд дараах байдлаар их засвар хийлээ.

Чингэлтэй дүүргийн 8, 13, 15 дугаар хороодын байрны дээвэр хуучирч дээврээс ус гоожих, дулаан алдах зэрэг хүндрэл үүссэн бөгөөд засварын ажлыг 2022 оны 05 дугаар сарын 13-наас 20-ны өдрүүдэд гүйцэтгэлээ.

10-р хорооны цэвэр усны шугам солих ажил, 5, 15 дугаар хорооны засаг даргын өрөөний шалыг шинэчлэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр болон 1-19 дүгээр хорооны байрны өдөр тутмын ашиглалтын явцад цахилгаан, сантехник болон бусад засварын 109 дуудлага ирсэн бөгөөд эдгээрийг тухай бүрт засварлан хэвийн ажиллагааг хангаж ажиллалаа. Засвар үйлчилгээний дуудлагыг ангилан авч үзвэл:



Тайлант хугацаанд дээрх засвар үйлчилгээнд нийт 61,8 сая төгрөг зарцуулсан бөгөөд эдгээрийг авч үзвэл:

**ЗАСВАРЫН АЖИЛД ЗАРЦУУЛСАН ЗАРДАЛ**



**Хайрхан хөгжлийн төв**

Бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд, иргэдийн эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий "Хайрхан хөгжил төв" 1,2, 3 орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь тайлангийн хугацаанд Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/357 тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 14,16,18,19 дүгээр хороодын ахмад, дунд, оюутан залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд батлагдсан цагийн хуваарийн дагуу 19-р хорооны 491 иргэн, 18-р хорооны 323 иргэн, 16-р хорооны нь 408 иргэн буюу давхардсан тоогоор 1222 иргэнд үйлчилсэн.

**Хайрхан хөгжил төвийн спорт зааланд** батлагдсан төлбөрт үнээр нийт 30 удаа нутгийн зөвлөл, байгууллага хамт олны тэмцээн уралдаан зохион байгуулж, 5200 иргэд хамрагдсан.

**Хайрхан хөгжил төвийн урлаг зааланд** албан болон улсын, хувийн байгууллагуудын сургалт, семинар, лекцийг төлбөртэй болон төлбөргүй байдлаар нийт 6 удаагийн тэмцээнд 500 иргэн хамрагдсан үзүүлэлттэй байна.

**Хайрхан хөгжил төвийн хөл бөмбөгийн талбайд:** Хөл бөмбөгийн талбайд амралт, зугаалга, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж байгаа иргэдэд цэвэр цэмцгэр байдлаар нээлттэй үнэгүй үйлчилж Чингэлтэй дүүргийн ахмад настан, өсвөр үеийн хүүхэд залуучуудын дунд хөл бөмбөгийн талбайд, улсын болон дүүргийн чанартай тэмцээн уралдаан үнэ төлбөргүй зохион байгуулсан. Хөл бөмбөг, сагсан бөмбөгийн талбай болон газрын теннисний талбайгаар иргэдэд батлагдсан хуваариар төлбөртэй үйлчилсэн. Тайлант хугацаанд хөл бөмбөг, сагсан бөмбөгийн талбай болон газрын теннисний талбайгаар иргэдэд 10 тэмцээн зохион байгуулан нийт иргэн 2300 хамрагдсан.

Дүүргийн засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн бэлтгэл сургуулилтад дэмжлэг үзүүлж хамтран ажилсан. Тайлант хугацаанд дүүргийн засаг даргын дэргэдэх "Хөл бөмбөг нэмэх Монгол" НҮТББ өсвөрийн шигшээ багийн бэлтгэл сургуулилтад дэмжлэг үзүүлж, долоо хоног бүр 2 удаа 2 цагаар Хөл Бөмбөгийн Талбайд бэлтгэл хийлгэж дэмжин ажиллаж байна.

МУ-ын Гавьяат Багш Ч.Шархүү агсны нэрэмжит Чингэлтэй -30 Мастер ангиллын тамирчдын хөл бөмбөгийн тэмцээн Хайрхан хөгжлийн төвийн Хөл бөмбөгийн талбай дээр амжилттай зохион байгуулагдлаа.



Монгол Оросын Холбооны улсын Буриад улсын" Нөхөрсөг" Граунд Гольф,Дартсын тэмцээн боллоо.

Улсын Аварга Шалгаруулах анхдугаар тэмцээнийг Чингэлтэй хайрхан Хөгжилийн төвийн ногоон талбайд үнэ төлбөргүй 2022.06.12-ны өдөр зохион байгууллаа.



Чингэлтэй Дүүргийн Ахмадын Хөл Бөмбөгийн Холбооны аварга шалгаруулах тэмцээн Хайрхан Хөл бөмбөгийн талбайд үнэ төлбөргүй 2022 оны 5 дугаар сарын 22, 23, 27, 28, 29-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа.



#### Хоймор хайрхан амралтын талаар:

"Хоймор хайрхан амралт" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын төсвийн шууд захирагч нь хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Чингэлтэй дүүргийн "Хоймор Хайрхан амралт" ОНӨТҮГ нь Монгол Улсын үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль тогтоомж, Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 12 сарын 11-ны өдрийн 72 дугаар тогтоол, Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2021 оны "Бүтэц орон тооны дээд хязгаарыг батлах тухай" А/125 дугаар захирамжийн дагуу дарга-1, нягтлан бодогч-1, зохион байгуулагч-2, нярав-1 туслах ажилтан-2, тогооч-2, сахиул-2, үйлчлэгч-2 гэсэн орон тоо, бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тус амралтын газар нь төв байр болон 24 ортой амралтын 6 байртай бөгөөд нэг элжиндээ 24 хүн хүлээн авах хүчин чадалтай.

УИХ-н гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга М.Оюунчимэгийн санаачилгаар тус амралтын газрын гадна тохижилтыг сайжруулах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар

“Garden city” ХХК ажиллаж мод, бут сөөг тарих, цэцэрлэгжүүлэх, сүүдрэвч барих, тоглоом суурилуулах болон зам талбайн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэж байна. Уг ажлын хүрээнд нийт 60 ширхэг гацуур мод тарихаар төлөвлөгдсөнөөс өнгөрсөн онд 15 ширхэг гацуур модыг тарьж суулгасан бол үлдсэн 45 гацуур модыг 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр бүрэн тарьж суулган усалгаа арчилгаа хийх, бордох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Мөн зам талбайн тохижилтын ажлын гүйцэтгэл одоогоор 80 орчим хувьтай явагдаж байгаа бөгөөд энэ ондоо багтаан гүйцэтгэлийг 100 хувь болгохоор зорин ажиллаж байна. Уг ажлын явцтай УИХ-ын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга М.Оюунчимэг тэргүүтэй ажлын хэсэг хүрэлцэн ирж ажил байдалтай танилцан заавар зөвлөгөө өгч санал солилцон ажиллаа.



Дэлхий нийтийг хамарсан халдварт Коронавируст (КОВИД-19) цар тахлын нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх, Монгол Улсын Ариун цэврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 8 дугаар зүйл, 9 дүгээр зүйл, 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалт, 18 дугаар зүйлийн 1.1 дэх заалт болон бусад хууль тогтоомжийн дагуу ариутгал халдваргүйжүүлэлт, шавьж, мэрэгч устгалын ажлыг “Баатарван Жаргалант” ХХК-тай хийгдсэн гэрээний дагуу 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр тус амралтын газар эзлжит ариутгал халдваргүйжүүлэлт мөн оны 05 дугаар сарын 24-ны өдөр бохир усны цооногт үнэр арилгах, өтгөн ялгадас задлах, ойр орчмын бүс газрыг ариутгах ажлыг хийлгэсэн.

Төсвийн тухай хууль, холбогдох тогтоомж зааврын журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулан, материаллаг баазыг бэхжүүлэхэд анхаарч ажиллаж байна. Нийслэлийн аудитын газраас тус газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд 2022 оны 2 дугаар сард аудит хийсэн ба аудитын дүгнэлтээр зөрчилгүй дүгнэлттэй шалгагдсан ба нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөгдөн, батлагдсан төсвийн хүрээнд санхүүгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байн

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**

“Харилцаа холбооны тухай хууль” болон холбогдох дүрэм, журмын дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс алба, хороодоос үзүүлж буй төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл боловсруулж иргэдэд хүргэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, олон нийттэй харилцах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, иргэдийг мэдээ, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан.

Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс албадын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх цаг үеийн мэдээлэл, өдөр тутмын мэдээ, зөвлөмжийг дүүргийн [www.chingeltai.gov.mn](http://www.chingeltai.gov.mn) цахим хуудас, Чингэлтэй дүүрэг / Chingeltei District фэйсбүүк пэйж хуудас,

дүүргийн Онцгой Комиссын фэйсбүүк пэйж хуудасны хэвийн үйл ажиллагааг ханган нийт 554 мэдээ, мэдээллийг байршуулан иргэд хандагчаас 26,965 хандалт авсан.

**Үүнээс:**

- ЗДТГ-н Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах тасаг 439 мэдээг бэлтгэж,
- Нийслэлийн ЗД-н мөрийн хөтөлбөр, ЗДТГ-н үйл ажиллагаатай холбоотой мэдээ 90
- Бусад -25 нийт 554 удаагийн мэдээ мэдээлэл иргэдэд хүрсэн.

Нийт цахимаар хүргэсэн мэдээллийн:

- Эерэг хандлага сэтгэгдэл 2369,
- Сөрөг хандлага сэтгэгдэл 15, 1
- Иргэдэд нийцсэн сэтгэгдэл 6,761
- Дагагч иргэд 7, 820 мэдээг шейрлэн дэмжин түгээсэн.

Дүүргийн Засаг дарга, ЗДТГ-с хэрэгжүүлж буй ажиллагааг иргэдэд мэдээлэн сурталчилсан 18 постерын эх бэлтгэлийг дүүргийн Чингэлтэй дүүрэг / Chingeltei Distric фэйсбүүк пэйж хуудас, нийт хороодын фэйсбүүк группт байрлуулсан.



Дүүргийн Засаг дарга, ЗДТГ-с зохион байгуулсан 15 үйл ажиллагааны зураг авалтыг хийж видео бичлэгийг дүүргийн Чингэлтэй дүүрэг / Chingeltei Distric фэйсбүүк пэйж хуудаст байрлуулсан.

Нийт 62 хурал зөвлөгөөн, арга хэмжээ, уулзалтын гэрэл зураг авч мэдээ бэлтгэн дүүргийн "Чингэлтэй дүүрэг" пэйж хуудсанд байршуулсан.



Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг боловсруулан хэрэгжүүлж "ТВ-5" телевиз, "Зариг.мн", "Эгүүр.мн", "Улстөрч.мн", "Isee.mn" зэрэг 5 байгууллагатай хамтран ажиллах болсон. Дүүргийн үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг тухай бүр хэвлэл мэдээллийн байгууллагад мэдэгдэн, мэдээллийг олон нийтэд түргэн шуурхай, ил тод хүргэж ажилласан.

Үүнд:

- Газар чөлөөлөлт буюу зөвшөөрөлгүй барьсан гараашны буулгалт, тээвэрлэлтийн талаар "Улстөрч.мн" сайттай хамтран Фэйсбүүк пэйжээр шууд дамжуулан иргэдэд ил тод нээлттэй хүргэж ажиллав.
- Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх таниулах өдөрлөгт "TV-5 телевиз", "Зариг.мн" сайтаар мэдээ бэлтгүүлэн иргэдэд анхааруулга, мэдээг хүргэн ажилласан.
- "Эртэч Чингэлтэй аян", "Хүүхдийн баяр", "Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг Олон улсын өдөр"-т зориулан зохион байгуулсан арга хэмжээг хамтран ажиллах гэрээ бүхий хэвлэл мэдээллийн байгууллагаар мэдээ, мэдээллийг хамтран бэлтгэж олон нийтэд хүргэн ажилласан.
- "Ковид-19" халдвараас урьдчилан сэргийлэх, өдөр тутмын дархлаажуулалтын постер мэдээг 2022 оны 03-р сарын 28-наас 2022 оны 04-р сарын 08-ныг хүртэл фэйсбүүк пэйж хуудсанд оруулж ажилласан.

**Шилэн данс:** Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд сар бүрийн 08-ны өдрийн дотор Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн нэгдсэн мэдээ зэрэг хугацаат мэдээллийг сар, улирлын байдлаар [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд тухай бүр байршуулж мэдээлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Мөн хэлтсийн мэргэжилтэн, төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарыг хариуцсан мэдээллээ хуулийн хугацаанд оруулж байхыг сануулан, хяналт тавин ажилласан.

#### **Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:**

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны ээлжит хоёрдугаар хуралдаанаар хэлэлцэн батлагдсан 2022 оны төсвийн орлого, зарлагын сар, улирлын хуваарийг хийж, дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Засаг даргын "Төсвийн хуваарь батлах тухай" А33 тоот захирамжаар батлуулан хэрэгжүүлсэн.

Мөн 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр Монгол Улсын Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон. Хууль, дүрмийн дагуу Нийслэлийн 2022 оны төсөвт өөрчлөлт орсны дараа дүүргийн төсвийн тодотголын хийгдэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

2. Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2015 оны 7, 2016 оны 431, 2021 оны 109, 190 дүгээр тушаал, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журам, тэдгээртэй нийцүүлэн гаргасан заавар, журам болон бусад эрх зүйн актын хүрээнд дүүргийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог өдөр бүр хүлээн авч, байгууллагын батлагдсан төсөв, зарцуулалтын эрхийн баталгаа, өөрийн орлогын гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын зүйлээр нь хянаж, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүрдэл болох 14622 ширхэг баримт бичгийг шалгаж, 213 069 442 506 төгрөг 44 мөнгөний гүйлгээг 2022 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн байдлаар түргэн шуурхай баталгаажуулан, банк хооронд дамжуулан ажилласан.

3. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43, 388 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын 2022 оны "Төсвийн үр өгөөж, сахилга хариуцлагыг сайжруулах" тухай А/45 дугаар захирамжийг 2022 оны 4/246 тоот албан бичгээр Татварын хэлтэс болон харьяа 67 байгууллагын төсвийн шууд захирагч нарт хүргүүлж, өдөр тутмын үндсэн баримтаар хяналт тавин ажилласан. Орон нутгийн төсөвт 12 байгууллагын бүлэг хоорондын болон сар хоорондын төсөвт зохицуулалт хийх тухай саналыг судлан, дүүргийн Засаг даргын 2022 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн А/68, 3 дугаар сарын 23-ны өдрийн А/107, 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/153, 5 дугаар сарын 10-ны өдрийн А/171, 6 дугаар сарын 3-ны

өдрийн А/202 дугаар захирамжаар төсөвт өр авлага үүсгэхгүй, зохистой удирдлага хэрэгжүүлэх үүднээс орон нутгийн төсвийн зарлага, сургууль цэцэрлэгийн төсвийн харилцааг тус тус үндэслэн 5 удаа төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан, дүүргийн Засаг даргын захирамж гарсан. Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээлгэх 56 хүсэлт ирүүлснийг Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийг нээсэн.

4. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43, 388 дугаар тогтоол, Монгол Улсын 2022 оны Хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Төсвийн зарлагын гүйцэтгэлд хяналт тавин, төсвийн хэтрэлт, хэмнэлт, өр авлагын шалтгааныг тогтоон урьд онтой харьцуулсан дүн шинжилгээ хийж, 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн судалгааг /ТҮ1-ТҮ3 ажилчдын/ авч нэгтгэн, өр төлбөр үүссэн 32 байгууллагын байр ашиглалттай холбоотой 198,2 сая төгрөгийн, урсгал завсрын 107,3 сая төгрөгийн өр төлбөр үүсэхээр байсныг ашиглалтад орохоор хүлээгдэж буй сургууль, цэцэрлэгийн төсвөөс шилжүүлэн FISCAL баазад өөрчлөлт оруулан өр төлбөрийг 100 хувь бууруулж ажилласан.

5. Дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар авч үзвэл:

- Улсын төсөвт 2 377.5 сая төгрөг төвлөрөхөөс 2 373.3 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 99.8 хувь,
- Нийслэлийн төсөвт 987.0 сая төгрөг төвлөрөхөөс 1 356.5 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 137.4 хувь,
- Орон нутгийн төсөвт 11 615.2 сая төгрөг төвлөрөхөөс 11 377.0 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 97.9 хувийн хэрэгжилттэй,

Өссөн дүнгээр төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг авч үзвэл:

- Улсын төсөвт 19 194.4 сая төгрөг төвлөрөхөөс 24 766.9 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 129.0 хувь,
- Нийслэлийн төсөвт 5 156.7 сая төгрөг төвлөрөхөөс 9 842.3 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 190.95 хувь биеэлж Орон нутгийн төсөвт 46 244.7 сая төгрөг төвлөрөхөөс 43 382.6 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 93.8 %-ын тус тус биелэлттэй гарч дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн биелэлтийг хангахад хөрөнгийн эх үүсвэрийг бий болгож, орлогоороо зарлагаа нөхөн бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.

Дүүргийн Засаг даргын 2022 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн А/68, 3 дугаар сарын 23-ны өдрийн А/107, 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/153, 5 дугаар сарын 10-ны өдрийн А/171, 6 дугаар сарын 3-ны өдрийн А/202 дугаар захирамжуудаар тус тус Төсвийн хуваарьт 5 удаа өөрчлөлт оруулж харьяа хэлтэс албадад шинэчилсэн хуваарийг хүргүүлсэн. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг сар бүрийн 05-ны өдрийн дотор татварын хэлтэстэй, тооцоо нийлж, баталгаажуулан, удирдлагад тухай бүр танилцуулан ажилласан. Дүүргийн татварын орлогыг нэр төрлөөр дүүргийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлэх, төсвийн байгууллагуудын харилцах дансанд орсон орлогыг тухай бүр холбогдох эдийн засгийн ангилалд бүртгэх, сарын мэдээний өр авлагыг бүртгэх тус тус журнал ваучераар тухай бүрт төрийн сангийн программд бүртгэн ажилласан. Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Татварын хэлтэс, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зэрэг байгууллагуудын нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийг нээж ажилласан. Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцооны гүйлгээг өөрчлөлт оруулсан төсвийн хуваарь, санхүүжилтийн багцын олгосон эрхийн дагуу цаг хугацаанд хөнгөн шуурхай бүрэн эрсдэлгүй хянан гүйцэтгэж ажилласан.

Батлагдсан төсвийн хуваарийн өөрчлөлт, зарцуулаагүй санхүүжилтийн эрхийн үлдэгдлээс орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын зардлын үндсэн баримтыг үндэслэн хянах, шийдвэрлэх, зохицуулах, гүйцэтгэх, хяналт тавих ажлуудыг цаг тухай бүр заавар, журам, дүрмийн дагуу шийдвэрлэн ажилласан.

Мөн дүүргийн төсвийн шууд захирагч нарт төсвийг үр ашигтай зарцуулах талаар дүүргийн Засаг даргын 2022 оны "Төсвийн үр өгөөж, сахилга хариуцлагыг сайжруулах" тухай А/45 дугаар

захирамжийг 2022 оны 4/246 тоот албан бичгээр Татварын хэлтэс болон харьяа 67 байгууллагын төсвийн шууд захирагч нарт хүргүүлж, өдөр тутмын үндсэн баримтаар хяналт тавин ажилласан.

7. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 08-ны өдрийн дотор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.

8. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 32 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын албан даалгаврын хүрээнд Төрийн албан хаагчдын гаргасан зөрчил болон сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх, ажлын байранд архидан согтуурах, архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон тухай урьдчилан сэргийлэх мэдэгдлийг шуурхайн хурлаар танилцуулах арга хэмжээг авч ажилласан ба мөн төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг хүргэх ажлыг хийж хэрэгжүүлсэн.

**Шилэн данс:** Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд сар бүрийн 08-ны өдрийн дотор Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн нэгдсэн мэдээ зэрэг хугацаат мэдээллийг сар, улирлын байдлаар [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд тухай бүр байршуулж мэдээлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Мөн хэлтсийн мэргэжилтэн, төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарыг хариуцсан мэдээллээ хуулийн хугацаанд оруулж байхыг сануулан, хяналт тавин ажилласан.

**Халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлаас:** 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар халдварт цар тахлын эрсдэл нэмэгдэхээс урьдчилан сэргийлж, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, мэргэжлийн хэлтэс албадын бэлэн байдлыг хангахад дүүргийн Засаг даргын 2022 оны захирамжийн дагуу Засаг даргын нөөц сангаас 56.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Мөн 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэхэд зарцуулагдсан мөнгөн дүн байхгүй байна.

**E-balance:** Дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагуудын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг дүүргийн хэмжээнд 80.5 хувьтай хүлээн авсан. Тайлан хүлээн авалтаар нийт тайлан ирүүлэх ёстой 12509 аж ахуйн нэгж, байгууллагаас:

- Тайлан баталгаажсан 8842 буюу 70,7 хувь,
- Тайлан баталгаажуулаагүй алдаатай 1229 буюу 9,8 хувь,
- Тайлан огт гаргаж ирүүлээгүй 2451 буюу 19,6 хувь байна.

Дүүргийн төсөвтэй харьцдаг нийтийн сонирхлын болон том аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг Сангийн сайдын 2016 оны 41 дүгээр тушаалын хавсралт журмын дагуу цахим санхүүгийн E-баланс программаар, 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийтийн сонирхлын байгууллагуудын дүрмийн сан нэмэгдүүлэх тухай, Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаал болон тухайн байгууллагын хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол шийдвэрийг үндэслэн 33 байгууллагын завсрын тайланг хуулийн хугацаанд хянаж, баталгаажуулсан.

Мөн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд цахим санхүүгийн программд илгээгээгүй 23 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн 11.18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6, 1.25-д заасан заалтаар хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх торгуулийн арга хэмжээ авч, Төрийн сангийн 100200700956 дансанд 12,8 сая төгрөгийг төвлөрүүлэн хуулийн хугацаанд Прокурорын байгууллагаар хянуулан ажилласан.

Дүүргийн прокурорын байгууллагын 2022 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 1/2192 тоот албан бичгийн дагуу "Зөрчлийн нэгдсэн бүртгэл" аяныг зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу Дүүргийн прокурорт 2017-2021 оны дуусталх Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн 11 боть баримтыг хугацаанд нь хүргэж, бүртгэлд хамруулан ажилласан.

Сангийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 46 дугаар тушаалын хавсралт журмын дагуу 81 аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим санхүүгийн программд залруулсан ба 2022 оны эхний хагас жилийн байдлаар аудитын байгууллага нь хүлээн



зөвшөөрөөгүй 154 аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг Е-баланс цахим санхүүгийн программд баталгаажуулсан ба Улсын бүртгэлийн газар өөрчлөлт орж байгаа 60 /өссөн дүнгээр/ аж ахуйн нэгж, байгууллагуудын завсрын санхүүгийн тайланг хянаж баталгаажуулсан. Татварын хяналт шалгалтаар орж татан буугдсан 19 аж ахуйн нэгж байгууллагын тайланг хянаж, Е-баланс программаас хасалт хийж ажилласан байна.

**Халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлаас:**

2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар халдварт цар тахлын эрсдэл нэмэгдэхээс урьдчилан сэргийлж, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, мэргэжлийн хэлтэс албадын бэлэн байдлыг хангахад дүүргийн Засаг даргын 2022 оны захирамжийн дагуу Засаг даргын нөөц сангаас 56.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Мөн 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэхэд зарцуулагдсан мөнгөн дүн байхгүй байна.

**E-balance:** Дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагуудын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг дүүргийн хэмжээнд 80.5 хувьтай хүлээн авсан. Тайлан хүлээн авалтаар нийт тайлан ирүүлэх ёстой 12509 аж ахуйн нэгж, байгууллагаас:

- Тайлан баталгаажсан 8842 буюу 70,7 хувь,
- Тайлан баталгаажуулаагүй алдаатай 1229 буюу 9,8 хувь,
- Тайлан огт гаргаж ирүүлээгүй 2451 буюу 19,6 хувь байна.

Дүүргийн төсөвтэй харьцдаг нийтийн сонирхлын болон том аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг Сангийн сайдын 2016 оны 41 дүгээр тушаалын хавсралт журмын дагуу цахим санхүүгийн Е-баланс программаар, 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийтийн сонирхлын байгууллагуудын дүрмийн сан нэмэгдүүлэх тухай, Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаал болон тухайн байгууллагын хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол шийдвэрийг үндэслэн 33 байгууллагын завсрын тайланг хуулийн хугацаанд хянаж, баталгаажуулсан.

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд цахим санхүүгийн программд илгээгээгүй 23 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн 11.18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6, 1.25-д заасан заалтаар хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх торгуулийн арга хэмжээ авч, Төрийн сангийн 100200700956 дансанд 12,8 сая төгрөгийг төвлөрүүлэн хуулийн хугацаанд Прокурорын байгууллагаар хянуулан ажилласан.

Дүүргийн прокурорын байгууллагын 2022 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 1/2192 тоот албан бичгийн дагуу "Зөрчлийн нэгдсэн бүртгэл" аяныг зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу Дүүргийн прокурорт 2017-2021 оны дуусталх Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн 11 боть баримтыг хугацаанд нь хүргэж, бүртгэлд хамруулан ажилласан.

Сангийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 46 дугаар тушаалын хавсралт журмын дагуу 81 аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим санхүүгийн программд залруулсан ба 2022 оны эхний хагас жилийн байдлаар аудитын байгууллага нь хүлээн зөвшөөрөөгүй 154 аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг Е-баланс цахим санхүүгийн программд баталгаажуулсан ба Улсын бүртгэлийн газар өөрчлөлт орж байгаа 60 /өссөн дүнгээр/ аж ахуйн нэгж, байгууллагуудын завсрын санхүүгийн тайланг хянаж баталгаажуулсан. Татварын хяналт шалгалтаар орж татан буугдсан 19 аж ахуйн нэгж байгууллагын тайланг хянаж, Е-баланс программаас хасалт хийж ажилласан байна.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 13 дугаар тогтоолоор батлагдсан 188,600,000 (KLCLK18kP8C033771) арлын дугаартай (Хьюндай) маркийн 7918 УНӨ, KLTCH4CK5CK000024 арлын дугаартай (Deawoo) маркийн 7928 УБЧ улсын дугаартай тусгай зориулалтын цистэрн авто машинуудыг дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ-т өмчид бүртгэж өгөх талаар Нийслэлийн өмчийн харилцааны газарт 2022 оны 3/1293 тоот албан бичгүүдээр хүсэлт гарган ажилласан.

**ТАВДУГААР БҮЛЭГ: “БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ”**

ЗДТГ-аас, дүүргийн ИТХ, Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Хар тамхитай тэмцэх газартай хамтран “Анзаар” аяныг зохион байгуулж, ЗДТГ-н нийт 89 төрийн албан хаагч, Ерөнхий боловсролын 20 сургуулийн 1500 гаруй багш ажилтан, 2000 гаруй эцэг эхэд сургалтаар мэдээллийг хүргэн ажилласан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсээс Тогтвортой хөгжлийн зорилтын дэд хороо, НҮБ-ын Хүүхдийн Сан, НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, People in Need ОУТББ-ын санаачилгаар Эрүүл мэндийн яам, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Өсвөрийн Парламенттай хамтран “Өсвөрийн Парламент”-ын гишүүдээр төлөөлүүлж өсвөр насныханд эрүүл зөв хооллох мэдлэг мэдээлэл олгох, амьдралын зөв дадал зуршилд уриалах, хөтөлбөрөөс олж авсан мэдлэгээ үе тэнгийнхэн, анги сургуулийнхандаа түгээх зэрэг нөлөөлөл үзүүлэх, эрүүл хооллолт, эрүүл амьдрахуйн талаар энгийн арга барилуудыг эцэг эхчүүд, багш нарт түгээн уриалах зорилгоор “Эрүүл хооллолт-Эрүүл ирээдүй” нөлөөллийн ажлыг 2022 оны 04 сарын 25-05 сарын 01-ний өдрийг хүртэл зохион байгуулсан.

Чингэлтэй дүүргийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл “New story” хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, зөвлөлийн гишүүдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх болон Залуучуудын хөгжлийн зөвлөлүүдээр дамжуулан 2022 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцүүлж, “Чингэлтэй дүүргийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, Залуучуудын хөгжлийн зөвлөлийг идэвхжүүлэх” арга хэмжээг 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Арга хэмжээнд Засаг даргын Инновац, хөгжлийн асуудал хариуцсан орлогч дарга, Залуучуудын хөгжлийн зөвлөлийн тэргүүн, Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөлийн анхны тэргүүн, Монголын залуучуудын холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын асуудал хариуцсан мэргэжилтэн, Чингэлтэй дүүргийн Залуучуудын хөгжлийн зөвлөлийн гишүүд нийт 113 хүн оролцож Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, Залуучуудын хөгжлийн зөвлөлийн дүрэм, бүтэц зохион байгуулалт, зорилго, чиглэлийн танилцуулж Залуучуудын хөгжлийн зөвлөлийн туршлагыг хуваалцсан.

“Дэлхийн зөн” Олон Улсын байгууллагын Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн “МОНГОЛЧУУД МОНГОЛЧУУДДАА” арга хэмжээ зохион байгуулагдлаа. Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт хамрагдаж хүүхдүүдийн ирээдүйн сайн сайханд сайн дураар хөрөнгө оруулалт хийж байгаа “Хүүхэд ивээн тэтгэгч” бүрийг сурталчлах, олон нийтэд таниулах зорилготой арга хэмжээний үеэр хүрэлцэн ирсэн зочдод “Дэлхийн зөн” ОУБ-ын үйл ажиллагааны танилцуулга, РС хүүхдийн болон Ивээн тэтгэгчдийн сэтгэгдэлээс хүргэж, шинээр “Хүүхэд ивээн тэтгэгч” болох хүсэлтэй иргэдийг бүртгэх ажил зохион байгуулагдсан юм. Байгууллага хүүхэд ивээх хөтөлбөрт хамрагдаж сар бүр 1 хүүхдийг ивээн тэтгэж, мөнгөн хандив илгээн ажиллаж байна.



**World Vision**  
ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ

Корона вирус /Covid-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Чингэлтэй дүүргийн онцгой байдлын хэлтсээс гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн алба хаагч тус бүрд дархлаа дэмжих зорилгоор амны хаалт, витагрип, aminocomplex 250ml, уушги цэвэрлэх цай, витамин Д, Ogamín-G витамин зэргийг алба хаагч тус бүрт олгож дархлаа дэмжиж ажилласан.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв нь дүүргийн 160.000 гаруй иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэж ажилладаг ба өнөөдрийг хүртэл зориулалтын бус байранд үйл ажиллагаа явуулж байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан 3843-MON, 3844-MON (COL) дугаартай хөнгөлөлттэй зээл болон 0672-MON буцалтгүй тусламжийн гэрээний дагуу “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн хүрээнд тус дүүргийн нэгдсэн эмнэлэг барих төслийг 10 дугаар хороонд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГИЙН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



П.БАЯНБААТАР

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Н.ХАНГАЙ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Т.ТҮВШИНЖАРГАЛ